

БАТЛАН ХАМГААЛАХЫН ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ХҮРЭЭЛЭН

ХҮН АМ ЗҮЙН БАЙДАЛ, ТҮҮНИЙ БАТЛАН ХАМГААЛАХ БОДЛОГЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХЭД ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨЛӨЛ

Судалгааны ажлын тайлан
2018-2019

Төсөл гүйцэтгэгч байгууллага:	БХЭШХ-ийн Аюулгүй байдал, батлан хамгаалах судлалын төв
Судалгааны ажлын удирдагч:	Б.Эрдэнэчимэг /доктор, дэд профессор, дэд хурандаа/
Гүйцэтгэгч:	Б.Очирсүрэн /докторант, ахмад/ Д.Налжир /магистр/
Санхүүжүүлэгч байгууллага:	БХЯ-ны Шинжлэх ухаан, технологийн зөвлөл
Захиалагч байгууллага:	БХЯ-ны Шинжлэх ухаан, технологийн зөвлөл
Тайлан өмчлөгч:	БХЭШХ. Улаанбаатар-22 Индекс 210322. Улаанхуаран Утас: 453942

Улаанбаатар хот. 2019

АГУУЛГА

УДИРТГАЛ	3
НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. ХҮН АМ ЗҮЙ БОЛОН БАТЛАН ХАМГААЛАХ БОДЛОГЫН ҮНДЭС, УЯЛДАА ХОЛБОО	
1.1. Хүн ам зүйн бодлогын үндэс, түүний мөн чанар, агуулга.....	6
1.2. Батлан хамгаалах бодлогын мөн чанар, агуулга	15
1.3. Хүн ам зүй болон батлан хамгаалах бодлогын уялдаа холбоо	25
Дүгнэлт	33
ХОЁРДУГААР БҮЛЭГ. МОНГОЛ УЛСЫН ХҮН АМ ЗҮЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ, ТҮҮНИЙ БАТЛАН ХАМГААЛАХ БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТЭД ҮЗҮҮЛЖ БУЙ НӨЛӨӨЛЛИЙН ШИНЖИЛГЭЭ, УЯЛДАА ХОЛБООГ САЙЖРУУЛАХ АРГА ЗАМ	
2.1. Монгол Улсын хүн ам зүйн бодлого, үйл ажиллагааны өнөөгийн байдал....	35
2.2. Батлан хамгаалах бодлогын хэрэгжилтэд хүн ам зүйн өнөөгийн байдлын үзүүлж буй нөлөөллийн шинжилгээ, уялдаа холбоог сайжруулах арга зам	58
Дүгнэлт	74
ЗӨВЛӨМЖ.....	77
ТӨГСГӨЛ.....	80
ЭШЛЭЛ АВСАН, АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ, БҮТЭЭЛИЙН ЖАГСААЛТ	82

УДИРТГАЛ

Судалгааны ажлын хэрэгцээ, шаардлага:

Монгол Улсын Батлан хамгаалах бодлогын үндэс баримт бичгийн нийгмийн чиглэлд “Монгол Улсын хүний хөгжил нь батлан хамгаалах бодлогын нийгмийн чиглэлийн үндэс мөн¹. Бүс нутгийг хөгжүүлэх, хүн амыг амьдрах нөхцөл, суурьшлын бүс, дэд бүтэц бий болгох, боловсрол, соёл, иргэдийн эрүүл мэндийг хамгаалах эдийн засаг, нийгмийн цогц бодлогыг хэрэгжүүлнэ². Иргэдийн цэргийн алба хаах хүсэл сонирхол, эрмэлзлийг нэмэгдүүлэхэд чиглэсэн эдийн засаг, нийгмийн урамшуулалт бодлого боловсруулж хэрэгжүүлнэ³.” гэж заасан.

Монгол Улс өөрийгөө хамгаалахдаа *нэгдүгээрт*, бэлтгэгдсэн, тангараг өргөсөн байнгын бие бүрэлдэхүүнээр, *хоёрдугаарт*, бэлтгэл хүчнээр, *гуравдугаарт*, нийт иргэдийнхээ оролцоотойгоор аюулгүй байдлаа хамгаалах ёстой.

Батлан хамгаалах бодлогод үзүүлж буй хүн амын гол үзүүлэлт бол тухайн орны хүн амын өсөлт (түүний дотор эрэгтэй хүүхдийн төрөлтийн тоо), хүйсийн харьцаа, цэргийн насны залуучуудын эрүүл мэнд, боловсролын түвшин, хөдөлмөрийн чадавхтай хүн амын ажил эрхлэлтийн байдал, дайчилгааны бэлтгэл нөөцийн бүрэлдэхүүн, тэдгээрийн бэлтгэлжилт юм.

Иймээс иргэдийн нас хүйсийн харьцаа, боловсрол, эрүүл мэндэд тулгамдаж буй асуудлыг шинжлэх ухааны үндэслэлтэйгээр тодорхойлж, улс орны батлан хамгаалах бодлого, үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд тэдний оролцоо, хүсэл сонирхлыг нэмэгдүүлэх гаргалгааг гаргах нь судалгааны ажлын үндэслэл болж байна.

Судалгааны зорилго:

Хүн ам зүйн болон батлан хамгаалах бодлогын үндэс, уялдаа холбоог судалж, Монгол Улсын хүн ам зүйн өнөөгийн байдал, түүний батлан хамгаалах бодлогын хэрэгжилтэд үзүүлж буй нөлөөллийн шинжилгээн дээр тулгуурлан хүн ам зүйн болон батлан хамгаалах бодлогын нийгмийн арга хэмжээний уялдаа холбоог сайжруулах арга замын талаар зөвлөмж боловсруулахад оршино.

Судалгааны зорилтууд:

1. Хүн ам зүйн болон батлан хамгаалах бодлогын үндэс, уялдаа холбоог судлах;

¹ Монгол Улсын Батлан хамгаалах бодлогын үндэс. 5.1 дэх заалт. УИХ-ын 2015 оны 85 дугаар тогтоол.

² Мөн тэнд. 5.2 дахь заалт

³ Мөн тэнд 5.4 дэх заалт

2. Монгол Улсын хүн ам зүйн өнөөгийн байдал, түүний батлан хамгаалах бодлогын хэрэгжилтэд үзүүлж буй нөлөөлөлд шинжилгээ хийх;
3. Хүн ам зүйн болон батлан хамгаалах бодлогын нийгмийн арга хэмжээний уялдаа холбоог сайжруулах арга замыг тодорхойлох

Судалгааны объект:

Монгол Улсын хүн ам зүйн байдал

Судлах зүйл: Монгол Улсын хүн ам зүйн байдал, түүний батлан хамгаалах бодлогын хэрэгжилтэд үзүүлж буй нөлөөлөл

Судалгааны ажлын бүтэц, агуулга:

Судалгааны ажлын тайлан нь удиртгал, хоёр бүлэг, зургаан зүйл, төгсгөл, хавсралт, эшлэл авсан, ашигласан сурвалж, судалгааны материалын жагсаалтаас бүрдэж байна.

“Хүн ам зүй болон батлан хамгаалах бодлогын үндэс, уялдаа холбоо” хэмээх нэгдүгээр бүлэгт хүн ам зүйн бодлогын агуулга, түүнд нөлөөлөх тулгуур гурван бодлого, Монгол Улсын хүн ам зүйн бодлогын түүхэн хөгжил болон батлан хамгаалах бодлого, тогтолцоо, батлан хамгаалах бодлогын чиглэлүүдийг судалсны зэрэгцээ хүн ам зүй, батлан хамгаалах бодлого хоорондын уялдаа холбоог авч үзсэн.

“Монгол Улсын хүн ам зүйн өнөөгийн байдал, түүний батлан хамгаалах бодлогын хэрэгжилтэд үзүүлж буй нөлөөллийн шинжилгээ, уялдаа холбоог сайжруулах арга зам” хэмээх хоёрдугаар бүлэгт Монгол Улсын хүн ам зүйн бодлого, үйл ажиллагааны өнөөгийн байдал болон Батлан хамгаалах бодлогын хэрэгжилтэд хүн ам зүйн өнөөгийн байдлын үзүүлж буй нөлөөлөлд шинжилгээ хийж, хүн ам зүйн болон батлан хамгаалах бодлогын нийгмийн арга хэмжээний уялдаа холбоог сайжруулах арга замын талаарх зөвлөмжийг санал болгосон.

Судалгааны ажлын шинэлэг тал:

Хүн амын тоо, бүтэц, өөрчлөлтийг нийгмийн хүчин зүйлүүдтэй нь холбон судалж, цэргийн насны залуучуудын төдийгүй нийт хүн амыг эрүүлжүүлэх, тэдний боловсролын түвшинг дээшлүүлэх, бие бялдрын бэлтгэлжилтийг сайжруулах, хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх, цэргийн алба хаах хүсэл эрмэлзлэлийг өдөөхөд чиглэсэн нийгмийн арга хэмжээний санал, зөвлөмж дэвшүүлсэн нь шинэлэг тал юм.

Судалгааны ажлын ач холбогдол:

Судалгааны ажлын үр дүн, зөвлөмжийг амьдралд хэрэгжүүлэх боломжтойгоороо ач холбогдолтой болсон.

Төслийн багийн бүрэлдэхүүний судалгааны ажил гүйцэтгэсэн байдал:


Судалгааны ажлын нэгдүгээр бүлгийг: Д.Налжир (§1.1; §1.3), доктор, дэд профессор Б.Эрдэнэчимэг (§1.2; §1.3), хоёрдугаар бүлгийг: доктор, дэд профессор Б.Эрдэнэчимэг, Д.Налжир (§2.1; §2.2), докторант Б.Очирсүрэн (§2.1) нар бичив. Удиртгал, төгсгөл, зөвлөмж хэсгийг Б.Эрдэнэчимэг боловсруулав.

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. ХҮН АМ ЗҮЙ БОЛОН БАТЛАН ХАМГААЛАХ БОДЛОГЫН ҮНДЭС, УЯЛДАА ХОЛБОО

1.1. Хүн ам зүйн бодлогын үндэс, түүний мөн чанар, агуулга


Анх 1855 онд Бельги улсын судлаач Ачили Гююлард хүн ам зүй хэмээх үгийн гарлыг өөрийн туурвисан “Хүн ам зүйн статистикийн элементүүд буюу харьцуулалтын хүн ам зүй” гэсэн бүтээлдээ бичсэн.

“Хүн ам зүйн олон хэлийн толь бичиг⁴”-т “Хүн ам зүй” гэдэг нь хүн амын тоо хэмжээ, бүтэц хөгжлийг голчлон судалдаг шинжлэх ухаан юм гэж тодорхойлжээ. Өөрөөр хэлбэл, хүн ам зүйн шинжлэх ухаан нь хүн амын тоо, бүтэц өөрчлөлтийг болон түүний үр дүнг нийгэм, эдийн засгийн үзэгдлүүдийн өөрчлөлтүүдтэй холбон авч үзэж, учир утгыг нь тайлбарладаг юм⁵. Хүн ам зүйн шинжлэх ухаан нь дараах хоёр үндсэн салбараас бүрддэг.



1.1 дүгээр зураг. Хүн ам зүйн шинжлэх ухааны салбар ухаан

Хүн ам зүй нь математик тооцоолол, загвар боловсруулахтай холбоотой. Тухайлбал, хүн амын өсөлт, өөрчлөлтөнд нөлөөлөх гурван бүрэлдэхүүн хэсэг болох төрөлт, нас баралт, шилжих хөдөлгөөний үзүүлэлтүүдийн өөрчлөлтийг судалдаг. Өөрөөр хэлбэл, хүн ам зүйн үзэгдлүүдийн хоорондох тоон уялдааг бусад үзэгдлүүдтэй хамаарах талаас нь тайлбарлахаас илүү тодорхойлон өгүүлэх, задлан шинжлэх онцлогтой.




1.2 дугаар зураг. Хүн амын өсөлт, өөрчлөлтөд нөлөөлөх бүрэлдэхүүн хэсэг

⁴Этиен Ванде Валле. Хүн ам зүйн олон хэлийн толь бичиг. Бельги., 1982

⁵ Хүн ам зүйн байдал, батлан хамгаалах асуудал. Судалгааны ажлын тайлан. БХЭШХ. 2010

Харин хүн ам судлал нь хүн ам зүйн үзэгдлүүдийн уялдаа холбоог нийгэм, эдийн засаг, сэтгэл зүй, социологи, антропологи, газар зүй зэрэг бусад салбар шинжлэх ухаантай нягт уялдуулан авч судалдаг⁶. Өөрөөр хэлбэл, хүн амын төрөлт, нас баралт, шилжих хөдөлгөөнд гарч буй өөрчлөлтийг бусад нийгэм, эдийн засаг, соёлын хүчин зүйлстэй хэрхэн уялдаж байгааг судалдаг.



1.3 дугаар зураг. Хүн ам судлалын судлагдахуун

Хүн ам судлал нь хүн ам зүйн шинжээс гадна бусад шинжлэх ухааны шинжийг агуулдаг. Тиймээс ч эдийн засгийн хүн ам зүй, түүхийн хүн ам зүй, антропологийн хүн ам зүй гэх мэт ойлголтуудыг эрдэмтэд өргөн хэрэглэдэг байна. Тухайлбал, эдийн засгийн хүн ам зүйн асуудалд хүн амын өсөлт, өөрчлөлт ба ажил эрхлэлт, ядуурлын уялдаа хамаарал, түүнчлэн шилжих хөдөлгөөн болон хотжилтын асуудлуудыг судалдаг бол түүхийн хүн ам зүйн судлах асуудалд орчин үеийн бүртгэл, тооллогоос өмнөх үеийн улс орон, дэлхийн хүн амын өсөлт, өөрчлөлт, бүтэц мөн эдгээрт нөлөөлсөн нийгэм, эдийн засгийн хүчин зүйлийн талаарх судалгаа багтана. Мөн төрөлт, нас баралтын хэв маягийг тодорхойлох соёл, уламжлалын асуудлууд нь антропологийн хүн ам зүйн асуудлууд болно.

Хүн ам зүйн шинжлэх ухаан нь бусад шинжлэх ухаантай уялдаатай судлагддаг утгаараа хүн амын талаар баримтлах бодлогын шинжлэх ухааны үндэслэлийг тодорхойлдог “суурь” шинжлэх ухаан болохыг дэлхий нийтийн практик нотолж байна. Иймд хүн амын талаар төрөөс баримтлах бодлого, чиглэлийг боловсруулах,

⁶ Хүн ам зүйн байдал, батлан хамгаалах асуудал. Судалгааны ажлын тайлан. БХЭШХ. 2010

хэрэгжүүлэх, хууль эрх зүйн үндсийг тодорхойлоход хүн ам зүйн үзүүлэлтүүд, тэдгээрийн хувьсал, өөрчлөлтөд нөлөөлж буй нийгмийн эдийн засгийн болон байгаль орчин зэрэг хүчин зүйлийг нарийвчлан судлах асуудал нэн чухал. Нөгөө талаар хүн ам зүйн асуудлаар хүн амын дунд сургалт, ухуулга сурталчилгааны ажлыг өргөн явуулахын зэрэгцээ иргэдэд хүн ам зүйн мэдлэг олгох явдал нь төрийн бодлогыг хэрэгжүүлэх угтвар нөхцлийг бүрдүүлэхэд чухал нөлөөтэй арга хэмжээ юм.

Хүн амын нас, хүйсийн байдал нь нийгэм, эдийн засаг, соёлын асуудлуудтай нягт холбоотой учраас түүнийг шинжлэх зайлшгүй шаардлагатай байдаг. Тухайлбал, сургуульд хамрагдалт, ажиллах хүчний нөөц, гэрлэх, төрөх, шилжих гэх мэт. Түүнчлэн зарим нэр төрлийн бүтээгдэхүүн, үйлчилгээний хэрэглээ нь нас хүйсийн бүтцээс хамааран өөр өөр байдаг. Нас хүйсийн бүтцийн мэдээлэл нь нийгмийн чиг хандлагыг тайлбарлах, зах зээлийг тодорхойлох, цэрэг татлага зэрэгт ирээдүйн төлөвлөлт хийхэд чухал ач холбогдолтой.

Хүн амын бүтэц нь хүн амын өсөлт, өөрчлөлтийн бүрэлдэхүүн хэсгүүд болох төрөлт, нас баралт, шилжих хөдөлгөөнөөс хамаардаг⁷. Төрөлт, нас баралтын өндөр түвшин нь хүн ам залуужих үндэс болдог. Энэ нь хүүхэд, залуучуудын эзлэх хувийн жин өндөр байна гэсэн үг юм. Төрөлт, нас баралт буурахын хэрээр хүн ам насжиж, дунд болон ахимаг насны хүмүүсийн эзлэх хувийн жин өсдөг ажээ. Харин шилжилт хөдөлгөөн нэмэгдсэнээр залуучуудын хувийн жин нэмэгдэхэд хүрдэг байна. Түүнчлэн дайн, улс төрийн тогтворгүй байдал, эдийн засгийн хямрал гэх мэт гэнэтийн үзэгдлийн үр дүнд зарим насны бүлгийн хүмүүсийн хувь багасна. Үүнийг тухайн үеийн төрөлтийн бууралт, нас баралтын өсөлт зэргээр тайлбарладаг байна.

Харин өдгөө хүн амын насны бүтцэд өөрчлөлт орж, хөдөлмөрийн насны хүн амын тоо хамгийн их буюу “хүн амын цонх” хэмээн нэрлэгддэг хамгийн тааламжтай үе тохиож, улмаар энэ нь 2025-2030 он хүртэл үргэлжлэх төлөвтэй байгаа нь манай орны хөгжилд ихээхэн ач холбогдолтой болж байна.

Хүн ам зүйн бодлогод нөлөөлөх гол хүчин зүйл болох дараах тулгуур 3 бодлогыг авч үзье. Үүнд:

Нэгд, Төрөлтийн талаарх бодлого⁸: Хүн амын төрөлтийн талаарх бодлого нь хүн амын төрөлтийг бүхий л талаар урамшуулах бодлого, төрөлтийг бууруулах бодлого гэсэн хоёр үндсэн хэлбэртэй байдаг бөгөөд хүн амын өсөлт, бүтцийн өөрчлөлтийн бодлоготой нягт уялдаатай юм. Хүн амын төрөлтийг урамшуулах бодлогыг тухайн орны хүн амын тоо цөөн, өсөлтийн хурд хэт удаан үед авч

⁷ Б.Наранчимэг. Хүн ам зүй ба хүн ам судлал. МУИС., 2011

⁸ https://www.un.org/en/development/desa/population/publications/pdf/popfacts/PopFacts_2017-10.pdf

хэрэгжүүлдэг бол төрөлтийг бууруулах бодлогыг тухайн орны хүн ам хэт өсч байгаа үед авч хэрэгжүүлдэг байна. Гэхдээ хүн амын хэт өсөлтөд хүн ам, эдийн засаг, нийгмийн өөрчлөлтүүдийн харилцан уялдаа чухал нөлөөтэй байдгийг анхаарах хэрэгтэй юм.

Хүн амын төрөлтийн талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээг дөрвөн үндсэн хэлбэрээр ангилдаг⁹. Үүнд:

1. Гэр бүлийн талаар авч явуулах арга хэмжээ (гэр бүлд үзүүлэх тэтгэмжийн хөтөлбөр, орлогын татварын асуудал, эхчүүдэд үзүүлэх төрөл бүрийн тусламж гэх мэт)

2. Нийгмийн асуудлын талаарх арга хэмжээ (бүх нийтийн зайлшгүй боловсрол, хүүхдийн хөдөлмөр эрхлэлтийн талаарх хууль, нийгмийн хангамжийн хөтөлбөр гэх мэт)

3. Жирэмслэлтээс урьдчилан сэргийлэх арга хэрэгсэл, үр хөндөлтийг зохицуулах хуулиуд

4. Гэрлэлт, цуцлалтын талаарх хуулиуд (гэр бүлийн хэлбэр, гэрлэх нас, гэр бүл цуцлалт, дахин гэр бүл болох асуудлуудыг хуульчлан тогтоох гэх мэт)

Эхний арга хэмжээ нь төрөлтийг урамшуулах бодлогыг хэрэгжүүлэхэд голчлон чиглэгддэг бол удаах бүлэг арга хэмжээ нь төрөлтийг хязгаарлах бодлого хэрэгжүүлэх үед шууд бусаар нөлөөлнө гэж үздэг байна. Сүүлчийн 2 бүлэг арга хэмжээг ямар арга замаар хэрэгжүүлэхээс шалтгаалж төрөлтийг урамшуулах буюу төрөлтийг хязгаарлах бодлогын алинд ч үйлчилж болох юм.

Харин гэр бүл төлөвлөлт нь хосууд төрүүлэх хүүхдийнхээ тоог болон төрөлт хоорондынхоо зайг зохицуулах арга хэмжээний цогц юм. Гэр бүл төлөвлөлтийн асуудал нь зөвхөн жирэмслэлтээс урьдчилан сэргийлэх арга хэрэгслийг практикт хэрэгжүүлэх асуудлаар хязгаарлагдахгүй бөгөөд энэ нь нөхөн үржихүйн стратегийн асуудал юм.

Олонхи улс оронд гэр бүл төлөвлөлтийг зөвхөн төрөлтийг хязгаарлах зорилгоор бус хосуудад ам бүлийнхээ тоог өөрсдөө зохицуулах өргөн эрхийг олгох үүднээс нэвтрүүлж байна. Мөн эх, нялхсын эрүүл мэндийг хамгаалах гол чухал хэрэгсэл болдог байна. Ийм учраас Монголд гэр бүл төлөвлөлтийг гэр бүлийн хөгжил гэсэн утгаар авч хэрэгжүүлэх нь илүү зохимжтой юм.

Хоёрт, Нас баралтыг бууруулах талаарх бодлого¹⁰: Нас баралтыг бууруулах талаарх бодлого нь хүн амын эрүүл мэндийг хамгаалах бодлоготой нягт

⁹ https://www.un.org/en/development/desa/population/publications/pdf/popfacts/PopFacts_2017-10.pdf

уялдаатай байдаг. Хүн амын эрүүл мэндийн байдлыг сайжруулснаар дундаж наслалтыг уртасгахад нөлөөлөх учир нас баралтыг бууруулах тусгайлсан бодлого улс болгонд байдаггүй. Харин цөөн оронд хүн ам зүйн бусад үзэгдлийн өөрчлөлттэй уялдуулан нас баралтыг бууруулах шууд бус арга хэмжээг хэрэгжүүлэх программыг нэвтрүүлэн ашигладаг байна.

Гуравт, Хүн амын байршил, нутагшилтын талаарх бодлого¹¹: Олон оронд хүн амын байршил, нутагшилтын талаарх бодлогыг авч хэрэгжүүлж байна. Энэ бодлогын зорилго нь хүн амыг тухайн орны газар нутагт жигд байршуулж, хүн амын зохистой байршлын үндсэн дээр нийгэм, эдийн засгийн чухал зорилтуудыг амжилттай шийдвэрлэх явдал юм. Улс орны хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэх үед хүн амыг нүүлгэн шилжүүлэх, байршуулахад зарим нэгэн зөрчил үүсдэг. Энэ зөрчлийг хүн амын байршил, нутагшилтын бодлогыг зөв хэрэгжүүлснээр шийдвэрлэж болох талтай. Тухайн улс орны хэмжээнд нутаг дэвсгэрийн хувьд ялгавартайгаар төрөлт, нас баралтын бодлого хэрэгжүүлэх боломжгүй учраас хүн амын байршил, нутагшилтын бодлогын гол цөм нь шилжих хөдөлгөөн болдог.

Шилжих хөдөлгөөний бодлого нь шууд ба шууд бус хэлбэртэй байдаг. Шилжих хөдөлгөөний шууд бодлого нь шилжин суурьшигчдад төрөл бүрийн мөнгөн урамшуулал олгох, тээврийн хөнгөлөлт үзүүлэх, мэдээллээр шуурхай хангах гэх зэргээр илэрдэг. Шилжих хөдөлгөөний шууд бус бодлого нь шилжин суурьшуулах газар нутагт анхаарал тавьж, эдийн засгийн дэд бүтцийг эрчимтэй хөгжүүлэх байдлаар илэрнэ.

Шилжих хөдөлгөөний бодлого нь авч хэрэгжүүлж байгаа арга замын хувьд эдийн засгийн болон засаг захиргааны шинж чанартай байдаг. Эдийн засгийн шинж чанартай бодлого нь эдийн засгийн төрөл бүрийн урамшууллаар шилжин суурьшигчдыг татах, эсвэл төлбөр, татварын хэлбэрээр шилжин суурших явдлыг хориглох зэргээр илэрдэг. Засаг захиргааны шинж чанартай бодлого нь оршин суух газар нутаг, нүүн шилжих явдлыг засаг захиргааны шийдвэрээр зохицуулах явдлаар илэрдэг байна.

Ер нь төрөөс хүн ам зүйн талаар авч хэрэгжүүлэх бодлого, үйл ажиллагаа нь тодорхой судалгаа, баримтанд тулгуурлаж байж илүү үр дүнгээ өгнө.

Бодлого гэдэг нь тавигдсан тодорхой зорилго, зорилтууд, түүнд хүрэх арга замыг тодорхойлсон иж бүрэн цогц ойлголт юм¹². Хүн амын бодлогод юуг хамруулах

¹⁰ Засгийн газрын 2016 оны 261 дүгээр тогтоол “Төрөөс хүн амын хөгжлийн талаар баримтлах бодлого”

¹¹ Н. Батжаргал, “Эдийн засгийн хөгжил ба хүн амын өсөлт шилжилт хөдөлгөөн”, УБ. 2017

¹² Я.Бямбасүрэн, П.Доржсүрэн. “Төрийн бодлого”. УБ., 2006 он

талаар хэдийгээр санал маргаантай байгаа боловч ерөнхий чиг хандлага тодорхойлогдсон юм.

Хүн амын бодлогыг явцуу ба өргөн утгаар авч үзэж болно. Явцуу утгаар тодорхойлох үед хүн амын тоо, бүтэц, газар нутгийн тархалт, байршилтыг зохицуулах арга хэмжээний иж бүрэн цогцолборыг авч үздэг бол өргөн утгаар тодорхойлох үед дээрхээс гадна хүн ам зүйн үзэгдэл, үйл явцад нөлөөлөх эдийн засаг, нийгмийн байдлыг хамруулдаг байна. Ер нь хүн амын бодлогыг олонхи оронд явцуу утгаар авч үзэж хэрэгжүүлж байна.

Хүн амын бодлого, хүн амын хөгжил, хүний хөгжил бол ихээхэн ялгаатай асуудал юм.

Хүн амын бодлого нь тухайн улсын хүн ам зүйн(төрөлт, нас баралт, гадаад дотоод шилжих хөдөлгөөн) хувьд тулгараад байгаа нөхцөл байдал, тэдгээрийн нийгэм, эдийн засгийн байдал хоорондын харилцаа холбоон дээр тулгуурлана. Бодлого нь тодорхой хугацаанд шийдвэл зохих хүн амын тулгамдсан асуудлуудыг янз бүрийн бодлогын арга хэмжээний нөлөөгөөр өөрчлөх/шийдэх оролдлогуудыг тодорхойлдог. Хүн амын бодлогын нийтлэг зорилго нийгэм эдийн засгийн хөгжил, хүн амын төлөв байдал, хандлага, хэв маягийн өөрчлөлтийн дүнд хүмүүсийн сайн сайхан байдал буюу амьдралын чанарыг дээшлүүлэх явдал юм.

Хүний хөгжил нь хүн бодит эрх чөлөөгөө эдлэх боломжийг бий болгох, өргөжүүлэх тухай ойлголт бөгөөд хүний хөгжлийн индексээр дэлхийн хэмжээнд тооцдог. Энэ нь улс орнуудын хүний хөгжлийг цөөхөн хэдэн, гэхдээ гол үзүүлэлт /орлого, боловсрол, эрүүл мэнд/-ээр гаргаж, харьцуулах боломжийг олгоно.

Харин хүн ам зүйн хөгжил XIX зууны сүүл үеийг хүртэл хүн амын нас баралтад дүн шинжилгээ хийх болон тоо баримт гаргахад чиглэгдэж ирсэн түүхтэй аж.

Хүн ам бол улс орны оршин тогтнох, нийгмийн хөгжил, өөрчлөлтийн гол үндэс, төлөвлөлт, удирдлага, хөгжлийн асуудлын чухал бүрэлдэхүүн болдог учраас аливаа улс орон, ялангуяа их гүрнүүд хүн амын бодлогыг төрийн бодлогынхоо эн тэргүүнд тавьдаг байна.

Хамгийн эртний хүн амын тооллого нь одоогоос 10000 гаруй жилийн өмнө хийгдсэн бөгөөд үүнээс өмнө 5-10 сая хүн амьдарч байжээ¹³ гэсэн тоо баримт тэмдэглэгдэж үлдсэн байдаг.

Монгол Улсын хүн амын бодлого

Монгол орны газар нутагт анхны төрт улс тогтсон үе буюу одоогоос 2000 гаруй жилийн өмнөөс хүн амаа бүртгэх, хүн амын бодлого баримтлах явдал эхлэлээ

¹³ Өвөрхангай аймгийн хүн ам зүйн үзүүлэлтүүдийн өнөөгийн байдал, 2012 он, т. 4.

тавьжээ. Түүхийн энэ үеэс барьж ирсэн бодлого **XIII зуун, Чингис хааны үеэс** улам боловсронгуй болж, хүн амын албан татвар авах, цэргийн алба хаалгах, нутаг бэлчээр хуваарилах, газар нутгийг бүрэн ашиглах, эзгүйрсэн нутгуудад хүн амыг суурьшуулах, өртөө унааны суурингуудыг байгуулах зэрэг зорилгын үүднээс хүн амаа аравт, зуут, мянгат, түмтийн зохион байгуулалтанд оруулж бүртгэх тогтолцоо бий болгосон бөгөөд нийслэл Хархорум хотыг байгуулснаар хүн ам зүйн тодорхой бодлого явагдаж байсан.

1251 онд Мөнх хаан болоод Их Монгол Улсын төрийг орон нутагт захирагч нарыг томилж, хатуу захиргаа тогтоон, улсын сан хөмрөг, эдийн засгийн орлогыг нэмэгдүүлэхтэй холбогдуулан улс орон даяар хүн амын бүртгэл тооллогыг шинээр явуулсан байна¹⁴.

Дэлхий нийтийн хүн ам зүйн түүхэн зүй тогтолын дагуу хөгжлийн ерөнхий түвшнээс хамааран энэ үед хүн амын ердийн өсөлт тун доогуур байсан ба ялангуяа XII-XIV зууны бараг дэлхийн талыг хамарсан их байлдан дагуулалтын үрээр олон тооны хүн ам бусад улс орнуудад суурьшин, аажмаар тухайн үндэстэнд ууссан нь Монголын хүн амын өсөлтийг бууруулсан нэг хүчин зүйл болсон байна.

Их гүрний доройтлыг даган XV зууны эхэн үеэс хүн амын цэгцтэй бодлого суларч, **XVII зууны сүүлчээр** Монгол улс Манжийн эрхшээлд орж, төрийн уламжлалт бодлого алдуурсан.

XVII зуунд Манж Хятадын эрх баригчид засаг захиргааны хуучин тогтолцоог өөрчлөн хошуудын хэлбэрт оруулснаар хүн амын байршилт, нутагшилтын зохистой байдал алдагдаж, шарын шашин дэлгэрүүлснээр XVIII зууны эцэс гэхэд насанд хүрсэн эрэгтэйчүүдийн 1/3 нь лам болж, гэр бүл болоогүй эмэгтэйчүүдийн хувийн жин тэр хэмжээгээр нэмэгдэн, өрхийн бүтэц гажуудалд орж төрөлт туйлын доогуур түвшинд тогтож, хүн амын өсөлт үндсэндээ зогссон байв. Мөн өвчлөл хэт нэмэгдэж, нас баралтын түвшин ихээхэн өндөр байжээ. Дээрх түүхэн үйл явцаас хамааран **XX зууны эхэн** хүртэлх 300 гаруй жилд Монголын хүн ам хоёр дахин багасаж, **1918 онд** гадаад иргэдийг эс тооцвол 647,5 мянга хүн бүртгэгджээ¹⁵.

Монгол Улсын Засгийн газар хүн ам, өрхийн тоог тогтоох зорилгоор 1918 онд хүн амын тооллого явуулсан бөгөөд эл тооллогыг Монгол Улсад явуулсан хүн амын анхны тооллого гэж албан ёсоор тооцдог. 1918 онд Оросын эрдэмтэн И.М.Майский шинжилгээний анги Монгол Улсын хүн амыг тоолж 647.5 мянга хүн амтай гэж үзсэн (Монголчууд 542.5 мянга, хятадууд 100 мянга, оросууд 5000 гэж тооцож, нийт хүн

¹⁴ Ш.Насанбат. "Монголын түүхэнд тодорсон 33 цуут жанжин". УБ., 2018 он,.т. 65

¹⁵ Иргэний бүртгэлийн түүхэн тойм. <http://burtgel.gov.mn/index.php/about/history/80-civil>

амын тоо 647.5 мянга) И.М.Майскийн тооллогонд Монгол Улсад худалдаа наймаа, ажил эрхэлдэг хятад, орос хүмүүсийг оруулсан бол Ховдын хязгаар, Хөвсгөл нуурын урианхай, Богдын Их шавийн нутаг дэвсгэрт амьдарч буй хүмүүсийн тоо ороогүй аж. Оросын эрдэмтэн Н. Прежевальский ХХ зууны эхээр "Байдал энэ хэвээрээ үргэлжлэх юм бол тавин жилийн дараа энэ нутагт Монгол хүн үлдэхгүй харин миний адуу л үлдэх бололтой"¹⁶ гэж бичсэн байна.

1921 оны Ардын хувьсгалын дараах анхны тооллогоор 738,2 мянган хүнтэй байсан бол **1935 онд** 90,7 мянган хүнээр өссөн буюу жилийн дундаж өсөлт 0,8 хувь байжээ. **1944 онд** дайны жилүүдэд хийсэн тооллогоор 754,2 мянга, **1956 оны** олон улсын аргачлалыг хэрэглэн явуулсан тооллогоор 845,5 мянган хүнтэй болж¹⁷, нийт хүн амын 21,6 хувь нь хотод, 78,4 хувь нь хөдөө амьдарч байсан бөгөөд 12 жилийн дотор 86.0 мянган хүнээр нэмэгдсэн нь эерэг үзүүлт бөгөөд дайн дуусаж, улс орон тайван замаар нийгэм, эдийн засаг, эрүүл мэндийг хөгжүүлэх таатай нөхцөл бүрэлдсэн байна.

1963 онд анх удаа 1017.1 мянган хүнтэй болж, жилийн дундаж өсөлт 2.7 хувьд хүрсэн бол **1969 онд** 1197.6 мянган хүн амтай болж, жилийн дундаж өсөлт 2.8 хувь болжээ. **1979 онд** 1595.0 мянга болсон нь Монгол Улсын хүн амын жилийн дундаж өсөлт хамгийн өндөр байсан жил юм. **1989 оны** тооллогоор 2044.0 мянган хүн тоологдсон. Энэ үед жилийн дундаж өсөлт 2.5 хувьтай байсан. **2000 онд** Монгол Улсын 8 дахь удаагийн хүн амын тооллого явагдаж 2373.5 мянга болж, жилийн дундаж өсөлт 1.4 хувьтай болж буурсан. **2010 оны** тооллогоор 2754.6 мянга¹⁸ байсан бол **2015 оны** 1 дүгээр сарын 24-нд Монгол Улсын гурван сая дахь иргэн мэндэлсэн.

Социализмын 70 жилд Монгол Улсын хүн ам гурав дахин өссөн нь томоохон амжилт юм.

Энэ үед улс хүчирхэгжихийн үндэс болсон хүн амын бодит өсөлтийг БНМАУ-ын Сайд нарын зөвлөлийн дарга Ю.Цэдэнбалын "Хүүхэд төрүүлж эх болох нь манай эмэгтэйчүүдийн нийгмийн өмнө хүлээсэн үүрэг, тэдний баяр баясгалан, аз жаргалын хэрэг мөн. Хүүхдийг хүмүүжүүлэх, тэдний эрүүл мэндийг хамгаалах ариун үйл хэргээс нэг ч байгууллага, нэг ч хүн хол хөндий байх ёсгүй"¹⁹ хэмээн хэлсэн үгийг төрийн бодлогын хэмжээнд авч үзэж, хэрэгжүүлэх, "Улсын хүн амын цэвэр өсөлтийг цаашид эрс нэмэгдүүлэн, нялх хүүхдийн эндэгдэлийг эрс багасгах" явдлыг

¹⁶ Хүн ам зүйн бодлогогүй Монгол Улс "Өвөг дээдсийн бодлогоос" Хөх толбо. 2013 он

¹⁷ ХХ зуунд Монгол улсын хүн ам өсөлт. <https://mongoltoli.mn/history/h/712>

¹⁸ Мөн тэнд

¹⁹ "Хүн ам зүйн бодлого" төгсгөл, 6/6-р хэсэг 2017 он т.3

Эрүүлийг хамгаалах ажлын үндсэн зорилт болгож, амаржих газрууд, сум-нэгдэл, суурин газруудын төрөх салбарууд, хүүхдийн эмч, эмнэлэгүүд нэмэгдүүлж, эх нялхсыг хамгаалах эрдэм шинжилгээний хүрээлэнг барьж байгуулан, эх нялхсыг хамгаалах ажлыг бүх нийтийн үйл хэрэг болгосон, бүх хүүхдийн Өсөлтийн түүхийн дэвтэр, байнгын хяналт, гэрээр өгөх зөвлөгөө, эмэгтэйчүүдийн жилд хоёроос доошгүй удаа урьдчилан сэргийлэх үзлэг явуулж, 1971-1975 онд яслийн 28 барилга ашиглалтанд оруулж байсан зэргээс харахад тэр үеийн бүтээн байгуулалт Монголын хүн амыг өсгөхийн төлөө чиглэж байсан нь харагдаж байна.

Монгол Улс дэвшүүлсэн зорилтдоо хүрэхийн тулд юуны түрүүнд хүнээ хөгжүүлэх, хүн амын аж төрөх, эрүүл энх байж, урт наслах нийгэм, эдийн засгийн нөхцлийг бүрдүүлэх асуудалд ихээхэн анхаарч, үүнд төр засгийн бодлого үйл ажиллагаа чиглэгдэж, үйл хэрэг болж, хэрэгжиж байх учиртай.

Энэ үүднээс Монгол Улсын төр засгаас хүн ам зүйн болон хүн амын хөгжилтэй холбоотой хууль эрх зүйн баримт бичгүүдийг боловсруулж, батлан хэрэгжүүлж байсан. Тухайлбал, 1991 онд БНМАУ-ын Ерөнхийлөгчийн 115 дугаар зарлигаар “БНМАУ-ын хүн ам зүйн талаар баримтлах чиглэл”²⁰-ийг батлан гаргасан байна.

Уг баримт бичигт “Хүн амын нөхөн үржихүйтэй нийгмийн үйлдвэрлэлийг уялдуулан зохицуулах, хүн амын жилийн дундаж өсөлтийн хэмжээг бууруулахгүй байх, хүн амын бүтэц, харьцааг зөв тогтоох, монгол хүний удмын санг цэвэр ариунаар хадгалах, гэр бүл бүрдэн бэхжих нөхцлийг бүрдүүлэх” явдлыг БНМАУ-ын төрөөс Хүн амын талаар баримтлах бодлого болгон баталгаажуулж, энэхүү бодлогын үндсэн агуулгыг хүн амын нөхөн үржихүй, удамшил зүйд нийцүүлэн хүн амын аж төрөх нийгэм, эдийн засаг, шинжлэх ухаан, соёлын болон байгаль орчин, сэтгэл зүйн таатай нөхцөлийг бүрэлдүүлэх үйл явцыг залж зохицуулахад оршино.” хэмээн тодорхойлсон байна.

Уг эрх зүйн баримт бичигт Хүн ам зүйн талаар баримтлах төрийн бодлогыг хэрэгжүүлэх үндсэн чиглэлийг:

- Хүн амын нөхөн үржихүйн үндэс болсон хүн амын төрөлтийг эмэгтэйчүүдийн биологийн зохистой чадавхи, сэтгэл зүй, эх, нялхсын эрүүл мэндтэй нягт уялдаатай байлгахыг чухалчлах;

- Хүн төрж бойжих, өсөж хүмүүжих анхны гол орчин нөхцөл гэр бүл гэж үзэж гэрлэгчдийн гэрлэх нас, бие бялдар, эрүүл мэнд, сэтгэл зүй, соёл, хөдөлмөр, ахуй нөхцөлтэй уялдуулан гэр бүлийн зохистой бодлого явуулах;

²⁰“БНМАУ-ын хүн ам зүйн талаар баримтлах чиглэл”.БНМАУ-ын Ерөнхийлөгчийн 115 дугаар зарлиг

- Хүний удмын санг цэвэр ариун байлгахыг эрхэмд үзэх, цус ойртохоос сэргийлэх гол хэрэглүүр “Угийн бичиг”-ийг айл өрх бүрт хөтлүүлж, хэвшүүлэх, иргэдийн овгийг сэргээн тогтоох явдлыг нэн чухалд тооцох;

- Удамшлын өвчин, бие эрхтний согог, тахир дутуугаас сэргийлэх зорилгоор гэр бүл-эмнэлэг-удамшлын зөвлөлгөө өгөх газруудыг хот, аймгийн түвшинд зохион байгуулах, ургийн элдэв өвчнийг эхийн хэвлийд оношлон сэргийлэх удамшил зүй, биохимийн орчин үеийн шинжилгээний аргыг өргөн хэрэглэх;

- Удамшлын болон сэтгэл мэдрэлийн эмгэг өвчтэй, оюун ухааны хомсдолтой эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийг жирэмслэлтээс сэргийлэх төгс арга хэмжээ авна.Түүнчлэн олон хүүхэд төрүүлсэн эхчүүд хүсвэл ийм арга хэмжээ авахыг зөвшөөрөх. Тахир дутуу, оюун ухааны хомсдолтой, эрхтний согогтой хүмүүст үзүүлэх нийгмийн халамж, анхаарлыг улам өргөтгөх;

- Зүй бус шалтгаанаар нас барах, ялангуяа эх нялхсын өвчлөл, эндэгдлийг эрс бууруулах, хүн амын наслалт, ажиллах чадварыг уртасгах эдийн засаг, нийгэм, соёл, сэтгэл зүйн олон талт арга хэмжээг төр, засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгаж хэрэгжүүлэх;

“Манай орны улс төр, нийгэм, эдийн засгийн шинэ тогтолцоо, үйлдвэрлэх хүчний хөгжил, байршил, засаг захиргаа, нутаг дэвсгэрийн зохион байгуулалт, хүн амын боловсрол, мэргэжил, ажилах хүчний нөөцтэй уялдаатайгаар хүн амын дотоод, гадаад хөдөлгөөнийг зохицуулах, нэн ялангуяа цөөхүүл хүн амыг хөдөлгөөн харьцаанд оруулахад онцлон анхаарна. Хотоос хөдөөд, аймаг хооронд, сумаас суманд шилжих хөдөлгөөнийг чөлөөтэй болгох;

- Хүн амын зохистой нөхөн үржих, эрүүл энх байх, урт удаан наслах, нийгэм, эдийн засгийн нөхцөлийг бүрдүүлэх явдал төр, засаг, улс, хоршоолол, олон нийтийн байгууллага, аж ахуйн газар, нэгж, иргэн бүрийн нэн тэргүүний журамт үүрэг гэж үзнэ. Үүнтэй холбоотойгоор ойрын үед “Хүн амын байршил, хөдөлгөөн”, “Эрүүл мэнд” “Хүмүүжил боловсрол, мэргэжил”, “Хөдөлмөрийн нөхцөл, хөдөлмөр эрхлэлт”, “Хүнс, тэжээл, ахуй хангамж”, “Хүн ба орчин”, “Монгол хүний нөхөн үржихүйн зохистой загвар” зэрэг бага хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлэх хэмээн тодорхойлсон байна.

1.2. Батлан хамгаалах бодлогын мөн чанар, агуулга

Дэлхийн болон бүс нутгийн аюулгүй байдлын орчны өөрчлөлтийн чиг хандлага нь улс орон бүрийг аюулгүй байдал, батлан хамгаалах бодлого, үйл ажиллагаагаа эргэн харж, шинэчилж байхыг зүй ёсоор шаардаж байна.

Монгол Улс гадаад орчны хурдацтай өөрчлөлт, дэлхийн улс орнуудын баримталж буй нийтлэг чиг хандлагыг харгалзан батлан хамгаалах бодлого, үйл ажиллагаандаа зарчмын өөрчлөлт оруулан, бодлогын анхны баримт бичгээ хоёр ч удаа өөрчилсөн. Тухайлбал,

УИХ-аас 1994 онд 56 дугаар тогтоолоор “Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”, “Монгол Улсын Гадаад бодлогын үзэл баримтлал”, “Монгол Улсын цэргийн номлолын үндэс” гэсэн харилцан уялдаа бүхий гурван баримт бичгийг батлан гаргасан нь хүйтэн дайны үе төгссөний дараах Монгол Улсын тусгаар тогтнолыг бэхжүүлэх талаар хийсэн анхны алхам болж, аюулгүй байдал, батлан хамгаалах бодлогын эрх зүйн үндсийг тавьсан юм.

4 жилийн дараа УИХ-аас 1998 оны 56 дугаар тогтоолоор “Монгол Улсын төрийн цэргийн бодлогын үндэс” баримт бичгийг баталж гаргасан. Энэхүү баримт бичигт зэвсэгт түрэмгийллийн аюулаас сэрэмжлэх төрийн бодлогын болон улс орныг батлан хамгаалахад хүн ам, эдийн засаг, нутаг дэвсгэрээ бэлтгэх, зэвсэгт хүчнийг бэлтгэх чиглэлүүдийг тодорхойлсон байна.

Цаг үеийн нөхцөл байдал, үндэсний аюулгүй байдлын тулгуур баримт бичгүүд шинэчлэгдсэнтэй уялдуулан 2015 онд Монгол Улсын Их Хурлын 85 дугаар тогтоолоор батлан хамгаалах бодлогын баримт бичгээ шинэчлэн “Монгол Улсын батлан хамгаалах бодлогын үндэс” баримт бичгийг батлуулан мөрдөж байна.

Улс орны үндэсний аюулгүй байдлын системийн хувьд аливаа бодлого, эрх зүйн зохицуулалтыг боловсруулах арга зүй нь *нэгдүгээрт*, үндсэн суурь нь “Үндсэн хууль”-ийн заалтууд, байх, *хоёрдугаарт*, Үндсэн хуулийн заалтуудын утга агуулгад тулгуурлан боловсруулагдсан “Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”, байх, *гуравдугаарт*, Үндсэн хууль болон Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын утга агуулгатай нийцүүлэн боловсруулагдсан “Гадаад бодлогын үзэл баримтлал” байх, *дөрөвдүгээрт*, Үндсэн хууль болон Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, Гадаад бодлогын үзэл баримтлалын утга агуулгатай нийцүүлэн боловсруулагдсан “Төрөөс батлан хамгаалах талаар баримтлах бодлого” байх, *тавдугаарт*, дээрх дөрвөн суурь баримт бичгүүдийн агуулгад тулгуурлан бусад бүх салбаруудын бодлого, хууль, эрх зүйн баримт бичиг боловсруулагдах зүй тогтолд тулгуурлана²¹.

Дээрх зүй тогтлын дагуу 2010 онд Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал шинэчлэгдэн батлагдсан тул түүнд тулгуурлан 2011 онд Гадаад бодлогын үзэл

²¹ О.Үржин. “Аюулгүй байдлын онол, арга зүйн асуудалд”. Аюулгүй байдлын онол, практикийн тулгамдсан асуудал” сэдэвт эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл. 2016 он.

баримтлалыг шинэчлэн баталсан. Төрийн бодлогын энэ 2 тулгуур баримт бичиг шинэчлэгдэн батлагдсан нь Монгол Улсын батлан хамгаалах бодлогын үндэс баримт бичгийг гаргах хэрэгцээ, шаардлагыг бий болгосон.

Монгол Улсын батлан хамгаалах бодлогын үндэс баримт бичигт “Батлан хамгаалах үйл ажиллагаа нь үндэсний аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааны бүрэлдэхүүн хэсэг бөгөөд Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал, хил хязгаарын халдашгүй дархан байдлыг хангах, хамгаалах зорилго бүхий улс төр, эдийн засаг, нийгэм, эрх зүй, цэргийн арга хэмжээ, тэдгээрийг хэрэгжүүлэх нэгдмэл удирдлага, зохион байгуулалт, зохицуулалтын цогц мөн”²² гэж батлан хамгаалах үйл ажиллагааг өргөн утгаар нь тодорхойлсон юм.

Энэхүү тодорхойлолтоос харахад батлан хамгаалах үйл ажиллагаа нь улс, нийгмийн бүхий л хүрээг хамарч байгаа бөгөөд төрийн батлан хамгаалах бодлого нь нэгдмэл удирдлагатай, зохион байгуулалттай арга хэмжээгээр хэрэгжих нь тодорхой байна. Өөрөөр хэлбэл, улс орны батлан хамгаалах чадавхыг бэхжүүлэх нь бүх нийтийн үйл хэрэг болох тул эрх зүйн зохицуулалт байх ёстой. Эрх зүйн зохицуулалт нь Батлан хамгаалах бодлогын үндэс баримт бичгийн холбогдох заалтууд бусад салбарын эрх зүйн баримт бичгүүдэд тусгагдан баталгаажиж хэрэгжих явдал болно.

Ер нь бодлого бол шийдвэр буюу үйлдлийн хөтөч болсон үйл ажиллагааны төлөвлөгөө юм. Төрийн бодлого бол тодорхой нөхцөлд зорилго түүнд хүрэх арга замыг сонгохын тулд улс төрд оролцогч буюу хэсэг оролцогчоос гаргасан харилцан холбоо бүхий цогц шийдвэр юм²³.

Батлан хамгаалах бодлого бол үндэсний аюулгүй байдлаа хангах хүрээнд улс орноо аливаа халдлагаас хамгаалах, түүний бэлтгэлийг хангах үйл ажиллагааны чиглэлийг тодорхойлсон төрийн бодлого²⁴ юм.

Батлан хамгаалах бодлого нь улс төр, эдийн засаг, нийгэм, эрх зүй, цэрэг-техник, оюун санааны агуулга бүхий үйл ажиллагааны хүрээг хамрах бөгөөд бодлогын хэрэгжилтийн үр дүн нь улс орны батлан хамгаалах чадавхаар илэрхийлэгдэнэ.

Батлан хамгаалах чадавх гэдэг нь улсын эдийн засаг, хүн амын эрүүл мэнд, боловсрол, төрийн цэргийн байгуулал, мэдээллийн болон улс төр-дипломатын чадавхын нэгдэл юм²⁵.

²² Монгол Улсын батлан хамгаалах бодлогын үндэс. УИХ-ын 2015 оны 85 дугаар тогтоол.

²³ Я.Бямбасүрэн, П.Доржсүрэн. “Төрийн бодлого”. УБ., 2006. т 5

²⁴ Б.Равжаа. “Батлан хамгаалах бодлого, үйл ажиллагааг боловсронгуй болгох зарим асуудал” Батлан хамгаалах бодлого эмхэтгэл. УБ., 2015.т 120

Батлан хамгаалах чадавх нь улс орны материалын болон оюун санааны хөгжлийн хүрсэн түвшингээс ихээхэн шалтгаална.

Батлан хамгаалах бодлогын гол зорилго нь улс орныхоо тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдлыг аливаа аюул сорилтоос хамгаалахад оршино.

Батлан хамгаалах бодлого нь дараах зургаан асуудалд анхаарлаа хандуулдаг. Үүнд²⁶:

Нэгд. Улс орны батлан хамгаалах хүчийг бэхжүүлэх

Улс орны шинжлэх ухаан, техник, технологийн дэвшлийг ашиглах, эдийн засгийг хөгжүүлэх, үр өгөөжийг дээшлүүлэх замаар нийгмийн материаллаг хэрэгцээг хангаад зогсохгүй, батлан хамгаалах чадавхыг бэхжүүлэхэд зайлшгүй шаардлагатай хэрэгслийг үйлдвэрлэх боломжийг бүрдүүлснээр хангана.

Хоёрт. Зэвсэгт хүчнийг хөгжүүлэх, байлдааны бэлтгэл сургууль, байлдааны бэлэн байдлыг дээшлүүлэх

Улс бүхэн өөрийн Зэвсэгт хүчнээ шаардлага, хэрэгцээнд нийцүүлэн орчин үеийн байлдааны зэвсэглэл, цэргийн техник, хамгаалалтын хэрэгсэлтэй байлгах, бүх талын хангалтыг тасралтгүй, бүрэн гүйцэт хийх, удирдлагыг шуурхай, тасралтгүй, найдвартай явагдах нөхцөлөөр хангагдана.

Гуравт. Улсын хилийн хамгаалалт

Улсын газрын болон агаарын хилийн халдашгүй дархан байдал, хилийн боомтоор нэвтрэн гаргах, орох хүн, техник, нисэх хэрэгсэлд тавих хяналтаар дамжуулан улс орныхоо аюулгүй байдлыг сахин хамгаална.

Дөрөвт. Иргэний хамгаалалт

Тайван цагт ямар ч улс хүн амаа аливаа халдлага, байгалийн гамшигт үзэгдлийн хөнөөлөөс болон техникийн гаралтай осол, сүйрлээс хамгаалах, олон нийтийн болон хувийн өмч хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хадгалах, томоохон үйлдвэрийн цогцолбор, стратегийн объектуудын үйл ажиллагааг таслахгүй, хэвийн явуулахын төлөө иргэний хамгаалалтыг зохион байгуулдаг.

Тавд. Зэвсэгт хүчнийг бие бүрэлдэхүүнээр нөхөн хангах цэрэгт бүртгэлтэй дайчилгааны бэлтгэл нөөцийн сургалт, бэлтгэл

Ихэнх улс орнууд цэрэгт бүртгэлтэй дайчилгааны нөөц бүрэлдэхүүнээ цэргийн гадуурх сургалтаар давтан бэлтгэдэг.

²⁵ Батлан хамгаалах тухай хуулийн 3 дугаар зүйл. 3.1.2 дахь заалт

²⁶ “Батлан хамгаалах стратеги” онол, арга зүй, шинжилгээний бүтээл. БХЭШХ. УБ., 2017. т 43-44

Зургаад. Терроризм

Терроризмоос сэргийлэх, хамгаалах, терроризмын заналыг арилгах, хөрш улсууд болон бүс нутгийн улс орнуудтай хамтран ажиллах, мэдээлэл солилцох, террорист халдлагын үр дагаврыг арилгах, терроризмын эсрэг сөрөг тусгай ажиллагаанд дэмжлэг үзүүлэх нь батлан хамгаалах бодлого, үйл ажиллагааны нэг чиглэл болж байна.

Батлан хамгаалах бодлого нь түүнийг хэрэгжүүлэх тогтолцоогоор дамжин шийдвэрлэгдэж байдаг зүй тогтолтой.

Батлан хамгаалах тогтолцоо гэж улс орныг батлан хамгаалахад чиглэсэн үйл ажиллагааг хэрэгжүүлэх зорилго бүхий улс төр, эдийн засаг, нийгэм, эрх зүй, цэргийн арга хэмжээ, тэдгээрийн удирдлага, зохион байгуулалтын арга хэмжээний цогцыг хэлдэг²⁷.

Монгол Улсын батлан хамгаалах тогтолцооны үндэс нь төр, захиргааны байгууллагууд, нийт иргэдийн оролцоонд тулгуурласан орон нутгийн хамгаалалт, мэргэжлийн цэрэгт суурилсан зэвсэгт хүчин, нэгдмэл удирдлага, төлөвлөлт бүхий дайчилгаа болж байна²⁸.

Орон нутгийн хамгаалалт нь Монгол Улсын өөрийгөө хамгаалах стратеги, улс орноо батлан хамгаалах тогтолцооны тулгуур үндэс бөгөөд бүх нийтийн оролцоотойгоор орон нутгийн хамгаалалтын бэлтгэлийг хангах, хамгаалах олон талт нэгдмэл арга хэмжээний цогцыг²⁹ хэлнэ. Орон нутгийн хамгаалалтын зорилго нь Монгол Улсын орон нутгийн өөрийгөө хамгаалах нийгэм, эдийн засгийн чадамжийг нэмэгдүүлэх замаар батлан хамгаалах нэгдмэл тогтолцооны цогц байдлыг хангах явдал юм.

Орон нутгийн хамгаалалтын үндсэн арга хэмжээ нь тайван цагт орон нутгийн хамгаалалтын бэлтгэлийг хангах, уламжлалт аюулаас урьдчилан сэргийлэх, уламжлалт бус аюулаас хамгаалах, онц болон дайны байдлын үед орон нутгаа хамгаалах замаар улсыг батлан хамгаалахад дэмжлэг үзүүлэхэд чиглэдэг. Тухайлбал, хуульд зааснаар тайван цагт ЗХЖШ-ын даалгаврын дагуу орон нутгийн цэргийн салбар, нэгжид иргэдийг оногдуулан бүртгэж, томилгоот үүрэгт нь сурган бэлтгэхээс гадна иргэдийнхээ эрүүл мэнд боловсролыг дэмжих, тэдний бие бялдар, сэтгэлзүйн бэлтгэлийг дээшлүүлэх мөн иргэдэд, ялангуяа хүүхэд залуучуудад эх

²⁷“Батлан хамгаалах тухай” хуулийн 3 дугаар зүйл. 3.1.3 дахь заалт

²⁸ “Монгол Улсын батлан хамгаалах бодлогын үндэс”-ийн 2 дугаар зүйл. 2.2. дахь заалт.;

²⁹ “Орон нутгийн хамгаалалтын тухай хуулийн 4 дүгээр зүйл. 4.1.1 дэх заалт;

оронч хүмүүжил олгох сургалт, мэдээлэл, сурталчилгааны ажлыг зохион байгуулах ажил, арга хэмжээг авч хэрэгжүүлэхээр тусгасан.

Бүх нийтийн оролцоонд тулгуурласан орон нутгийн хамгаалалт гэдэг бол эх орныхоо тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдалд эрсдэл учирч буй үед нийт иргэдийг үндэс угсаа, хүйс, нийгмийн гарал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол үл харгалзан орон нутгийн хамгаалалтын арга хэмжээнд татан оролцуулахыг хэлж байгаа бөгөөд ийнхүү оролцох нь иргэн бүрийн эх орныхоо өмнө хүлээсэн ариун үүрэг³⁰ юм.

Орон нутгийн хамгаалалтын бэлтгэлжилт нь тайван цагт улс орныг батлан хамгаалах бодлого, зорилттой уялдуулсан, орон нутгийн нийгэм, эдийн засгийн нөөц бололцоо, нийт иргэдийн дэмжлэгт тулгуурласан төрийн ба төрийн бус бүх шатны байгууллагын нягт хамтын ажиллагааны үр дүнгээр хэмжигдэнэ. Иймд орон нутгийн захиргаа, албан тушаалтнуудын бэлтгэл, чадавхыг сайжруулж, залуу үеийнхэнд эх оронч хүмүүжил олгох сургалтыг орон нутагт явуулж тогтмолжуулах шаардлагатай байна.

Батлан хамгаалах тогтолцооны нэг гол бүрэлдэхүүн хэсэг нь **“Мэргэжлийн цэрэгт суурилсан чадварлаг зэвсэгт хүчнийг бүрдүүлж бэхжүүлэх”** явдал юм. Монгол Улс эх орноо батлан хамгаалах хэрэгцээ, шаардлага, эдийн засгийн бодит боломжид нийцсэн, мэргэжлийн цэрэгт суурилсан, өөрийгөө хамгаалах зэвсэгт хүчнийг байгуулан бэхжүүлж байна. Зэвсэгт хүчнийг байгуулах, бэлтгэх, бэхжүүлэх талаар хэрэгжүүлдэг харилцан уялдаа холбоо бүхий арга хэмжээний тогтолцоог зэвсэгт хүчний байгуулалт гэж үздэг³¹.

Аливаа улсын төрийн цэргийн бодлого нь зэвсэгт хүчнийхээ байгуулалтад баримталж буй зарчмаар илэрхийлэгдэж байдаг. Монгол Улс зэвсэгт хүчнээ байгуулж, бэхжүүлэхдээ дараах зарчмуудыг баримталж байна. Үүнд:³²

- Зэвсэгт хүчин иргэний хяналтад байх;
- Зэвсэгт хүчнийг төрөөс удирдах;
- Зэвсэгт хүчний бүтэц, зохион байгуулалт, зэвсэглэл нь түүний тайван цагийн болон дайны үед гүйцэтгэх үүрэгт зохицсон байх;
- Зэвсэгт хүчин үндсэн үүргээ биелүүлэхэд байнга бэлэн байх;
- Зэвсэгт хүчний бүх төрлийн хангалтыг төрөөс баталгаажуулах;

³⁰ Ц.Дашзэвэг. Батлан хамгаалах бодлого, зэвсэгт хүчний байгуулалт, удирдлагын шинэчлэл. УБ., 2019.т 86

³¹ Ц.Дашзэвэг. Батлан хамгаалах бодлого, зэвсэгт хүчний байгуулалт, удирдлагын шинэчлэл. УБ., 2019. т28

³² Мөн тэнд. т100-104

- Зэвсэгт хүчний бие бүрэлдэхүүнийг цэрэг татлагаар болон сайн дурын үндсэн дээр гэрээгээр нөхөн хангах;
- Цэргийн алба хаагч нэг бүрийг цэргийн мэргэжилд заавал сургах;
- Хууль дээдлэх, чанд сахилга, өндөр зохион байгуулалттай байх;
- Төвлөрүүлэн удирдах, нэгтгэн захирах;
- Зэвсэгт хүчин нэгдмэл байх.

Монгол Улсын Зэвсэгт хүчин нь хуульд заасны дагуу “эх орныхоо тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн халдашгүй дархан байдлыг гадны зэвсэгт халдлага, түрэмгийллээс хамгаалах”³³ үндсэн чиг үүрэгтэй. Мөн түүнчлэн тайван цагт энэхүү үндсэн чиг үүргээ биелүүлэхийн тулд аливаа зэвсэгт халдлага түрэмгийллээс өөрийгөө хамгаалах бэлтгэлийг хангах, агаарын хилийн халдашгүй дархан байдлыг хамгаалах, улсын хил хамгаалалтад дэмжлэг үзүүлэх, энхийг дэмжих ажиллагаанд оролцох, зэвсэглэл, техник материал хэрэгслийн нөөцийг бүрдүүлэх, хадгалах зэрэг уламжлалт үүргээс гадна хөнөөх хэрэгслийн голомтоос хүн ам, эд хөрөнгийг авран хамгаалах, хүмүүнлэгийн тусламжийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, дайчилгааны бэлтгэл нөөцийн бүрэлдэхүүнийг сургах, залуучуудад эх оронч хүмүүжил төлөвшүүлэхэд дэмжлэг үзүүлэх, цэргийн зориулалттай тэсэрч дэлбэрэх зүйлийг аюулгүй болгох улс орныхоо бүтээн байгуулалтын ажилд оролцож болохыг хуульчилсан.

Монгол Улсын хувьд дайчилгааны бэлтгэл бол батлан хамгаалах тогтолцооны нэг үндэс бөгөөд **“Монгол Улс нэгдмэл удирдлага, төлөвлөлт бүхий дайчилгааны тогтолцоог** эдийн засгийн төлөв байдал, зэвсэгт хүчний гүйцэтгэх үүрэгт нийцүүлэн бүрдүүлнэ”³⁴ гэж бодлогын баримт бичигт тусгасан. Дайчилгаа нь улс орны эдийн засаг, нийгмийг дайны байдалд шилжүүлэх, зэвсэгт хүчнийг байлдааны цагийн орон тоогоор нөхөн хангахын тулд дайчилгааны бэлтгэл нөөцийн бүрэлдэхүүн, дайчилгааны материаллаг болон санхүүгийн нөөцийг дахин хуваарилах зорилгоор төрөөс төр, төрийн захиргааны төв, нутгийн захиргааны байгууллагаас хуулийн дагуу авч хэрэгжүүлж байгаа цогцолбор арга хэмжээ³⁵-г хэлдэг. Энэхүү цогцолбор арга хэмжээний төлөвлөлт, түүнийг хэрэгжүүлэх бэлтгэлжилт нь манай улсын батлан хамгаалах тогтолцооны салшгүй нэг хэсэг болж байна.

Улс орны эдийн засаг, нийгмийг дайны байдалд шилжүүлэхийн тулд дайчилгааны болон санхүүгийн нөөцийг дахин хуваарилах замаар улсын дайчилгааг

³³ Зэвсэгт хүчний тухай хуулийн 6 дугаар зүйл. 6.1 дэх заалт

³⁴ “Монгол Улсын батлан хамгаалах бодлогын үндэс” баримт бичгийн 2.5. дахь заалт;

³⁵ Дайчилгааны тухай хуулийн 3 дугаар зүйл.3.1.14 заалт

явуулдаг бол зэвсэгт хүчнийг байлдааны цагийн орон тоогоор нөхөн хангаж, байлдааны бүрэн бэлэн байдалд оруулахын тулд дайчилгааны бэлтгэл нөөцийн бүрэлдэхүүн, дайчилгааны болон санхүүгийн нөөцийг дахин хуваарилах цэргийн дайчилгааг явуулдаг. Харин орон нутгийн цэргийг дайчлан зохион байгуулах, орон нутгийн хамгаалалтын томилгоот нэгж, салбарыг эмхлэн зохион байгуулах зорилгоор нутгийн захиргааны байгууллагаас орон нутгийн хамгаалалтын төлөвлөгөөний дагуу авч хэрэгжүүлж буй арга хэмжээг орон нутгийн дайчилгаа гэнэ³⁶.

Хуульд заасны дагуу төрийн захиргааны төв, аймаг, нийслэл, сум дүүрэг, дайчилгааны даалгавар бүхий байгууллага, аж ахуйн нэгж бүр дайчилгааны төлөвлөгөөтэй байна. Гэхдээ энэхүү дайчилгааны даалгаврыг байнга тодотгож, шинэчилж байх учиртай.

Дайчилгааны бэлтгэлжилт нь улсын хөрөнгө, санхүүгийн нөөцөөс гадна дайчилгааны сургалт, сургуулиар хангагдана. Иймээс дайчилгааны бэлтгэл сургалтад удирдах албан тушаалтнууд, дайчилгааны бэлтгэл нөөцийн бүрэлдэхүүн зайлшгүй хамрагдах ёстой. Мөн иргэдийг эх орноо батлан хамгаалахад сургаж бэлтгэх асуудал яригдана. “Монгол Улсын батлан хамгаалах бодлогын үндэс” баримт бичигт “төрийн захиргааны төв, нутгийн захиргааны байгууллага, төрийн өмчийн ба хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, байгууллага, иргэн бүр хуульд заасан дайчилгааны даалгавраар хүлээсэн үүргээ биелүүлэх урьдчилсан бэлтгэлтэй байна³⁷” гэж заасан нь дайчилгааны сургалтын эрхэм зорилго болж байна.

Дайчилгааны бэлтгэл нөөцийн бүрэлдэхүүний сургалт явуулах журмыг “Дайчилгааны тухай”, “Цэргийн албаны тухай” хуулиар зэвсэгт хүчний цэргийн нэгтгэл анги болон аймаг нийслэлд орон нутгийн зарчмаар зохион байгуулахаар тусгагдсан.


2018 оны байдлаар улсын хэмжээнд дайчилгааны бэлтгэл нөөцийн нийт бүрэлдэхүүнээс нэгдүгээр зэргийн бэлтгэл үүрэгтэн цэргийн алба хаасан **хүн** хувийг эзэлж байна. Их, дээд сургууль төгссөн залууст цэргийн нарийн мэргэжил эзэмшүүлэх зорилгоор ҮБХИС-ийг түшиглэн явуулдаг бэлтгэл офицерын сургалтад 2018 оны байдлаар 200 гаруй хүн хамрагдсан байна. Бэлтгэл офицеруудыг тодорхой хугацааны дараа давтан бэлтгэх хэрэгцээ шаардлага гардаг. Тиймээс дээрх хүмүүсийг сургаж бэлтгэхэд шаардагдах зардлыг аймаг, нийслэлийн болон Зэвсэгт хүчний жил бүрийн төсөвт суулгаж, хэрэгжилтэд нь хяналт тавьж байх нь зүйтэй юм.

³⁶ Ц.Дашзэвэг. “Батлан хамгаалах бодлого, зэвсэгт хүчний байгуулалт, удирдлагын шинэчлэл”. УБ., 2019. т113

³⁷ Монгол Улсын батлан хамгаалах бодлогын үндэс”. 2 дугаар зүйл. 2.5.3 дахь заалт. УИХ-ын 2015 оны 85 дугаар тогтоол

Мөн бүсийн тулгуур төвүүдэд дайчилгааны сургалтын нэгжийг байгуулж ажиллах нь бэлтгэл офицер, цэргийн бэлтгэл үүрэгтний дайчилгааны бэлтгэл сургалтыг боловсронгуй болгох, дайчилгааны бэлтгэл нөөцийн бүрэлдэхүүний хомсдолоос гарах арга зам байж болох талтай.

“Монгол Улсын батлан хамгаалах бодлогын үндэс” баримт бичигт улс орноо батлан хамгаалах бодлогын улс төрийн, эдийн засгийн, нийгмийн, эрх зүйн болон цэргийн чиглэлийг тодорхойлж өгсөн нь батлан хамгаалах зорилт, үйл ажиллагаа зөвхөн цэргийн төдийгүй улс орны бүх салбарыг хамарсан нэгдмэл удирдлага, төлөвлөлт, зохион байгуулалт, зохицуулалтын цогц арга хэмжээ болохыг илэрхийлж байгаа юм.



1.4 дүгээр зураг. Батлан хамгаалах бодлогын чиглэл

Монгол Улсын батлан хамгаалах бодлогын улс төрийн чиглэлийн үндэс нь Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын болон Гадаад бодлогын үзэл баримтлалыг үндэс болгон улс төр, дипломатын аргыг урьтал болгох бөгөөд гадны зэвсэгт түрэмгийллийн эсрэг цэргийн хүч ашиглахад чиглэгдэнэ.

Монгол Улсын батлан хамгаалах бодлогын эдийн засгийн чиглэлийн үндэс нь улсын тогтвортой хөгжлийг хангаж, батлан хамгаалах чадавхыг бэхжүүлэхэд гол анхаарлаа хандуулна. Эдийн засгийн тогтвортой хөгжлийг хангах үйл ажиллагааг үндэсний аюулгүй байдал, батлан хамгаалах ашиг сонирхолд нийцүүлж байх нь батлан хамгаалах бодлогын эдийн засгийн үндсэн чиглэл юм.

Батлан хамгаалах бодлогын нийгмийн чиглэлийн үндэс нь Монгол Улсын хүний хөгжил учраас хүн амын эрүүл мэнд, боловсрол, сэтгэл зүй, бие бялдрын

хүмүүжлийг дээшлүүлэх, нийт иргэд, залуучуудыг эх оронч үзлээр хүмүүжүүлэхэд чиглэгдэнэ.

Батлан хамгаалах бодлогын эрх зүйн чиглэлийн үндэс нь батлан хамгаалах тогтолцоо болон зэвсэгт хүчний үйл ажиллагааны хууль эрх зүйн бүх асуудлыг хамарч байна. Нийгмийн бүх харилцаа, тэр тусмаа зэвсэгт хүчний байгуулалт, үйл ажиллагааны хэмжээ зөвхөн төрийн хууль тогтоомж, хуульчлагдсан эрх зүйн актаар зохицуулагдаж байх учиртай.

Батлан хамгаалах бодлогын цэргийн чиглэлийн үндэс нь өөрийгөө хамгаалах зэвсэгт хүчнийг шинэчлэхэд оршиж байгаа бөгөөд энэ нь төрийн цэгцтэй бодлого, төсвийн зохих санхүүжилт, улс төрийн бүх хүчин, нийт иргэдийн хүчтэй дэмжлэгийн үр дүнд л амжилттай хэрэгжих учиртай.

Монгол Улсын төр батлан хамгаалах бодлого, зорилтоо тодорхойлохдоо улс, үндэстэн хоорондын аливаа маргаантай асуудлыг шийдвэрлэхэд яриа, хэлэлцээ, улс төр-дипломатын аргыг урьтал болгох, бусад улсад цэргийн аюул занал учруулахгүй байх, гадны зэвсэгт халдлага, түрэмгийлэлд өртөхөөс бусад тохиолдолд цэргийн эвсэл холбоонд нэгдэхгүй байх, гадны цэргийн хүчийг өөрийн нутагт байрлуулахгүй, дамжин өнгөрүүлэхгүй, хөрш орнууд болон дэлхийн бусад орнуудтай харилцан итгэлцсэн, найрсаг хамтын ажиллагааг тэнцвэртэй хөгжүүлэх зэрэг энхийг эрхэмлэсэн зарчмуудыг тууштай баримтлахаа дахин нотолсон байдаг. Батлан хамгаалах талаар баримтлах төрийн бодлого нь төр, нийгэм, нийт иргэдийн эрх ашгийн тусын тулд төрийн бодлогын тэргүүлэх байр сууриа хадгалж, тогтвортой мөрдөх удирдамж болохын хувьд батлан хамгаалах хууль тогтоомжийн үндэс болон хэрэгжиж байна.

Монгол Улс өөрийн нутаг дэвсгэр дээр гадаадын цэрэг байрлуулахгүй, дамжин өнгөрүүлэхгүй, тайван цагт цэргийн ямар нэг эвсэл холбоонд нэгдэхгүй байх бодлого нь юуны өмнө хөрш хоёр оронтойгоо адил тэнцвэртэй, найрсаг харилцаатай байхыг чухалчилж байгаагийн илэрхийлэл юм.

Монгол Улс цэргийн аюулгүй байдлаа Орос, Хятадын зэрэгцээ дэлхийн нөлөө бүхий бусад улс орон, түүний дотор АНУ-тай харилцах, хамтран ажиллах замаар болон НҮБ, нэр хүнд бүхий олон улсын бусад байгууллагуудын үйл ажиллагааны хүрээнд хангах эрмэлзэлтэй ажиллаж байна.

Гэхдээ арга зүйн хувьд хамтын ажиллагааны чиглэлийг бодлого, стратегитай холбон авч үзвэл: **нэгд**, “**гуравдагч хөрш**”-ийн бодлого бол мөнхийн хоёр хөршийн дунд орших манай улсын хувьд мөнхийн бодлого байх бөгөөд энэхүү бодлогод цаг хугацааны хязгаар тавих боломжгүй, **хоёрт**, харин тухайн гадаад нөхцөл байдалтай

уялдан “гуравдагч хөрш”-ийг сонгох, түүнийг ил гаргах, эрчимжүүлэх, эсхүл сааруулах, засварлах зэрэг стратеги баримтлах шаардлагатай³⁸ юм.

Сүүлийн үед Зэвсэгт хүчин уламжлалт үндсэн үүргээс гадна олон талт, хүмүүнлэгийн, энхийг сахиулах, улс орны бүтээн байгуулалтад оролцох зэрэг уламжлалт бус үүргүүд нэмэгдэж байна.

Цэргийн аюулын зэрэгцээ уламжлалт бус аюулын төрлүүд олширч, бас хурцдаж байгаа нь үүний эсрэг чиглэсэн цогц бодлогыг тодорхойлон хэрэгжүүлэхэд батлан хамгаалах үйл ажиллагаа нэмэгдэх хандлага ихсэж байна.

Мөн түүнчлэн цаг уурын болон экологийн өөрчлөлтөөс үүдэлтэй байгалийн гамшиг гарах давтамж нэмэгдэж, түүнээс учрах хохирол жилээс жилд ихсэж, үндэсний болоод бүс нутгийн хэмжээний гамшиг гарах магадлал өндөрсөх болсон нь цэргийн хүчийг зэвсэгт хүчний тайван цагийн үүргийн нэг болох гамшгийн үед аврах, хор уршгийг арилгах, сэргээн босгох, олон улсын хүмүүнлэгийн тусламжийн үйл ажиллагаанд туслах арга хэмжээнд татан оролцуулах хэрэгцээ нэмэгдэх хандлагатай байна.

Мөн түүнчлэн бодлогын баримт бичигт уул уурхай, олборлох, боловсруулах салбар, түлш эрчим хүчний салбар, хүнс, хөдөө аж ахуйн салбар, зам тээвэр, харилцаа холбооны салбар гэх мэт стратегийн чухал ач холбогдолтой салбаруудыг үндэсний аюулгүй байдал, батлан хамгаалах эрх ашигт нийцүүлэх талаар тусгалаа олсон нь Монгол Улсын тусгаар тогтнолыг бэхжүүлэх нэг чухал чиглэл болж байна.

Дээр дурьдсан бодлого, үйл ажиллагаанаас харахад улс орныхоо тусгаар тогтнолыг бэхжүүлэхэд батлан хамгаалах, түүний дотор цэргийн хүчнийхээ чадавхыг нэмэгдүүлэх асуудал их чухал гэдэг нь харагдаж байна.

1.3. Хүн ам зүй болон батлан хамгаалах бодлогын уялдаа холбоо

Улс орны хөгжил нь нийгмийн хөгжлөөс, нийгмийн хөгжил нь хүний хөгжлөөс шууд хамаардаг. Иймд төрийн үйл ажиллагаа хүн амынхаа сайн сайхны төлөө чиглэгдэж, улмаар эрүүл чийрэг, мэдлэг боловсролтой, чадварлаг боловсон хүчинд тулгуурлаж хөгжих учиртай. Өөрөөр хэлбэл, улс орны бүхий л салбарын талаар баримтлах төрийн бодлогуудын уялдаа холбооны зангилаа нь хүн амын өсөлт, хөгжилт, ажил хөдөлмөр, гүйцэтгэх чадвар дээр суурилагддаг.

³⁸ Б.Эрдэнэчимэг. “Монгол Улсын тусгаар тогтнолыг бэхжүүлэх талаарх батлан хамгаалах бодлогын чиг хандлага”. Монгол Улсын тусгаар тогтнол ба батлан хамгаалах бодлого сэдэвт эрдэм шинжилгээний хурал. МУЕТГ. 2016.

Тийм учраас батлан хамгаалах асуудалд хүн амын өсөлт, түүний бүтэц, боловсрол, эрүүл, мэнд, бие бялдрын болон оюун санааны төлөвшлийг цогцоор авч үзэх шаардлагатай юм. Өөрөөр хэлбэл, төр, төрийн захиргааны төв, нутгийн захиргааны бүх шатны байгууллагуудын оролцоо, хамтын ажиллагаагаар хүн ам зүйн болон батлан хамгаалах бодлогын нийгмийн арга хэмжээний уялдаа холбоо сайжирч, үр дүнд хүрэх болно.

Судалгааны 1.1 дүгээр зүйлд авч үзсэн хүн ам зүйн бодлогын хүн амын тоо, хэмжээ, бүтэц, хөгжлийн асуудлын судалгаа нь батлан хамгаалах бодлогын хэрэгжилтийн үр дүнг илэрхийлдэг батлан хамгаалахын чадавхын улс төр, нийгэм, эдийн засгийн хөгжлөөс гадна хүн амын эрүүл мэнд, боловсролтой салшгүй холбоотой байдаг талаар 1.2 дугаар зүйлд өгүүлсэн хамааралтай нягт уялдаатай байна.

Батлан хамгаалах бодлогод хүн ам зүйн бодлогын үзүүлэх гол нөлөөлөлд тухайн орны хүн амын өсөлт (түүний дотор эрэгтэй хүүхдийн тоо), хүйсийн харьцаа, цэргийн насны залуучуудын эрүүл мэнд, боловсролын түвшин, хөдөлмөрийн чадавхтай хүн амын ажил эрхлэлтийн байдал, дайчилгааны бэлтгэл нөөцийн бүрэлдэхүүн, тэдгээрийн бэлтгэлжилт орно.

Судалгаанаас үзэхэд 1995-1999 онд жил бүр 23682-25195 буюу дунджаар 24439 эрэгтэй хүүхэд, 2013-2017 онуудад жил бүр 38958-42653³⁹ буюу дунджаар 41200 эрэгтэй хүүхэд төрсөн нь эмэгтэй хүүхдийнхээс жил бүр дунджаар 2300 гаруйгаар илүү байна. Энэ нь ирээдүйд батлан хамгаалах ашиг сонирхолд эерэг нөлөөтэй байх сайн талтай.

Дээрх үзүүлэлт нь 2030 оноос батлан хамгаалах бодлого дахь хүн ам зүйн зохистой хөгжлийг бүрдүүлэх үндэстэй байна гэсэн дүгнэлтэд хүргэж байгаа боловч тэднийг сургаж бэлтгэх нөхцлийг урьдчилан бүрдүүлж, үйл ажиллагааг бодлого төлөвлөгөөний дагуу нягт уялдаа холбоотойгоор хийж гүйцэтгэх нь чухал юм.

Батлан хамгаалах бодлого, түүнийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны үр дүнд гарах эерэг, сөрөг үр дагаварууд нь гол төлөв хувь хүний болон олон нийтийн үйл ажиллагаанаас үүдэх бөгөөд энэ нь тэдний ёс суртахуун, сэтгэл зүй, эх оронч үзэл, хүмүүжлийн төлөвшлөөс хамаарч байна.

Хүн чадавхтай, эх оронч үзэл, хүмүүжилтэй байж батлан хамгаалах тогтолцоо зөв бүрдэнэ. Харин хүний чадавх нь эрүүл мэнд, боловсрол, бие бялдар, сэтгэл зүйн түвшингөөр тодорхойлогдоно.

³⁹ Төрөлтийн тоо, хүйсээр, аймгаар. http://www.1212.mn/tables.aspx?TBL_ID=DT_NSO_0300_013V3

Тэгвэл төрийн оролцооны асуудал ямар байх ёстой вэ. Төр хүнийхээ хөгжилд тустай, ая тухтай, таатай орчин бүрдүүлэх, эх оронч үзэл, хүмүүжил төлөвшүүлэх үүрэг хүлээж, бодит байдалд дүгнэлттэй хандаж, үйл ажиллагаагаа алсын хараатай явуулах шаардлагатай.

Хүн өөрөө яах ёстой вэ. Хүн боломжоо бүрэн ашиглаж, өөрийн сонирхол хэрэгцээнийхээ хүрээнд бүтээлчээр ажиллаж, амьдрах ёстой. Үүнийг хүн төвтэй, хүнийг сонголтыг өргөжүүлсэн хөгжил гэнэ. Өөрөөр хэлбэл, хүнээ хөгжүүлж, өв тэгш хүмүүжилтэй болгох асуудал юм. Ийм учраас батлан хамгаалах болон хүн ам зүйн бодлогын уялдаа холбоо нь хүний хөгжил, амьдралын оршихуйд тулгуурлана.

Ямар ч улс орны Зэвсэгт хүчний хөгжил нь түүнд алба хааж буй бие бүрэлдэхүүний боловсрол, эрүүл мэнд, бие бялдын хөгжлөөс ихээхэн хамааралтай байдаг. Зэвсэгт хүчний анги, салбарууд нь зөвхөн мэргэжлийн өндөр бэлтгэлтэй төдийгүй эрүүл чийрэг бие бялдартай, сэтгэл зүйн хувьд зориг хатуужилтай бие бүрэлдэхүүнтэй байснаар сая тайван цагийн орон тоо, зохион байгуулалтаараа байлдааны болон тусгай үүрэг гүйцэтгэх чадвартай болох учиртай билээ.

Төр, захиргааны байгууллагууд, нийт иргэний оролцоонд тулгуурласан орон нутгийн хамгаалалт, мэргэжлийн цэрэгт суурилсан зэвсэгт хүчин, нэгдмэл удирдлага, төлөвлөлт бүхий дайчилгаатай байх төрийн бодлогыг хэрэгжүүлэх хүрээнд цэргийн насны залуучуудыг хугацаат цэргийн албанд тэнцүүлэн татахад хэд хэдэн чухал шаардлага тавигдаж байна⁴⁰. Тухайлбал:

- Бие бялдын хэвийн хөгжилтэй, биеийн тамирын зохих үзүүлэлтийг хангах чадвартай байх;
- Суурь өвчингүй байх;
- Тодорхой тогтоосон хэмжээний IQ-тай байх /Байлдааны дүрэмд тодорхой хэмжээний IQ-тай иргэнийг цэргийн албанд татах заалт орсон/;
- Бүрэн бус дунд буюу түүнээс дээш боловсролтой байх гэх мэт ерөнхий шаардлагууд байна. Түүнчлэн гэрээт цэргийн албан хаагчдад гадаад хэлний зохих мэдлэгтэй, компьютер болон бусад техник, хэрэгсэл ашиглах чадвартай байх нэмэлт шаардлагууд ч шинээр тавигдах боллоо.

Дээрх шалгуур үзүүлэлтүүд нь орчин үед Зэвсэгт хүчний шинэчлэл, түүний гүйцэтгэх үүрэг, хүлээх хариуцлагатайдаа нягт холбогдож байгаа юм. Ялангуяа НҮБ-ын Энхийг сахиулах хүчний бүрэлдэхүүнд хилийн чанадад үүрэг гүйцэтгэх нь манай

⁴⁰ “Монголын залуучуудын бие бялдын хөгжлийн судалгаа”. БХЭШХ. 2016

Зэвсэгт хүчний цэргийн албан хаагч нэг бүрээс дэлхийд цэргийн шинжлэх ухааны хөгжлөөр тэргүүлэгч улс орнуудын нийтлэг стандартад тохирох, мэргэжлийн төдийгүй бие бялдар, сэтгэл зүйн өндөр бэлтгэлжилтийг шаардаж байна. Гэвч тавигдаж байгаа шаардлагыг цэргийн албанд татагдан ирж байгаа залуучуудын эрүүл мэнд, боловсролын байдал төдийлөн хангахгүй байгаа нь сүүлийн жилүүдийн судалгаанаас харагдаж байна.

Төр, засгаас Зэвсэгт хүчнийг "мэргэжлийн цэрэгт суурилсан", "чадварлаг" болгон шинэчлэх зорилтын хүрээнд бие бүрэлдэхүүний дотор мэргэжлийн ахлагч, гэрээт цэргийн албан хаагчид болон хугацаат цэргийн албанд татах иргэдийн тоог ч нэмэгдүүлэх бодлогыг хэрэгжүүлж байна. Гэсэн хэдий ч жил бүрийн цэрэг татлагаас чөлөөлөгдөж буй хүний тоо өмнөх жилүүдийнхтэй харьцуулахад нийт дүнгээрээ төдийлөн буурахгүй байгаа нь бидний анхаарлыг зүй ёсоор татаж байна.

Цэргийн насны залуучуудын эрүүл мэнд, боловсрол, бие бялдын хөгжил, бэлтгэлжилтийг сайжруулахын тулд Төр засаг бодлогын хүрээнд иргэн болон нийгмийн байгууллагууд тодорхой үүрэг хүлээж, шаардлагатай арга хэмжээ нэн даруй авах нөхцөл байдал бий болоод байна.

*Хүн амын тогтвортой өсөлтийг хангах, иргэдийн урт удаан, эрүүл энх, бүтээлчээр амьдрах, хөгжих таатай орчныг бүрдүүлэх, хувь хүн болон гэр бүлийн амьдралын чанарыг дээшлүүлэх*⁴¹ зорилгоор **Төрөөс хүн амын хөгжлийн талаар баримтлах бодлого** (2016-2025 он)-ыг Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 261 дүгээр тогтоолоор; *аливаа дайн, зэвсэгт мөргөлдөөнөөс ангиуд байж, улсыг батлан хамгаалах тогтолцоо, батлан хамгаалах бодлогын үндсэн чиглэлийг тодорхойлж, Монгол Улсын тусгаар тогтнол, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал, оршин тогтнохуйн аюулгүй байдлыг баталгаажуулах*⁴² зорилгоор Монгол Улсын Их Хурлын 2015 оны 85 дугаар тогтоолоор **Монгол Улсын Батлан хамгаалах бодлогын үндэс** баримт бичгийг батлуулан мөрдөж байна.

Батлан хамгаалах болон хүн ам зүй бодлогын уялдаа холбоог гаргахын тулд хоёр бодлогын баримт бичгийн зарим заалтуудыг харьцуулан авч үзье.

Батлан хамгаалах бодлогын үндэс баримт бичгийн "Батлан хамгаалах бодлогын нийгмийн чиглэл"-ийн *"Бүс нутгийг хөгжүүлэх, хүн амыг амьдрах нөхцөл, суурьшлын бүс, дэд бүтэц бий болгох, боловсрол, соёл, иргэдийн эрүүл мэндийг хамгаалах эдийн засаг, нийгмийн цогц бодлогыг хэрэгжүүлнэ"*⁴³, "Бүх шатны

⁴¹ Монгол Улсын төрөөс хүн амын хөгжлийн талаар баримтлах бодлого. ЗГ-ын 2016 оны 261 тогтоол

⁴² Монгол Улсын батлан хамгаалах бодлогын үндэс. УИХ-ын 2016 оны 85 дугаар тогтоол

⁴³ Мөн тогтоолын 5.2 дахь заалт

боловсролын байгууллагын сургалтын хөтөлбөрт хүүхэд, залуучуудад цэрэг эх оронч үзэл, хүмүүжил олгох хичээлийн хөтөлбөрийг тусгаж, хэрэгжүүлнэ⁴⁴” гэсэн заалтууд нь Төрөөс хүн амын хөгжлийн талаар баримтлах бодлогын “хүн амын тогтвортой өсөлтийг хангах таатай нөхцөлийг бүрдүүлэх⁴⁵”; “хүн амын шилжилт хөдөлгөөнийг зохистой түвшинд байлгах⁴⁶”; “хүн бүр боловсрол эзэмших, хөгжих боломжийг бүрдүүлэх⁴⁷” гэсэн заалтуудаас тодорхой хэмжээгээр хамаарах бөгөөд энэ хүрээнд хүн авьяас чадвараа хөгжүүлэн үр бүтээлтэй хөдөлмөрлөж, аз жаргалтай амьдрахад шаардагдах чанартай боловсрол, мэдлэг, чадварыг эзэмших, зөв төлөвших, насан туршдаа суралцах боломжийг бүрдүүлж, хариуцлагатай, бүтээлч, хүмүүнлэг, ёс зүйтэй, амьдралын зөв дадал, хэвшилтэй, эх орноо хайрласан, үндэсний дэвшилтэт уламжлал, өв соёлоо дээдэлсэн монгол хүн болж төлөвших ёстой болж байна. Иймд төр, төрийн захиргааны байгууллагууд, түүний дотроос Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын, Эрүүл мэндийн, Батлан хамгаалах, Сангийн, Байгаль орчин, аялал жуулчлалын, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамдууд хамтарч хүний эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг хангах, нийгэм, эдийн засгийн хөгжлийг байгаль орчны тэнцэлтэй уялдуулах, хөдөө орон нутагт хүн амын нягтралыг нэмэгдүүлэх, эрүүл мэнд, амьдралын чанарыг дээшлүүлэх, нийт иргэд, залуучуудыг эх оронч үзлээр хүмүүжүүлэх, цэрэг иргэний харилцааг төлөвшүүлэх, нутаг дэвсгэрийн эзэнгүйдлийг арилгах цогц бодлого боловсруулж, хуульчлан хэрэгжүүлэх нь төрийн бодлогын залгамж чанар, уялдаа холбооны мөн чанарын илэрхийлэл байх болно.

Мөн түүнчлэн Батлан хамгаалах бодлогын үндсийн “Иргэдийн цэргийн алба хаах хүсэл сонирхол, эрмэлзлийг нэмэгдүүлэхэд чиглэсэн эдийн засаг, нийгмийн урамшуулалт бодлого боловсруулж хэрэгжүүлнэ⁴⁸” гэсэн заалт нь Төрөөс хүн амын хөгжлийн талаар баримтлах бодлогын “гэр бүлийн амьдралын таатай орчныг бүрдүүлэх, амьдралын чанарыг сайжруулах⁴⁹”; “хүн амыг ажилтай, орлоготой байх нөхцлийг бий болгох⁵⁰” гэсэн заалтуудын хүрээнд хэрэгжих боломжтой. Үүний тулд Батлан хамгаалах, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамтай хамтарч, хүүхэд, залуучуудад эх оронч үзэл төлөвшүүлэх,

⁴⁴ Монгол Улсын батлан хамгаалах бодлогын үндэс. УИХ-ын 2016 оны 85 дугаар тогтоолын 5.3 дахь заалт

⁴⁵ Монгол Улсын төрөөс хүн амын хөгжлийн талаар баримтлах бодлого. ЗГ-ын 2016 оны 261 дүгээр тогтоолын 3.1.1 дэх заалт

⁴⁶ Мөн тэнд 3.1.2 дахь заалт

⁴⁷ Мөн тэнд 3.1.4 дэх заалт

⁴⁸ Мөн тэнд 5.4 дэх заалт

⁴⁹ Монгол Улсын төрөөс хүн амын хөгжлийн талаар баримтлах бодлого. ЗГ-ын 2016 оны 261 дүгээр тогтоолын 3.1.3 дахь заалт

⁵⁰ Мөн тэнд 3.1.5 дахь заалт

цэргийн алба хаасан залуучуудад сурч боловсрох, хөдөлмөр эрхлэх давуу байдлыг хууль эрх зүйн хувьд, өөрөөр хэлбэл, холбогдох хуулиудад нэмэлт оруулах, эсхүл Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлэх, эдийн засгийн өсөлтийн өгөөжийг зохистой хуваарилж, төр, хувийн хэвшлийн түншлэлээр хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлж, ажиллах хүчний нөөцийг төлөвлөлттэйгээр үр дүнтэй ашиглаж, ажилгүйдлийн, ядуурлын түвшинг зохих түвшинд хүртэл бууруулснаар батлан хамгаалах болон хүн ам зүйн бодлогын уялдаа бодитой бий болно.

Батлан хамгаалах бодлогын үндсийн *“Эх орноо батлан хамгаалах үйл хэрэгт иргэн бүрийн оролцоог хангаж, цэргийн алба хаах тогтолцоог боловсронгуй болгоно. Цэргийн албыг биеэр болон хуульд заасан бусад хэлбэрээр хаагаагүй иргэнд хариуцлага хүлээлгэх эрх зүйн орчныг бүрдүүлнэ. “Төрийн албанд анх орж байгаа иргэнд цэргийн алба хаасан байх шаардлага тавина⁵¹; “Цэргийн алба хаагч, цэргийн анги, байгууллагад гэрээгээр ажиллагсдын алба хаах нөхцөлийг бүрдүүлэх, нийгмийн баталгааг хангах эрх зүйн орчныг боловсронгуй болгоно⁵²”; “Цэргийн алба хаагчийн гэр бүлийн гишүүнд эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэх нөхцлийг бүрдүүлнэ”⁵³* гэсэн заалтуудын хүрээнд төр, төрийн захиргааны төв, түүний дотроос Батлан хамгаалах, Сангийн, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын, Эрүүл мэндийн яамдууд, нутгийн захиргааны байгууллагууд хамтарч эх орон, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал, хил хязгаарын дархан байдлын мөн чанар, түүхэн уламжлалыг иргэдэд сурталчлан таниулах, их, дээд сургуулиудад Цэрэг-батлан хамгаалах-ын тэнхим байгуулах, одоо мөрдөгдөж байгаа хуулиудын хэрэгжилтийг сайжруулах, холбогдох хууль тогтоомжуудад нэмэлт, өөрчлөлт оруулах, төрийн захиргааны төв, нутгийн захиргааны байгууллагын удирдах албан тушаалтныг сургууль, цугларалтад хамруулах замаар тэдний цэрэг-стратегийн бэлтгэлийг дээшлүүлснээр Батлан хамгаалах бодлогын нийгмийн чиглэлүүд хүн ам зүйн бодлоготой уялдаатай хэрэгжих боломжтой болно.

Энэхүү бодлогуудын уялдаа холбоо, хэрэгжилтийн үр дүнд орон нутагт хүн тогтвор суурьшилтай ажиллаж, амьдрах таатай орчин, нөхцөл бүрдэж, хөдөө рүү чиглэсэн шилжилт хөдөлгөөн нэмэгдэж, хүн амын байршлын зохистой харьцааг хот, хөдөөд тэнцвэртэй болох бөгөөд орон нутгийн хамгаалалтыг зохион байгуулах, батлан хамгаалах чадавхыг дээшлүүлэх аятай нөхцөл бүрдэнэ.

⁵¹ Монгол Улсын батлан хамгаалах бодлогын үндэс. УИХ-ын 2016 оны 85 дугаар тогтоолын 5.5 дахь заалт

⁵² Мөн тогтоолын 5.6 дахь заалт

⁵³ Мөн тогтоолын 5.7 дахь заалт

Төрийн бодлогын уялдаа холбоог сайжруулах үндсэн механизм нь нийгмийн олон янзын ашиг сонирхлыг нийтлэг эрх ашгийн үүднээс зохицуулсан, уялдаа холбоо бүхий хууль эрх зүйн актууд байх болно. Иймд одоо мөрдөгдөж байгаа хууль эрх зүйн актуудад зохих өөрчлөлтүүдийг алсын хараатай, хоёрдмол утгагүй, явцуу ашиг сонирхлын бус үүднээс хийх шаардлагатай байна.

Иргэдийг эх орноо батлан хамгаалахад бэлтгэх арга хэмжээний үндэс нь төрөл бүрийн хэлбэрийн сургалт юм. Гэхдээ энэ сургалтыг аль болох богино хугацаанд өндөр үр дүнтэй, зардал чирэгдэл багатай, иргэдийг сурч боловсрох, ажил, амьдралаа эрхлэхэд нь саад болохооргүй явуулах учиртай. *“Иргэдийг эх орноо батлан хамгаалахад сургаж бэлтгэх, эх оронч үзлээр хүмүүжүүлэхэд төрийн бүх шатны болон төрийн бус байгууллагын үйл ажиллагааг нэгтгэн чиглүүлэх”*⁵⁴ нь Засгийн газрын чухал бүрэн эрхийн нэг болохыг, түүнчлэн *“улсын дайчилгааны бэлтгэлийг хангах, сургалтыг зохион байгуулах”*⁵⁵ нь төрийн захиргааны бүх шатны байгууллагын үүрэг мөн болохыг Батлан хамгаалах хуулийн шинэчилсэн найруулгаар зохицуулсан.

Дайчилгааны бэлтгэл нөөцийн бүрэлдэхүүний сургалт явуулах журмыг “Дайчилгааны тухай”, “Цэргийн албаны тухай” хуулиар зохицуулж, тэдэнтэй явуулах сургалтыг зэвсэгт хүчний цэргийн нэгтгэл, ангид болон аймаг, нийслэлд орон нутгийн зарчмаар зохион байгуулах эрх зүйн орчин бүрдсэн.

Гэсэн хэдий ч их, дээд сургууль төгссөн залууст цэргийн нарийн мэргэжил эзэмшүүлэх зорилгоор бэлтгэл офицерын сургалтыг зөвхөн ҮБХИС-ийг түшиглэн зохион байгуулж ирсэн. Бэлтгэл офицерын бүрэлдэхүүн нь оногдуулан бүртгэгдсэн тухайн албан тушаалыг тодорхой хугацаагаар зохих төвшинд хашсан, мэргэжил дадлагатай, зохих төвшний боловсрол эзэмшсэн, ажлыг зохион байгуулах туршлагатай бүрэлдэхүүн хэдий ч тэднийг цэргийн жинхэнэ албанаас бэлтгэл албанд шилжээд 10 жил болсны дараа цэргийн мэргэжил эзэмшүүлэх сургалтанд зайлшгүй хамруулах шаардлагатай болохыг манай зэвсэгт хүчинд урьд өмнө зохион байгуулж явуулсан дайчилгаатай томоохон хээрийн сургуулиудын дүн нотлон харуулж байдаг. Энэ нь бэлтгэл офицеруудыг давтан бэлтгэх хэрэгцээ, шаардлагыг улам өсгөж байгаа юм. Дэлхий дахины улс гүрнүүдийн цэргийн дайчилгааны бэлтгэл үүрэгтний сургалтын туршлага ч ийм байдаг байна⁵⁶.

⁵⁴ “Батлан хамгаалах тухай” хууль. 13 дугаар зүйлийн 13.1.6. дахь заалт;

⁵⁵ “Батлан хамгаалах тухай” хууль. 16 дугаар зүйлийн 16.1.3. дахь заалт;

⁵⁶ Ц.Дашзэвэг. “Батлан хамгаалах бодлого, зэвсэгт хүчний байгуулалт, удирдлагын шинэчлэл”. УБ., 2019. т123

Бэлтгэл офицерын сургалтыг Зэвсэгт хүчний цэргийн анги, салбаруудад зөвхөн дайчилгаатай хээрийн сургууль явуулах үед зохион байгуулагддаг.

Иймд дайчилгааны бэлтгэл нөөцийн бүрэлдэхүүний сургалт, ялангуяа нэгдүгээр ба хоёрдугаар зэргийн бэлтгэл үүрэгтэн, бэлтгэл офицеруудын давтан бэлтгэх сургалтыг чанартай, үр өгөөжтэй, тогтмол зохион байгуулахад, *нэгд*, дайчилгааны нөөцийн бүрэлдэхүүний сургалтын эрх зүйн орчныг улам боловсронгуй болгох; *хоёрт*, улс орныг батлан хамгаалах зорилтыг хэрэгжүүлэхэд олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх нь гол арга зам бөгөөд бага буурай орны хувьд өөрийгөө хамгаалах стратеги болох орон нутгийн хамгаалалтын эрх зүй, зохион байгуулалтын үндэс бүрдээгүй зэрэг нь ноцтой хүндрэл учруулж байна⁵⁷.

БХЭШХ-ийн эрдэмтэдийн туурвисан “Батлан хамгаалах стратеги” хэмээх бүтээлд бэлтгэл офицер, цэргийн бэлтгэл үүрэгтний дайчилгааны бэлтгэл сургалтыг боловсронгуй болгохын тулд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагатай гэж үзсэн байна. Үүнд⁵⁸:

1. Бэлтгэл офицер, цэргийн бэлтгэл үүрэгтний дайчилгааны бэлтгэл сургалт явуулах жил бүрийн нэгдсэн төлөвлөгөөг БХЯ эрхлэн боловсруулж, Засгийн газарт оруулан баталгаажуулж, шаардагдах зардлыг Зэвсэгт хүчний цэргийн нэгтгэл, ангиуд, Үндэсний Батлан хамгаалахын их сургуулийн хийгээд аймаг, нийслэлийн Тамгын газрын жил бүрийн төсөвт суулгаж, хэрэгжилтэд хяналт тавьж байх журамд шилжих;

2. Бэлтгэл офицерын цэргийн мэргэжил олгох зорилтод сургалтанд ҮБХИС-ийн гүйцэтгэх үүргийг нэмэгдүүлэх талаар удирдлага, зохицуулалтын тодорхой арга хэмжээ авах;

3. Иргэний их, дээд сургуулийн ахлах ангийн оюутан, төгсөгч нарыг сайн дурын үндсэн дээр чухал мэргэжлийн офицерын албан тушаалд оногдуулан бүртгэгдэж, нарийн мэргэжлийн бэлтгэл офицeroор бэлтгэдэг тогтолцоонд шилжих асуудлыг судалж үзэх;

4. Өндөр хөгжилтэй орнуудад зохион байгуулж байгаа дайчилгааны бэлтгэл нөөцийн бүрэлдэхүүнийг бэлтгэдэг туршлагыг орон нутгийн хамгаалалтын тогтолцоотой нягт уялдуулах аймаг, нийслэл (бүсийн тулгуур төв)-д цэргийн бэлтгэл нөөцийн бүрэлдэхүүний дайчилгааны сургалтын нэгжийг шинээр байгуулан ажиллуулах саналыг анхаарч авч үзэх.

⁵⁷ Ц.Дашзэвэг. “Батлан хамгаалах бодлого, зэвсэгт хүчний байгуулалт, удирдлагын шинэчлэл”. УБ., 2019. т124

⁵⁸ “Батлан хамгаалах стратеги”. БХЭШХ.2019. т381-382

Эдгээр ажил, арга хэмжээг улс орны эдийн засгийн боломж, батлан хамгаалах хэрэгцээ, шаардлагад нийцүүлэн эрэмбэлэн хэрэгжүүлснээр бэлтгэл офицер, цэргийн бэлтгэл үүрэгтний эх орноо батлан хамгаалах бэлтгэлжилтийг чанарын шинэ төвшинд гаргах болно.

Дүгнэлт

“Хүн ам зүй болон батлан хамгаалах бодлогын үндэс, уялдаа холбоо” хэмээх нэгдүгээр бүлэгт хүн ам зүйн бодлогын агуулга, түүнд нөлөөлөх тулгуур гурван бодлого, Монгол Улсын хүн ам зүйн бодлогын түүхэн хөгжил болон батлан хамгаалах бодлого, тогтолцоо, батлан хамгаалах бодлогын чиглэлүүдийг судалсны зэрэгцээ хүн ам зүй, батлан хамгаалах бодлого хоорондын уялдаа холбоог авч үзээд дараах дүгнэлтэд хүрэв. Үүнд:

1. Хүн ам бол улс орны оршин тогтнох, нийгмийн хөгжил, өөрчлөлтийн гол үндэс болдог учраас хүн ам зүйн асуудал нь улсын нийгэм, эдийн засаг, соёлын асуудлуудтай нягт холбоотой явагддаг. Иймээс хүн ам зүйн шинжлэх ухаан нь бусад шинжлэх ухаантай уялдаатай судлагддаг байна.

2. Хүн ам зүйн бодлого (хүн амын нас, хүйсийн бүтцэд)-д төрөлт, нас баралт, шилжилт хөдөлгөөн буюу нутагшилт байршилтын талаарх бодлого ихээхэн нөлөө үзүүлдэг.

3. Монгол Улс нь одоогоос 2000 гаруй жилийн өмнөөс хүн амаа тоолж, бүртгэлжүүлж эхэлсэн байсан бол энэ нь XIII зууны үеэс боловсронгуй болж ирсэн хэдий ч их байлдан дагуулалтын үр дүнд XV зууны эхэн үеэс хүн амын цэгцтэй бодлого суларч, XVII зууны сүүлчээр Монгол Улс Манжийн эрхшээлд орсноор төрийн уламжлалт бодлого алдагдсан.

1921 онд анхны тооллогоор хүн ам 738,2 мянга байсан бол 1956 онд олон улсын аргачлалыг хэрэглэн явуулсан тооллогоор 845,5 мянга, 1963 онд 1 сая, 1989 онд 2 сая, 2015 онд 3 сая дахь иргэн мэндэлсэн. Хүн амын жилийн дундаж өсөлт 1969-1979 онд хамгийн их 3.25 байсан бол 1990 оны үед хамгийн бага 1.4 болж огцом буурсан нь тухайн үеийн нийгэм, эдийн засгийн байдалтай холбоотой юм.

4. Батлан хамгаалах бодлого нь улс төр, эдийн засаг, нийгэм, эрх зүй, цэрэг-техник, оюун санааны агуулга бүхий үйл ажиллагааны хүрээг хамарсан ихээхэн өргөн утга агуулгатай. Иймээс Батлан хамгаалах бодлогын үндэс баримт бичигт улс орноо батлан хамгаалах бодлогын улс төрийн, эдийн засгийн, нийгмийн, эрх зүйн болон цэргийн чиглэлийг тодорхойлж өгсөн нь батлан хамгаалах зорилт, үйл ажиллагаа зөвхөн цэргийн төдийгүй улс орны бүх салбарыг хамарсан нэгдмэл

удирдлага, төлөвлөлт, зохион байгуулалт, зохицуулалтын цогц арга хэмжээ болохыг илэрхийлж өгсөн.

5. Батлан хамгаалах бодлого нь батлан хамгаалах тогтолцоогоор дамжин хэрэгждэг бөгөөд тогтолцооны үндэс нь төр, захиргааны байгууллагууд, нийт иргэдийн оролцоонд тулгуурласан орон нутгийн хамгаалалт, мэргэжлийн цэрэгт суурилсан зэвсэгт хүчин, нэгдмэл удирдлага, төлөвлөлт бүхий дайчилгаа болж байна.

6. Аливаа улсын зэвсэгт хүчинд алба хааж буй иргэд нь эрүүл чийрэг бие бялдартай, орчин үеийн техник, цэргийн зэвсэглэлийг эзэмших чадвартай, сэтгэлзүйн хувьд зориг хатуужилтай байснаар байлдааны болон тусгай үүрэг гүйцэтгэнэ. Иймээс батлан хамгаалах асуудалд хүн амын өсөлт, бүтэц (эрэгтэй хүүхдийн), боловсрол, эрүүл мэнд, бие бялдрын болон оюун санааны төлөвшлийг цогцоор авч үзэх шаардлагатай гэдэг нь судалгаанаас харагдаж байна.

7. “Төрөөс хүн амын хөгжлийн талаар баримтлах бодлого” болон “Монгол Улсын батлан хамгаалах бодлогын үндэс” баримт бичгүүдийн холбогдох заалтуудыг харьцуулан судлахад батлан хамгаалах бодлогын нийгмийн чиглэлүүд хүн ам зүйн бодлоготой уялдан хэрэгжих боломжтой нь харагдаж байна. Бодлогын баримт бичгүүдийн уялдаа холбоог ханган ажиллавал хөдөө, орон нутагт иргэд тогтвор суурьшилтай ажиллаж, амьдрах таатай орчин, нөхцөл бүрдэж, хүн амын шилжилт хөдөлгөөн, байршлын харьцаа тэнцвэртэй болох бөгөөд орон нутгийн хамгаалалтыг зохион байгуулах, батлан хамгаалах чадавхыг дээшлүүлэх аятай нөхцөл бүрдэнэ хэмээн үзэж байна.

8. Иргэдэд цэрэг-эх оронч үзэл хүмүүжил төлөвшүүлэх, тэднийг эх орноо батлан хамгаалахад бэлтгэх арга хэмжээний гол үндэс нь сургалт юм. Тухайлбал, оюутан цэргийн, бэлтгэл офицерийн, цэргийн бэлтгэл үүрэгтний сургалт, бэлтгэлийг батлан хамгаалах хэрэгцээ шаардлагад нийцүүлэн зохион байгуулж байна. Эдгээр сургалтыг улсын эдийн засгийн боломж, орон нутгийн хамгаалалтын тогтолцоотой уялдуулан тодорхой үечлэлээр, оновчтой зохион байгуулах нь чухал юм.

ХОЁРДУГААР БҮЛЭГ. МОНГОЛ УЛСЫН ХҮН АМ ЗҮЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ, ТҮҮНИЙ БАТЛАН ХАМГААЛАХ БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТЭД ҮЗҮҮЛЖ БУЙ НӨЛӨӨЛЛИЙН ШИНЖИЛГЭЭ, УЯЛДАА ХОЛБООГ САЙЖРУУЛАХ АРГА ЗАМ

2.1. Монгол Улсын хүн ам зүйн бодлого, үйл ажиллагааны хэрэгжилтийн өнөөгийн байдал

Улс орны хөгжил, дэвшил хүн амынх нь тооноос ихээхэн хамаардаг билээ. Хүн ам бол нэг талаар хэрэглэгч, нөгөө талаар баялагийг бүтээгч юм. Тийм болохоор улс орон бүр өөрийн онцлогт тохирсон хүн ам зүйн бодлоготой байдаг.

Улс орнууд төрөөс хүн ам зүйн талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэх үйл ажиллагаагаа залгамж чанартай, үе шаттайгаар явуулж, түүний хэрэгжилтийн явцад хяналт шалгалт хийж, үнэлэн дүгнэж, сайжруулж байдаг учиртай. Ялангуяа улсын хөгжил дэвшлийн тулгуур үндэс болсон хүн амын эрчимтэй өсөлтийн түвшинг эдийн засаг, боловсрол, эрүүл мэндтэй нягт холбон бодлогоор зохицуулж, эерэг үр дүнтэй байлгах асуудлыг төр засаг үйл ажиллагааныхаа тэргүүлэх чиглэлд байнга байлгах нь чухал юм.

Монгол Улсын баримталж буй хүн ам зүйн бодлого, үйл ажиллагааны хэрэгжилтийг бодлогын баримт бичгийн шинжилгээ; хүн амын нас, хүйс; суурин хүн ам; дундаж наслалт; нас баралт; төрөлт; шилжилт хөдөлгөөн; эрүүл мэнд, боловсрол болон гэсэн хэсэгтэйгээр судлан шинжлэв.

Бодлогын баримт бичигт хийсэн шинжилгээ

Хүн ам зүйн талаарх бодлогыг “Монгол Улсын Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал– 2030” (2016-2030), “Монгол Улсын төрөөс хүн амын хөгжлийн талаар баримтлах бодлого” (2016-2025), “Эрэгтэйчүүдийн эрүүл мэнд стратеги”, (2014-2018) “Жендэрийн эрх тэгш байдлыг хангах үндэсний хөтөлбөр” (2017-2021) зэрэг баримт бичгүүдийн хүрээнд шинжилгээ хийлээ.

Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030

Монгол Улсын Засгийн газраас 2016 онд “Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”-ийг баталж, хүн амын эрүүл мэндийн чанартай хүртээмжтэй тогтолцоог сайжруулах чиглэлээр онцгойлон анхаарлаа хандуулсан. Юуны түрүүнд урьдчилан сэргийлэх үндэсний тогтолцоог сайжруулснаар дундаж наслалтыг уртасгахаар төлөвлөсөн. Дундаж наслалтыг уртасгахад доорх 3 үе шат бүхий системтэй арга хэмжээг авч хэрэгжүүлснээр 2030 он гэхэд хүн амын дундаж наслалтыг 78-д хүргэх зорилтыг дэвшүүлсэн байна. Үүнд:

I үе шат 2016-2020 онд “... эрт илрүүлэлтийн тогтолцоо, лавлагаа лабораторийг бэхжүүлж, хүн амын *дундаж наслалтыг 71-д хүргэх*, II үе шат 2021-2025 онд “...нас баралтын эрсдэлт хүчин зүйлийг бууруулж, хүн амын *дундаж наслалтыг 74-д хүргэх*, , III үе шат 2026-2030 онд “...нийт сумдыг хамарсан алсын зайн оношилгооны сүлжээг бий болгож, *дундаж наслалтыг 78-д хүргэх*⁵⁹-ээр шат дараатай, системтэй арга хэмжээг авах зорилтыг дэвшүүлсэн байна.

Тогтвортой хөгжлийн зорилтын үзэл баримтлалд дундаж наслалтыг 78-д хүргэх зорилт дэвшүүлсэн нь эмэгтэйчүүдийн хувьд одоогийн түвшин 75-аас 78 хүргэхэд боломжтой боловч эрэгтэйчүүдийн хувьд 65-78 хүргэхэд нийт 13 насаар дундаж наслалтыг нэмэгдүүлэх шаардлагатай учраас энэхүү зорилт нь эрэгтэйчүүдийн хувьд дорвитой арга хэмжээ авч, бүх бодлого хөтөлбөрийн уялдааг сайтар хангаж, хэрэгжилтийг эрчимжүүлснээр мөн эрэгтэйчүүдийн онцлог, ялгаатай байдлыг харгалзан, түлхүү эрэгтэйчүүд рүү чиглэсэн үйл ажиллагааг төлөвлөөд, бодит байдалтай уялдуулах шаардлагатай нь харагдаж байна.

Мөн зонхилон тохиолдох халдварт бус өвчин, тэдгээрийн эрсдэлт, хүчин зүйлийн тархалт болон сэргийлж болох нас баралтыг хувь хүн гэр бүл, хамт олон, байгууллагын идэвхтэй, оролцоотой, нэгдмэл үйл ажиллагаанд тулгуурлан бууруулахаар 3 үе шаттай арга хэмжээ авч ажиллахаар тусгасан байна.Үүнд:

I үе шат 2016-2020 онд “...10 000 хүн амд ногдох зүрх судасны өвчлөлөөс шалтгаалсан нас баралтыг 17.4, хорт хавдраас шалтгаалсан нас баралтыг 10.5 хүртэл бууруулах, II үе шат 2021-2025 онд “...10 000 хүн амд ногдох зүрх судасны өвчлөлөөс шалтгаалсан нас баралтыг 16, хорт хавдраас шалтгаалсан нас баралтыг 9 хүртэл бууруулах, III үе шат 2025-2030 онд “...10 000 хүн амд ногдох зүрх судасны өвчлөлөөс шалтгаалсан нас баралтыг 14, хорт хавдраас шалтгаалсан нас баралтыг 8 хүртэл бууруулах⁶⁰-аар тус тус зорилтыг дэвшүүлсэн байна.

2018 онд нийт нас баралтын 43 хувь нь зүрх судасны тогтолцооны өвчин, 31 хувь нь хавдар, 9 хувь нь хоол боловсруулах тогтолцооны өвчин, 5 хувь нь амьсгалын тогтолцооны өвчин, 12 хувийг бусад өвчлөл эзэлж байсан. Нас баралтын хамгийн том шалтгаан болох зүрх судасны тогтолцооны өвчний улмаас нас барсан хүмүүсийн 58 хувь эрэгтэйчүүд, 42 хувь нь эмэгтэйчүүд байна. Нас барсан хүмүүсийн насны хувьд эрэгтэйчүүд эмэгтэйчүүдээс илүү залуу насандаа байгаа бөгөөд эрэгтэйчүүдийн дийлэнх нь 45-с дээш настай, эмэгтэйчүүдийн дийлэнх нь 60-с дээш

⁵⁹ “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”-ийн 2.2.2 заалтын Зорилт 1. УИХ-ын 2016 оны 19 дүгээр тогтоол.

⁶⁰ Мөн үзэл баримтлалын. Зорилт 3

настай байгаагаас харагдаж байна. Нөгөө талаас эрэгтэйчүүдийн 42 хувь нь хөдөлмөр эрхлэх насандаа, эмэгтэйчүүдийн 17 хувь нь хөдөлмөр эрхлэх насандаа зүрх судасны тогтолцооны өвчний улмаас нас барсан байна. Нас баралтын зонхилох өвчлөлийн хоёр дахь гол шалтгаан болох хавдраас шалтгаалсан нас баралтын 55 нь хувь эрэгтэй, эрэгтэй, 45 хувь нь эмэгтэй хүмүүс буюу эрэгтэйчүүд эмэгтэйчүүдээс 1.2 дахин их байна⁶¹. Монгол эрчүүдийн хооллолт, хорт зуршил, буруу зан үйлийн улмаас өвчлөл нас баралт өндөр байна. Иймээс эрчүүдийг эрүүл мэндэд нь сөрөг нөлөө бүхий өндөр эрсдэлтэй зан үйлээс зайлсхийх, хорт муу зуршлыг өөрчилж, тэдэнд чиглэсэн эрүүл мэндийн боловсролын хөтөлбөр, төслөөр дамжуулан, тэдний тогтсон ойлголтыг өөрчилж, эрүүл мэндийн тусламж үйлчилгээ эрэлхийлдэг болгох шаардлагатай байна.

Төрөөс хүн амын хөгжлийн талаар баримтлах бодлого

УИХ-ын 2004 оны 21 дүгээр тогтоолоор “Төрөөс хүн амын хөгжлийн талаар баримтлах бодлого”-ыг баталж, /2004-2007 он; 2008-2011 он; 2012-2015 он/ 3 үе шаттайгаар хэрэгжүүлэхээр заасан боловч хэрэгжилтийг гаргаагүй.

Харин УИХ-ын 2014 оны 11 дүгээр сарын 28-ны өдрийн чуулганаар “Монгол Улсын төрөөс хүн амын хөгжлийн талаар баримтлах бодлого”-ыг батлан гаргасан байдаг. Энэхүү баримт бичигт “Бодлогоор хүн амын хөгжлийн асуудлыг эдийн засаг, нийгмийн хөгжилтэй холбон цогц байдлаар олон улсын гэрээ хэлэлцээр болон үндэсний зорилтуудтай уялдуулан шийдэхийг зорино” хэмээн заасан.

*“Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030” баримт бичиг 2016 онд батлагдсантай уялдан *Засгийн газрын 2016 оны 261 дүгээр тогтоолоор “Төрөөс хүн амын хөгжлийн талаар баримтлах бодлого”-ыг шинэчлэн баталсан.**

2016-2025 он хүртэл баримтлах хүн амын хөгжлийн бодлогын хэрэгжилтийн үр дүнг тооцож үнэлэхээр тусгагдсан байгаа нь өмнөх хоёр бодлогын баримт бичгээс дэвшилттэй байна.

*Энэхүү баримт бичигт хүн амын тогтвортой өсөлтийг хангах зорилтын хүрээнд дундаж наслалтыг *2025 он гэхэд 74-т* хүргэхээр зорилтыг дэвшүүлсэн байгаа нь “Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030” баримт бичгийн хэрэгжилттэй нягт уялдсаныг харуулж байна. Мөн тус бодлогын хүрээнд эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн дундаж наслалтын зөрүүтэй байдалд буюу нас баралтад гол нөлөөлж буй халдварт болон халдварт бус өвчлөлд нөлөөлж байгаа эрсдэлт хүчин зүйлийг бууруулах, өвчлөлийг эрт илрүүлж, оношлох, тархалт өвчлөлөөс урьдчилан сэргийлэх үндэсний тогтолцоог бүрдүүлэн оношилгоо, эмчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэн*

⁶¹ Наоми Китахара, А. Ариунзаяа. “Монгол эрчүүдийн хорт зуршлын хор хөнөөл” УБ., 2018

өвчлөл нас баралтын эрсдэлт хүчин зүйлийг бууруулахаар зорилтыг тавьсан байна. Тус бодлогод эрчүүдийн эрүүл мэндийн асуудлыг онцгойлон анхааралдаа авсан болох нь ажиглагдаж байна. Эрчүүдийн эрүүл мэндийн асуудлыг төр анхааралдаа авч, тусгайлан бодлогын зорилт болгон 4.1.13-д “эрэгтэйчүүдэд зориулсан эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг өргөжүүлж, эрэгтэйчүүдийн дундаж наслалтыг нэмэгдүүлэх”⁶²-ийг тусгасан нь дэвшилтэт алхам болсон байна. Харин эмэгтэйчүүд рүү чиглэсэн бодлогын зорилтын хувьд 4.1.3 буюу “эх, хүүхдийн эндэгдлийг 100000 амьд төрөлтөд 26-аас 12-д хүргэх, нялхсын эндэгдлийг 1000 амьд төрөлтөд 15-аас 11 хүртэл болгож бууруулах”⁶³ зорилт дэвшүүлсэн байна.

Мөн түүнчлэн хүн амын эрүүл, идэвхтэй насжилтыг дэмжих чиглэлээр нийгмийн даатгалын тогтолцоог хөгжүүлэх, эдийн засгийн идэвхтэй хүн амын нийгмийн даатгалд хамрагдалтыг 95 хувьд хүргэх, ахмад настан бүрийг тэтгэвэр, орлогын баталгаагаар хангах, тэдэнд зориулсан эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх, эрүүл идэвхтэй насжилтын орчныг бүрдүүлэх зорилтуудыг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

Энэхүү хүн амын хөгжлийн талаар баримтлах бодлогод дундаж наслалтыг нэмэгдүүлэхэд эрүүл мэнд талаас нь нөлөөлж буй эрсдэлт хүчин зүйлсийг бууруулахад эрүүл мэндээс гадна, нийгэм, эдийн засгийн хүчин зүйлс болох боловсрол, хөдөлмөр эрхлэлт гэх олон асуудал нөлөөлж байгааг цогцоор нь авч үзэх шаардлагатай байна.

Эрэгтэйчүүдийн эрүүл мэнд стратеги

Монгол Улсын Засгийн газраас эрэгтэйчүүдийн эрүүл мэндийн асуудлыг анхааралдаа авч, хүн амын мэдлэг, хандлагыг өөрчлөхийн тулд Эрүүл мэндийн сайдын 2014 оны 03 дугаар сарын 17-ны өдрийн 84 дүгээр тушаалаар Эрэгтэйчүүдийн эрүүл мэнд стратеги (2014-2018)-ийг батлуулсан.

Монгол Улсын эрэгтэйчүүдийн эрүүл мэндийн өнөөгийн байдал, тулгамдсан асуудлуудыг эрэгтэйчүүдийн нас баралт өндөр; архи, тамхины хэрэглээ, хөдөлгөөний хомсдол, буруу хооллолт зэрэг амьдралын буруу хэв маяг, дадал зуршил эрэгтэйчүүдэд илүү байгаагаас халдварт бус өвчинд өртөмтгий; эрэгтэйчүүдийн эрүүл мэндийн мэдлэг хомс, тусламж эрэлхийлэх хандлага сул; эрэгтэйчүүдийн эрүүл мэндийн өвөрмөц эрэлт хэрэгцээг хангасан нарийн мэргэжлийн тасаг, кабинет, мэргэжлийн эмчийн хангамж хувийн хэвшлийн ганц нэг эмнэлгийг эс тооцвол нэн

⁶² “Төрөөс хүн амын хөгжлийн талаар баримтлах бодлого”. Засгийн газрын 2016 оны 261 дүгээр тогтоолын 4.1.13 дахь заалт

⁶³ Мөн тэнд 4.1.3 дахь заалт

хангалтгүй; эрэгтэйчүүдийн эрүүл мэнд, түүнд нөлөөлөгч хүчин зүйлсийн талаарх нарийвчилсан судалгаа, мэдээлэл хангалтгүй гэж тодорхойлсон байна.

Тус стратегийн хүрээнд үндсэн 4 зорилтыг дэвшүүлэн нийт 59 үйл ажиллагааг төлөвлөн хэрэгжүүлжээ.

Зорилт 1: Бүх шатны бодлого боловсруулагчид, эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэгчид, байгууллага хамт олон, гэр бүл болон эрэгтэйчүүдэд өөрсдөд нь эрэгтэйчүүдийн эрүүл мэндийн асуудлын чухлыг сурталчлах;

Зорилт 2: Эрэгтэйчүүдийн эрүүл мэндийн өвөрмөц хэрэгцээнд нийцсэн гэр бүл, хамт олонд тулгуурласан эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг хөгжүүлэх;

Зорилт 3: Эрүүл мэндийн боловсрол олгох, эрүүл мэндийг дэмжих үйл ажиллагааг эрчимжүүлэх замаар эрэгтэйчүүдийн эрүүл мэндийн эрсдэлт зан үйлийг өөрчлөх;

Зорилт 4: Эрэгтэйчүүдийн эрүүл мэндийн чиглэлээрх судалгаа шинжилгээг өргөжүүлэх замаар бодлогын нотолгоо бий болгох гэсэн зорилтуудын хүрээнд үйл ажиллагааг хэрэгжүүлсэн байна.

Өнөөгийн байдлаар энэхүү стратегийн хэрэгжилтийн талаар үнэлэлт, дүгнэлт өгсөн баримт, мэдээ байхгүй байна.

Иймд энэхүү стратегийн хэрэгжилтэд үнэлэлт, дүгнэлтийг олон нийтэд ил болгож, цаашид хоёрдугаар үе шатыг хэрэгжүүлэхдээ нийгэм, эдийн засаг, соёлын хүчин зүйлс, жендэрийн хэвшмэл ойлголтыг өөрчлөх архи тамхины хэрэглээг буруулахад түлхүү анхаарч, урьдчилан сэргийлэх үйлчилгээнд эрэгтэйчүүдийг тогтмол хармуулахад анхаарч ажиллах шаардлагатай харагдаж байна.

Жендэрийн эрх тэгш байдлыг хангах үндэсний хөтөлбөр 2017-2021

Монгол Улс эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн тэгш эрхийг баталгаажуулах, тэгш байдлыг хангах асуудлаар хууль тогтоомж, бодлого шийдвэрийг батлан гаргаж нэлээдгүй ахиц дэвшил гаргаж байна. Тухайлбал, Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийг 2011 онд Улсын Их Хурлаас баталснаар жендэрийн эрх тэгш байдлыг ханган хэрэгжүүлэх эрх зүйн орчин бүрдүүлсэн юм.

Тогтвортой хөгжлийн зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд жендэрийн мэдрэмжтэй бодлого, төлөвлөлтийг нэвтрүүлэх, жендэрийн эрх тэгш байдлын талаарх хэвшмэл ойлголтыг өөрчлөхөд чиглэсэн цогц арга хэмжээгээр хуулийн хэрэгжилтийг хангах, улс төр, эдийн засаг, нийгэм, соёл, гэр бүлийн харилцаанд жендэрийн тэгш байдлыг хангах зорилгоор Засгийн газрын 2017 оны 129 дүгээр тогтоолоор “Жендэрийн эрх тэгш байдлыг хангах үндэсний шинэ хөтөлбөр” баталсан.

Дэлхийн эдийн засгийн форумаас эрхлэн гаргадаг эдийн засаг, улс төр, боловсрол, эрүүл мэндийн салбарын шалгуур үзүүлэлт бүхий Жендэрийн зөрүүтэй

байдлын тайланд дурдсанаар манай улсын жендэрийн хөгжлийн индекс 2006 онд 0.682 байсан бол бага зэргийн ахиц гарч, 2013 онд 0.720 гэсэн индексээр 136 орноос 33 дугаар байранд орсон байна. Жендэрийн зөрүүтэй байдлын гол асуудал болон тавигдаж байсан хөвгүүдийн сургууль завсардалт буурч, их, дээд сургуульд суралцагчдын дотор эрэгтэйчүүдийн эзлэх хувь нэмэгдэн, эрэгтэйчүүдийн эрүүл мэндийн асуудалд хандах Засгийн газар, олон нийтийн хандлага сайжирч байна.

Цаашид нийгэмд эрэгтэйчүүдийн өмнө тулгамдаад буй асуудлыг шийдвэрлэхэд энэхүү үндэсний хөтөлбөрт тусгасан “эрэгтэйчүүдэд зориулсан эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх тасаг, кабинетийг бүх аймаг, дүүргийн эрүүл мэндийн төвд ажиллуулж, хүний нөөц, техник, тоног төхөөрөмжөөр хангах⁶⁴; эрүүл мэндийн боловсрол олгох, эрүүл мэндийг дэмжих үйл ажиллагаанд жендэрийн мэдрэмжтэй бодлогыг хэрэгжүүлэх чадавх олгох цуврал сургалт зохион байгуулах⁶⁵; эрэгтэйчүүд, ялангуяа 18-35 насныханд зориулан жендэрийн хэвшмэл ойлголтыг арилгах, үндэсний уламжлалт, дэвшилтэт зан үйл, хандлагыг төлөвшүүлэх чиглэлээр сургалт зохион байгуулж, эрэгтэйчүүдийн оролцоог дэмжсэн аян, төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх⁶⁶; тэдний хорт зуршил, хандлага, мэдлэг, дадал, амьдралын хэв маягийн талаар нарийвчилсан судалгааг хийж, олон нийтийн ойлголтыг өөрчлөхөд чиглэсэн ажлыг өрнүүлэх шаардлагатай байна. Түүнчлэн салбар дундын хамтын ажиллагааг өрнүүлж, тэдгээрийн уялдаа холбоог сайжруулж, салбар дундын жендэрийн стратеги болон орон нутгийн жендэрийн дэд хөтөлбөрүүдэд тусгасан эрэгтэйчүүдийн эрүүл мэнд, хэвшмэл ойлголттой холбоотой ажлуудыг эрчимжүүлж, эргэх холбоог үүсгэж, хяналт тавьж ажиллах шаардлага байгаа нь ажиглагдаж байна.

Манай улс жендэрийн тэгш байдлын бодлоготой болсон нь ихээхэн сайшаалтай. Учир нь Дэлхийн банкнаас Хөгжлийн бодлогын холбооноос жил бүр бодлогын болон институтын үнэлгээг хийдэг. Тус үнэлгээгээр хөгжлийн бодлогын холбооны гишүүн орнуудын ядуурлыг бууруулах, тогтвортой өсөлтийг дэмжихэд чиглэсэн бодлого, институт тогтолцоог үнэлж, хөгжлийн тусламжийг үр дүнтэй ашиглаж чадах эсэх талаарх мэдээллийг өгдөг байна. 2018 оны бодлогын болон институтын үнэлгээгээр Монгол Улсыг 3.4 гэж үнэлсэн нь түүнд хамрагдсан бусад улсуудын дундаж болох "3.2" гэсэн үзүүлэлтээс өндөр гарчээ. Манай улсын хувьд тус

⁶⁴ “Жендэрийн эрх тэгш байдлыг хангах үндэсний шинэ хөтөлбөр”-ийн 3.1.10 дахь заалт. Засгийн газрын 2017 оны 129 дүгээр тогтоол

⁶⁵ Мөн хөтөлбөрийн 3.1.12 дахь заалт

⁶⁶ Мөн хөтөлбөрийн 3.3.13 дахь заалт

үнэлгээ 2016 онд 3.2, 2017 онд 3.3 байсан байна⁶⁷. Ийнхүү тус үнэлгээ өндөр гарахад жендэрийн тэгш байдал, хүний нөөцийг чадавхжуулах зэрэг нийгмийн хүртээмжтэй байдалд чиглэсэн бодлого нөлөөлсөн байна.

Хүн амын нас, хүйсийн бүтэц

Хүн амын бүтцэд хүн амын нас, хүйсийн байдал чухал байр суурь эзэлдэг бөгөөд эдгээр үзүүлэлтүүдийн өөрчлөлт, түүний шалтгаан зэрэг нь тухайн улс орон, бүс нутгийн нийгэм, эдийн засгийн хөгжлийн байдалтай холбоотой байна.

Хүн амын нас, хүйсийн бүтэц төрөлт, нас баралт, шилжих хөдөлгөөний нөлөөгөөр өөрчлөгдөж байна. Өөрөөр хэлбэл хүн амын төрөлт, нас баралт буурч, дундаж наслалт нэмэгдсэнээр залуу насны хүн амын хувийн жин нэмэгдэнэ.

Монгол Улсын хүн ам 2018 онд 3 сая 238.4 мянга болж, өмнөх оныхоос 60.5 мянган хүн буюу 1.9 хувиар өссөн байна. Хүн амын 49.2 хувь нь эрэгтэйчүүд, 50.8 хувь нь эмэгтэйчүүд байгаа ба хүйсийн харьцаа буюу 100 эмэгтэйд ногдох эрэгтэйчүүдийн тоо 97 байна. Насны бүтцээр авч үзвэл 15 хүртэлх насны хүүхэд 31.2 хувийг, 15- 64 насны хүн ам 64.7 хувийг, 65-аас дээш насны хүн ам 4.1 хувийг тус тус эзэлж байна.⁶⁸.

Монгол Улсын хүн амын тоог нас, хүйсний ангиллаар ялгаж, 4 жилийн байдлаар хүснэгтэд үзүүллээ.

⁶⁷ Салбаруудын жендэрийн бодлогын эмхэтгэл. ХНХЯ, Жендэрийн Үндэсний хороо, Азийн хөгжлийн банк. УБ., 2018 он

⁶⁸ Эрүүл мэндийн үзүүлэлт-2018. ДЭМБ, Эрүүл мэндийн төв. УБ., 2019


Монгол Улсын хүн амын тоо (хүйс, насны бүлгээр)⁶⁹

Насны бүлэг	Хүйс	2015	2016	2017	2018
Бүгд	Нийт	3,057,778.	3,119,935.	3,177,899.	3,238,479.
	Эрэгтэй	1,503,612.	1,533,983.	1,562,370.	1,591,848.
	эмэгтэй	1,554,166.	1,585,952.	1,615,529.	1,646,631.
0-4	Нийт	386,866.	394,514.	393,984.	391,125.
	Эрэгтэй	198,115.	201,936.	202,282.	200,715.
	эмэгтэй	188,751.	192,578.	191,702.	190,410.
5-9	Нийт	298,808.	322,575.	341,311.	358,379.
	Эрэгтэй	152,485.	164,768.	174,304.	183,100.
	эмэгтэй	146,323.	157,807.	167,007.	175,279.
10-14	Нийт	219,332.	220,429.	232,601.	252,548.
	Эрэгтэй	111,675.	112,576.	118,653.	128,855.
	эмэгтэй	107,657.	107,853.	113,948.	123,693.
15-19	Нийт	239,910.	236,400.	233,001.	228,402.
	Эрэгтэй	121,780.	119,966.	118,408.	116,247.
	эмэгтэй	118,130.	116,434.	114,593.	112,155.
20-24	Нийт	267,844.	255,144.	244,980.	244,971.
	Эрэгтэй	135,073.	128,877.	123,701.	123,951.
	эмэгтэй	132,771.	126,267.	121,279.	121,020.
25-29	Нийт	313,709.	314,540.	310,730.	294,550.
	Эрэгтэй	157,118.	157,575.	155,846.	147,740.
	эмэгтэй	156,591.	156,965.	154,884.	146,810.
30-34	Нийт	263,538.	273,997.	283,360.	295,098.
	Эрэгтэй	130,591.	136,030.	140,867.	146,913.
	эмэгтэй	132,947.	137,967.	142,493.	148,185.
35-39	Нийт	232,634.	236,622.	241,307.	244,225.
	Эрэгтэй	114,492.	116,417.	118,861.	120,394.
	эмэгтэй	118,142.	120,205.	122,446.	123,831.
40-44	Нийт	208,439.	214,112.	217,532.	221,914.
	Эрэгтэй	100,801.	103,502.	105,370.	107,578.
	эмэгтэй	107,638.	110,610.	112,162.	114,336.
45-49	Нийт	178,411.	181,405.	186,765.	191,780.

⁶⁹ Монгол Улсын хүн амын тоо, насны бүлэг хүйсээр. Статистикийн мэдээллийн нэгдсэн сан.
http://www.1212.mn/tables.aspx?TBL_ID=DT_NS0_0300_003V1

	Эрэгтэй	84,610.	86,238.	88,673.	91,409.
	эмэгтэй	93,801.	95,167.	98,092.	100,371.
50-54	Нийт	152,601.	159,075.	161,016.	164,214.
	Эрэгтэй	71,155.	74,040.	74,828.	76,170.
	эмэгтэй	81,446.	85,035.	86,188.	88,044.
55-59	Нийт	115,125.	119,888.	128,739.	135,542.
	Эрэгтэй	51,524.	53,671.	57,844.	61,015.
	эмэгтэй	63,601.	66,217.	70,895.	74,527.
60-64	Нийт	65,496.	73,940.	79,856.	87,790.
	Эрэгтэй	28,448.	32,125.	34,356.	37,601.
	эмэгтэй	37,048.	41,815.	45,500.	50,189.
65-69	Нийт	43,089.	43,711.	47,326.	50,307.
	Эрэгтэй	17,781.	17,837.	19,410.	20,586.
	эмэгтэй	25,308.	25,874.	27,916.	29,721.
70+	Нийт	71,976.	73,583.	75,391.	77,634.
	Эрэгтэй	27,964.	28,425.	28,967.	29,574.
	эмэгтэй	44,012.	45,158.	46,424.	48,060.

Дээрх хүснэгтээс харахад 0-4 нас болон 15-29 насны хүн амын тоо 2015 оноос буурч байгаа бол бусад насны хүн амын тоо жил тутам өсөлттэй, ялангуяа 55-аас дээш насныхан жилд 2-8 мянгаар өссөн нь *нэгд*, цэргийн насны залуучуудын тоо буурч байгааг, *хоёрт*, насжих үйл явц хурдасч байгааг, *гуравт*, хүн амын дундаж нас нэмэгдэж байгааг харуулж байна.



2.1 дүгээр зураг. Нас, хүйсийн суварга, бодит тоогоор, /2008, 2018он/⁷⁰

⁷⁰ Эрүүл мэндийн үзүүлэлт-2018. ДЭМБ, Эрүүл мэндийн төв. УБ., 2019

Хүн амын нас, хүйсийн суваргыг харахад 2008 онд 15-19 насныхны хувь их байхад 2018 оны суваргад 15-19 насныхны эзлэх хувь харьцангуй бага байгаа нь 2001-2005 онд төрөлт хамгийн доод түвшинд байсныг харуулж байна.

Мөн энэхүү нас хүйсийн суварга дунд хэсгээрээ аажмаар өргөсч байгаа нь хүн ам идэршиж байгааг харуулж байна. Харин 10-19 насны бүлгийн хүн амын хэсгээр нарийссан байгаа нь 1990 оноос хойш төрөлтийн түвшин эрс буурч байсныг харуулж байна. Түүнчлэн, 0-4 нас болон 5-9 насанд суваргын суурь ихээхэн өргөн болсон нь сүүлийн жилүүдийн төрөлтийн түвшин нэмэгдсэнийг илэрхийлж байна. Манай улс хүн амын хүйсийн харьцаа харьцангуй жигд байдаг улс юм. Тухайлбал, 100 эмэгтэйд 97-103 эрэгтэй ногддог нь насны бүлгээс хамааран янз бүр байдаг. Түүнчлэн, аймаг, нийслэлийн түвшинд тус үзүүлэлт мөн ойролцоо жигд байна. Харин 2011 оноос төрөлт аажим нэмэгдэж байгааг суваргын доод хэсэг хамгийн өргөн байгаагаар харж болно.

Суурин хүн ам

Тухайн засаг захиргааны нэгжид 183 хоног буюу 6 сараас дээш хугацаагаар оршин сууж байгаа хүн амыг суурин хүн амд хамруулдаг. “Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай” хуулиар 15000-аас доошгүй оршин суугчтай, тэдгээрийн дийлэнх нь үйлдвэр, үйлчилгээний салбарт ажилладаг, хот бүрдүүлэгч дэд бүтэц хөгжсөн, өөрийн удирдлага бүхий төвлөрсөн суурин газрыг хот⁷¹, 500-15000 оршин суугчтай, хөдөө аж ахуй, үйлдвэрлэл, аялал, жуулчлал, амралт, сувилал, тээвэр, худалдаа зэрэг салбарын аль нэг хөгжсөн, өөрийн удирдлага бүхий суурин газрыг тосгон⁷² гэж тодорхойлсон. Дээрх хот, тосгоны тодорхойлолтуудад хамрагдахгүй хүн амыг хөдөөгийн хүн ам гэж үздэг.

2010 оны дүнгээр хотод амьдарч буй хүн ам 1798,1 мянга буюу 67,9 хувь, хөдөөд амьдарч буй иргэд 849,3 мянга буюу 32,1 хувь байсан. Энэ нь нийгэм, эдийн засгийн байдал, хөдөөгийн малчин өрхийн амьжиргааны түвшин, дэд бүтэц зэрэг хүчин зүйлүүдээс шалтгаалан хүн амын хот руу шилжих хөдөлгөөн хурдацтайгаар өсөн нэмэгдсэнийг харуулж байна.

Харин 2018 оны жилийн эцсийн байдлаар нийт хүн амын 67.8 хувь буюу 2195,7 мянга нь хот суурин газар, үлдсэн 32.2 хувь буюу 1042,8 мянга нь хөдөө амьдарч байна. Улаанбаатар хотод 1491.3 мянган хүн буюу нийт хүн амын 46.1 хувь нь оршин

⁷¹ Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1 дэх заалт. УБ., 1993

⁷² Мөн тэнд 3 дугаар зүйл. 3.2 дахь заалт

сууж байгаа ⁷³ нь хөдөөнөөс хот руу чиглэсэн шилжилт хөдөлгөөн зогсож, хотоос хөдөө рүү чиглэж байна уу гэх хандлага ажиглагдаж байна.

Хүснэгт 2.2

Суурин хүн амын тоо, хүйс (хот/хөдөөгөөр)

	2014	2015	2016	2017	2018
Бүгд	2,995,949	3,057,778.	3,119,935.	3,177,899.	3,238,479.
Хот	1,990,321	2,096,180.	2,131,823.	2,146,716.	2,197,970.
Хөдөө	1,005,628	961,598.	988,112.	1,031,183.	1,040,509.
Эрэгтэй	1,466,455	1,503,612.	1,533,983.	1,562,370.	1,591,848.
Эмэгтэй	1,529,494	1,554,166.	1,585,952.	1,615,529.	1,646,631.

2014 онд нийт хүн ам 2995.9, үүнээс эрэгтэй 48,9 хувийг, эмэгтэй 51,1 хувийг эзэлж, хүн амын нягтрал 1,9 байсан бол 2018 онд нийт хүн ам 3238.5, үүнээс эрэгтэй 49.2 хувийг, эмэгтэй 50.8 хувийг эзэлж⁷⁴, хүн амын нягтрал 2.0 байна.

Монгол Улсад 2010 оны байдлаар 100 эмэгтэйд 93 эрэгтэй ногдож байсан бол 2018 оны байдлаар 97 эрэгтэй ногдож байна.

Хүснэгт 2.3

Суурин хүн амын насны бүтэц /хувиар/

Насны бүлэг	2014	2015	2016	2017	2018
Бүх хүн ам	100	100	100	100	100
0-14 настай	28,1	29,6	30,1	30,4	29,6
15-64 настай	67,9	66,6	66,1	65,7	66,5
65-түүнээс дээш настай	4,0	3,8	3,8	3,9	3,9

Хүн ам зүйн судалгаанд 0-14 насны хүүхдийн бүх хүн амд эзлэх хувийн жин 35 хувиас дээш бол насны “залуу” бүтэцтэй, 65 ба түүнээс дээш настай хүн амын бүх хүн амд эзлэх хувь 10, түүнээс дээш бол насны бүтцийн хувьд “хөгшин” бүтэцтэй гэж үздэг.

Дээрх хүснэгтийн 2018 оны насны бүтцээс нийт хүн амд 0-14 насны хүүхэд болон 65 ба түүнээс дээш насныханыг харахад манай улсын хүн ам “залуу” бүтэцтэй байна. Гэсэн хэдий ч хамгийн залуу хүмүүсийн эзлэх хувь буурч, ахмад настнуудын эзлэх хувь нэмэгдэж байгаа нь ихээхэн анхаарал татаж байна.

⁷³ Эрүүл мэндийн үзүүлэлт-2018. ДЭМБ, Эрүүл мэндийн төв. УБ.,2019

⁷⁴ Монгол Улсын хүн амын тоо, хүйсээр. 1212.мн


Хүн амын дундаж наслалт

Монгол Улсад эрэгтэйчүүдийн дундаж наслалт нь эмэгтэйчүүдээс 9.67 жилээр богино буюу дэлхийн 187 орноос 15-49 насны 1000 эрэгтэйд ногдох сүүлийн 40 жилийн нас баралтын байдлаар 450-иас дээш үзүүлэлттэй 19 орны нэг байгаа⁷⁵ нь эрчүүдийн эрүүл мэндийг онцгойлон анхаарах шаардлагатайг илтгэн харуулж байна.

Нийт хүн амын 49.2 хувийг эрэгтэйчүүд, 50.8 хувийг эмэгтэйчүүд эзэлж насны бүтцийн хувьд нийт хүн амын 29.6 хувийг 15 хүртэлх насны хүүхэд, 66.5 хувийг 15-64 насны, 3.9 хувийг 65-аас дээш насны хүн ам тус тус эзэлж байна.

2000 оноос хойш дундаж наслалт тууштай нэмэгдэж байгаа ч жендэрийн зөрүү ихэссээр байгаа бөгөөд энэ нь газар зүйн байршлаар ихээхэн ялгаатай байна. Тухайлбал, Орхон, Дорноговь, Дундговь, Өмнөговь, Сэлэнгэ Төв аймгуудад эмэгтэйчүүд улсын дунджаас дээгүүр насалж байхад, Баян-Өлгий, Завхан, Ховд, Архангай, Орхон, Говь-сүмбэр, Дундговь, Төв аймгуудад эрэгтэйчүүд илүү насалж байна.

Монгол Улс анх 1992 оноос эхлэн дундаж наслалтыг тооцож эхэлсэн. Хүн амын дундаж наслалтыг 1992 онд анх тооцоход 62.77 байсан бол 2018 он хүртэлх 26 жилийн хугацаанд 7.4 жилээр нэмэгджээ⁷⁶.



2.2 дугаар зураг. Монгол Улсын хүн амын дундаж наслалт

⁷⁵ Монгол Улсын жендэрийн нөхцөл байдлын дүн шинжилгээ: 2005 оноос өнөөг хүртэлх ололт ба сургамж, 2019

⁷⁶ Эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн дундаж наслалтын зөрүү, түүнд нөлөөлж буй хүчин зүйлс. МУЗГ, ДБ. 2019

Дундаж наслалтыг хүйсээр авч үзвэл 1992 онд эмэгтэй хүний дундаж наслалт эрэгтэйгээсээ 4.19 жилийн илүү байсан бол 2018 онд тэр зөрүү 9.67 болж өссөн байна.



2.3 дугаар зураг. Монгол Улсын хүн амын дундаж наслалт

Дундаж наслалт нь НҮБ-ын Статистикийн хорооноос гаргасан аргачлалын дагуу хүн амын насжилтын хүснэгтийг байгуулж хийсэн тооцоолол буюу шинэ төрсөн хүүхдийн цаашид үргэлжлэн амьдрах дундаж хугацааг илэрхийлж буй тооцоолол юм. Хүн амын насжилтын хүснэгтэд насны бүлгээр тооцсон хүн амын тоо, нас барсан хүний тоо, нас баралтын коэффициентүүдийг үндэслэн хүн амын нас баралтын түвшин, нас барах магадлал, тодорхой насыг насалсан хүний цаашид амьдрах дундаж хугацааг тооцоолдог⁷⁷. Иймээс эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн дундаж наслалт, түүний зөрүүтэй байдалд нөлөөлж буй хүчин зүйлсийг тодорхойлохын тулд хүн амын нас баралтыг судлах нь зайлшгүй шаардлагатай юм.

Хүн амын нас баралт


Монгол Улсад жилд ойролцоогоор 17 мянга гаруй хүн буюу 1000 хүн ам тутмын 6 нь нас барж байна. Хүн амын нас баралт 1990-2018 оны хооронд жилд дунджаар 6 хувиар өссөн байна.

⁷⁷ “Хүн амын статистикийн үзүүлэлт тооцоолох аргачлал”. ҮСХ-ны даргын 2013 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 1/149 дугаар тушаалын хавсралт.



2.4 дүгээр зураг. Монгол Улсын хүн амын нас баралтын тоо


Нийт нас баралтад эрэгтэйчүүдийн эзлэх хувь өссөөр байна. Монгол Улсын хүн амын хүйсийн харьцааны хувьд эрэгтэйчүүд 49.2 хувь, эмэгтэйчүүд 50.8 хувь байдаг бол нас баралтын хувьд эрэгтэйчүүд 60.4 хувь, эмэгтэйчүүд 39.6 хувийг тус тус эзэлж байна⁷⁸. Өөрөөр хэлбэл, 2018 оны байдлаар нас барж буй 10 хүн тутмын 6 нь эрэгтэй, 4 нь эмэгтэй хүн байна.



2.5 дугаар зураг. Хүн амын нас баралт, хүйсээр, 2018

2018 онд нас барсан хүмүүсийн хүйс, насны бүлгээс харахад 70 хүртэлх аль ч насны бүлэгт эрэгтэй хүмүүсийн нас баралт эмэгтэйчүүдээс их байна. Эрэгтэйчүүд эмэгтэйчүүдээс илүү залуу насандаа нас барж байгаа ба тэдний нас баралт 45 наснаас эхлэн эрс нэмэгдсэн байна.

⁷⁸ Эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн дундаж наслалтын зөрүү, түүнд нөлөөлж буй хүчин зүйлс. МУЗГ, ДБ. 2019



2.6 дугаар зураг. Хүн амын нас баралт, насны бүлгээр


Нас баралтыг насны бүлгийн эзлэх хувиар харвал, нас барсан эрэгтэйчүүдийн 40.4 хувь, эмэгтэйчүүдийн 68 хувь нь тэтгэврийн насандаа нас барсан байна. Нөгөө талаас эрэгтэйчүүдийн 52.2 хувь буюу тал хувь нь, эмэгтэйчүүдийн 24 хувь нь хөдөлмөрийн насандаа нас барсан байна. Хөдөлмөрийн насны эрэгтэйчүүдийн нас баралт эмэгтэйгээс 3.3 дахин илүү байна⁷⁹.

Хүн амын төрөлт

Хүн амын өсөлт, өөрчлөлтийг шууд тодорхойлдог төрөлт, нас баралт, шилжих хөдөлгөөн гэсэн 3 үндсэн үзүүлэлтээс төрөлт нь хүн амын өсөлтөд эерэг нөлөө үзүүлдэг гол хүчин зүйл мөн. Төрөлт нь зөвхөн хүн амын тоо хэмжээнд нөлөөлөөд зогсохгүй нас, хүйсийн бүтцэд ч нөлөөлдөг.


Монгол Улсын хүн амын төрөлтийн түвшин 1990-2000 онд буурч байсан боловч сүүлийн 15 жилд нилээд хэлбэлзэлтэй байна. Төрөлт 2007-2009 онуудад өмнөх жилүүдийнхээс тогтвортой нэмэгдсэн ба 2014 онд 81.4 мянга болж, сүүлийн 10 жилийн хамгийн өндөр төрөлт байсан ба 2018 онд 78.4 мянга болж буурсан. Сүүлийн 5 жил тутамд эрэгтэй хүүхдийн тоо эмэгтэйгээсээ 9000-10000-аар илүү байгаа нь ирээдүйд хүн амын зохистой бүтцийг бий болгоход ихээхэн ач холбогдолтой юм.

⁷⁹ Эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн дундаж наслалтын зөрүү, түүнд нөлөөлж буй хүчин зүйлс. МУЗГ, ДБ. 2019



2.7 дугаар зураг. Төрөлт, амьд төрсөн нярайн тоо, сонгосон онуудаар

1990 онд 1000 хүн амд ногдох төрөлтийн түвшин 35.3 байсан бол 2005 онд 17.8 болж 2 дахин буурч хамгийн бага түвшинд хүрсэн бөгөөд 2006 оноос тогтвортой нэмэгдэн 2018 онд 24.8 болсон. Төрсөн хүүхдийн тоо 2018 онд 78.4 мянга, хүйсийн харьцаа 100 охинд 105 хөвгүүн ногдож байна⁸⁰.



2.8 дугаар зураг. Төрөлтийн нийлбэр коэффициент, сонгосон онуудаар

Нэг эмэгтэйн амьдалынхаа туршид төрүүлэх хүүхдийн тоо 1990 онд 4.3 байснаа 1995 онд 2.75, 2000 онд 2.25 болж 1990 оны түвшингээс хоёр дахин буурсан. Хүн ам зүйд төрөлтийн нийлбэр коэффициент (ТНК) хамгийн багадаа 2.1 байвал хүн

⁸⁰ Төрөлтийн тоо, хүйсээр. http://www.1212.mn/tables.aspx?TBL_ID=DT_NS0_0300_013V1

амын нөхөн үржихүйн эргэн нөхөгдөх түвшин хангагдана гэж үздэг Харин 2003 онд ТНК нөхөн үржихүйн эргэн нөхөгдөх түвшнээс доогуур 1.99 болж, 2005 онд 1.95 болтлоо буурсан нь Монгол Улсын түүхэн дэх хамгийн бага үзүүлэлт байв. Төр засгаас төрөлтийг дэмжих арга хэмжээ авсны үр дүнд 2007-2009 онд ТНК 2.34-2.69 болж өссөн боловч 2010 онд эргээд буурч 2.39 болсон. Харин 2011 оноос хойш тасралтгүй өссөөр 2018 онд 2.9⁸¹ болсон байна. Үүнд идэвхтэй төрөх нас /20-39/-ны эмэгтэйчүүдийн төрөлт нэмэгдсэн, нөгөөтэйгүүр, хүүхдүүдэд олгох болон хүүхэд асарсны мөнгөн олговрын талаар төрөөс баримталж байгаа бодлого, эдийн засгийн өсөлт зэрэг олон хүчин зүйлүүд нөлөөлсөн байх талтай.

Үндэсний статистикийн хорооны мэдээгээр⁸² 2018 онд 78404 эх амаржиж, 78444 хүүхэд төрсөн байна. Амаржсан эхийн тоо өмнөх оныхоос 3928 буюу 5.3 хувиар, хүүхэд 3123 буюу 2.4 хувиар тус тус өсөв. Улсын хэмжээгээр 2018 онд 1-5 хүртэлх насны 241 хүүхэд эндсэн нь өмнөх оныхоос 13 хүүхэд буюу 1.8 хувиар өсч, нэг хүртэлх насандаа 1037 хүүхэд эндэж, өмнөх оныхоос 28 хүүхдээр буюу 3.6 хувиар тус тус буурчээ.

Хүн амын шилжилт хөдөлгөөн

Дэлхий нийт даяарчлагдаж буй өнөө үед суурин хүн амын тоо жилээс жилд харилцан адилгүй гарч байна. 2000 оноос хойш монголчуудын гадагшаа чиглэсэн хөдөлгөөн ихэссэн бол сүүлийн жилүүдэд Монголыг зорьсон гадаадын иргэдийн шилжилт хөдөлгөөн нэмэгдэж байна.

Монгол Улсын суурин хүн 1990 онд 2149.3 байсан бөгөөд хотын хүн ам 905,9 буюу 42,1 хувийг, хөдөөгийн хүн ам 1197,4 мянга буюу 55,7 хувийг эзэлж байсан. 2000 онд хүн амын тоо 2407.5 мянга болж өссөн бөгөөд үүнээс хотын хүн амын тоо 1377,0 мянга буюу нийт хүн амын 57,2 хувийг эзэлж өссөн байхад хөдөөгийн хүн ам 1030,5 мянга болж буурч, хүн амын 42,8 хувь болж буурсан байна. 2009 оны байдлаар нийт хүн ам 2735.8 мянга болж өссөн бөгөөд үүнээс хотын хүн ам 1713,3 мянга буюу 62,6 хувь, хөдөөгийн хүн ам 1022,5 мянга буюу 37,4 хувь болж буурсан бол 2015 оноос эхлэн хөдөө орон нутаг руу шилжих хөдөлгөөн нэмэгдсэн байна.

Олон улс орнуудын хүн амын шилжих, шилжин суурьшилтын түүхэн баримтаас үзэхэд байгалийн нөөц баялгийг ашиглах явдал нэмэгдэж, үйлдвэр, уурхайн салбар хөгжиж, хот суурин газар олшрохтой зэрэгцэн хүн амын шилжин суурьшилт нэмэгддэг зүй тогтолтой байдаг.

⁸¹ Эрүүл мэндийн үзүүлэлт-2018. ДЭМБ, Эрүүл мэндийн төв. УБ.,2019

⁸² Монгол Улс. “Нийгмийн үзүүлэлтийн түүвэр судалгаа-2018”. Нэгдсэн тайлан. ҮСХ, НҮБ-ын Хүн амын Сан., 2019.

Шилжих хөдөлгөөн нь дараах шалтгаанаар хот хөдөөгийн ялгааг нэмэгдүүлж байна.

- Өндөр хурдаар өсч байгаа хотын хүн амын ердийн өсөлт нь шилжих хөдөлгөөнөөр нэмэгдэх механик өсөлтийн хамт ажилгүйдлыг их хэмжээгээр нэмэгдүүлж байна.

- Эрэлт хэрэгцээний байдлаас авч үзэхэд хотод ажлын байр шинээр бий болгох нь зардал шаардсан төвөгтэй асуудал бий болгож байна.

Шилжилт хөдөлгөөн нь хүний нас, боловсрол, эдийн засагтай салшгүй холбоотой юм.

Хөдөөгөөс хот руу шилжиж байгаа хүн амын дийлэнх нь 15-24 насны залуус эзэлж байна. Сүүлийн жилүүдэд эмэгтэйчүүдийн боловсрол нэмэгдэж байгаатай холбоотойгоор тэд хотод ажлын байр хайх зорилгоор шилжин ирэх явдал нэмэгдэх болсон. Харин боловсрол багатай хүмүүст хотод ажил олдох нь хомс байна. Иймээс шилжин ирэгсдийн дунд боловсролгүй хүмүүсийн эзлэх хувийн жин буурах хандлагатай байна. Мөн шилжих хөдөлгөөн нь эдийн засагтай салшгүй холбоотой. Шинэ газар ирээд өндөр орлого олох зорилго нь шилжих хөдөлгөөний гол шалтгаан болно.

Хот, суурин газар руу шилжих хөдөлгөөн нэмэгдсэн нь нэгд, хууль /Үндсэн хуульд⁸³ "... улсынхаа нутаг дэвсгэрт чөлөөтэй зорчих, түр буюу байнга оршин суух газраа сонгох, гадаадад явах, оршин суух ... эрхтэй"./-иараа хүн амьдарч, оршин суух газраа чөлөөтэй сонгох эрхтэй болсон, хоёрт, хот, хөдөөгийн амьдралын ялгаа эрс өөрчлөгдөж эхэлсэн, гуравт, хөдөө орон нутагт өмч хувьчлалын бодлогын алдаанаас болж ажлын байрны хомсдол бий болсон, дөрөвт, соёл, мэдээллийн тэгш бус байдал зэрэгтэй холбоотой юм. Энэхүү шилжих хөдөлгөөнөөс үүдэн эерэг гэхээсээ сөрөг нь давамгайлсан олон асуудал урган гарч байна. Тухайлбал, эрүүл мэнд, боловсролын асуудал, хүнсний хангамж, орон сууцны хангалт, орчны бохирдол зэрэг нэн даруй шийдвэрлэвэл зохих асуудлууд тулгараад байна.

⁸³ Монгол Улсын Үндсэн хууль. 16 дугаар зүйлийн 18 дахь заалт. УБ., 1992 он.

Хүн амын шилжилт хөдөлгөөн

Он	Шилжиж ирсэн хүний тоо					Шилжиж явсан хүний тоо				
	2013	2014	2015	2016	2017	2013	2014	2015	2016	2017
Бүгд	54673	54390	53912	50683	37443	56010	55864	53684	52169	38691
Архангай	637	570	637	667	1022	1706	2237	1706	1226	1446
Баян-Өлгий	233	218	262	270	317	615	695	1328	2570	3530
Баянхонгор	519	572	545	833	853	1723	1922	1614	1444	663
Булган	1186	1937	1072	1321	1168	1866	1831	1800	1663	1383
Говь-Алтай	187	484	386	716	573	1632	1637	1423	1146	604
Дорноговь	1,673	1,516	1,505	1,607	1,888	1,554	1,590	1,912	1,547	1,224
Дорнод	605	698	698	567	1070	1790	1992	891	1016	683
Дундговь	618	669	1152	701	807	1629	1450	792	1155	593
Завхан	781	703	703	1090	852	1891	2073	2073	1579	918
Орхон	3505	2132	2374	2202	2461	4705	4285	3263	2989	2009
Өвөрхангай	780	762	849	1049	1152	3365	3121	2639	2316	1053
Өмнөговь	1754	1089	1130	1564	1660	1191	1277	1369	1129	784
Сүхбаатар	778	730	905	672	628	1113	1082	900	961	464
Сэлэнгэ	2214	2135	1999	2514	2510	3843	4219	3900	2999	2181
Төв	2106	2160	2303	2487	2421	3699	3626	3578	2805	1557
Увс	578	516	547	693	766	1973	1754	1799	1826	1009
Ховд	721	738	666	1138	898	1940	1789	1706	1864	703
Хөвсгөл	795	743	874	839	1200	2114	2358	2016	1871	1102
Хэнтий	1210	1351	1903	1555	1690	2328	2106	2919	1907	928
Дархан-Уул	2850	2563	2306	2257	2533	3948	3963	3677	3147	1931
Улаанбаатар	30127	31356	30297	25196	10335	10671	10009	11702	14342	11431
Орхон	3505	2132	2374	2202	2461	4705	4285	3263	2989	2009
Говьсүмбэр	816	748	799	745	639	714	748	677	687	489

Дээрх хүснэгтээс харахад уул уурхай болон дэд бүтцийн хөгжил илүү хөгжсөн аймагт шилжиж ирсэн хүний тоо өссөн бол амьжиргааны түвшин, цаг уур, дэд бүтэц, бүтээн байгуулалт зэрэг хүчин зүйлүүдээс шалтгаалан зарим аймгаас шилжиж явсан хүний тоо өсөх хандлага ажиглагдаж байна. Тухайлбал, Өмнөговь, Дорноговь,

Дорнод аймгуудын хүн ам энэ хугацаанд жилд дунджаар 100-500-аар, Улаанбаатар хотын хүн ам 2016 оныг хүртэл жил тутам 10-20 мянгаар тус тус нэмэгдэж байсан бол Баян-Өлгий аймгийн хүн ам 2013-2017 оны хооронд 80-1200-аар цөөрсөн байгаа нь харагдаж байна.

Төрөөс хөдөө, орон нутгийг хөгжүүлэх зорилгоор худалдааны чөлөөт бүсийг байгуулсан болон хөдөөгийн ард иргэд, малчдын талаар авч буй арга хэмжээний үр дүнд хотыг чиглэсэн их нүүдэл сүүлийн жилүүдэд багасах хандлага ажиглагдаж байна.

Шилжилт хөдөлгөөнөөс үүдэлтэй нийслэл, хот суурин газруудад дараах сөрөг үр дагаварууд бий болж байна. Үүнд:

1. *Агаарын бохирдол их хэмжээгээр нэмэгдсэн.* Гэр хорооллын айл өрхийн тоо их хэмжээгээр нэмэгдсэнээс гадна нийслэл хотын автомашины тоо сүүлийн жилүүдэд эрс өсөж, хотын ногоон байгууламж багассантай холбоотой юм. Энэ нь хүний эрүүл мэндэд ихээхэн сөрөг нөлөөлөл үзүүлж байна.

2. *Ядуурал нэмэгдэж байна.* Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яам болон НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр, Хүн амын сургалт, судалгааны төвөөс хамтран хийсэн судалгааны дүгнэлтээр хүртээмжийн ядуурал шилжигчдийн дунд эрс өндөр байгаа бөгөөд хотод шилжин ирэгсдийн тал илүү хувь (54,8 хувь) нь хүртээмжийн ядуурал, мэдрэл сэтгэлзүйн доройтолд өртөж, шилжих хөдөлгөөнд оролцоогүй хүн амынхаас 2 дахин өндөр байгаа тооцоо гарсан байна.

3. *Ажилгүйдэл их хэмжээгээр нэмэгдэж байна.* 5-6 хүнтэй малчин өрхийн дийлэнх хэсэг нь 200 хүрэхгүй малтай, хотод шилжин ирж буй малчдын 90 орчим хувь нь мал маллахаас өөр ажил үндсэндээ эрхэлж байгаагүй учраас хотод ирээд ажил олдохгүй ажилгүйчүүдийн эгнээг нэмэгдүүлж байна.

4. *Суурь боловсролын чанар муудаж байна.* Хотын захын дүүргийн сургуулиудын ачаалал хэт нэмэгдэж, байрны хүрэлцээгүйн улмаас 3 ээлжээр хичээллэх, анги дүүргэлт хэтэрсэн зэргээс үүдэн багш нарын сурагчидтай тулж ажиллах ажлын үр дүн буурч, сургалтад сөрөг нөлөө үзүүлж байна. Хөдөө орон нутгийн хувьд багшлах боловсон хүчний хүрэлцээ хангамж муутайн улмаас дунд сургууль төгссөн хүмүүс багшлах болсон нь суурь боловсролын чанарт муугаар нөлөөлж байна.

5. *Эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмж муудаж байна.* Шилжин ирэгсдийн зарим хэсэг нь бүртгэлгүйн улмаас эмнэлэгийн үйлчилгээ авч чадахгүйд хүрч байгаагаас гадна хүн амын халдварт өвчинд өртөх байдал нэмэгдэж байна.

6. *Автозамын ачаалал нэмэгдэж байна.* Хүн амын нягтрал ихэссэнтэй холбоотойгоор авто замын ачаалал төв замуудын түгжрэл ихээр нэмэгдэж байна.

Аймаг, нийслэлийн хүн амын тооны өөрчлөлтөд төрөлт, насжилтын түвшингээс гадна шилжилт хөдөлгөөн ихээхэн нөлөөлж байна. Баруун аймгуудын хүн амын тоо бусад аймгуудыг бодвол буурч байна. Тухайлбал, Завхан аймгийн нийт сумын 60 орчим хувь нь 2000 хүрэхгүй хүн амтай байна. Энэ нь нийслэл, төв суурин газар бараадсан шилжих хөдөлгөөний нөлөөлөл байх магадлалтай юм.

Хүснэгт 2.5

Хүн амын нягтрал

Аймаг	2015	2016	2017	2018
Улсын дүн	2.	2.	2.	2.1
Баруун бүс	0.9	0.9	1.	1.
Баян-Өлгий	2.2	2.2	2.2	2.3
Говь-Алтай	0.4	0.4	0.4	0.4
Завхан	0.8	0.9	0.9	0.9
Увс	1.2	1.2	1.2	1.2
Ховд	1.1	1.1	1.1	1.2
Хангайн бүс	1.5	1.5	1.5	1.6
Архангай	1.7	1.7	1.7	1.7
Баянхонгор	0.7	0.7	0.7	0.8
Булган	1.2	1.2	1.3	1.3
Орхон	125.9	127.2	130.	132.5
Өвөрхангай	1.8	1.8	1.8	1.9
Хөвсгөл	1.3	1.3	1.3	1.3
Төвийн бүс	1.	1.	1.1	1.1
Говьсүмбэр	3.	3.1	3.2	3.2
Дархан-Уул	30.6	30.9	31.5	32.1
Дорноговь	0.6	0.6	0.6	0.6
Дундговь	0.6	0.6	0.6	0.6
Өмнөговь	0.4	0.4	0.4	0.4
Сэлэнгэ	2.6	2.6	2.7	2.7
Төв	1.2	1.2	1.3	1.3
Зүүн бүс	0.7	0.7	0.8	0.8
Дорнод	0.6	0.6	0.6	0.7
Сүхбаатар	0.7	0.7	0.7	0.8
Хэнтий	0.9	0.9	0.9	1.
Улаанбаатар	297.1	306.5	311.3	317.3

Аймгуудын хүн амын нягтрал шилжих хөдөлгөөнтэй холбоотойгоор ерөнхийдөө буурах хандлагатай байна. Их нягтралтын хувьд Орхон, Дархан-Уул аймгууд нийслэл хотын дараа орж байна. Харин бага нягтралтай, нэг хавтгай дөрвөлжин километр нутаг дэвсгэрт 2-3 хүн ногдож байгаа нь Баян-Өлгий, Сэлэнгэ,

Говьсүмбэр аймгууд орж байна. Судалгаанаас харахад Зүүн, зүүн урд, өмнөд, баруун урд хилийн аймгуудад хүн амын нягтрал хамгийн сийрэг, нэг хавтгай дөрвөлжин километр нутаг дэвсгэрт 0.4-0.7 хүн ногдож байна. Тухайлбал, Сүхбаатар-0,8; Дорноговь-0,6; Өмнөговь-0,4; Баянхонгор-0,7; Говь-Алтай-0,4 гэсэн хүн амын нягтралтай байна. Гэтэл хот суурин газар (Улаанбаатар-317,3; Орхон-132,5; Дархан-Уул-32,1)-ын хүн амын нягтрал 32,1-317,3 байна.

Хүн амын эрүүл мэнд, боловсрол

Эрүүл мэндийн салбарт өнгөрсөн 15 жилийн хугацаанд хүн амын дундаж наслалтыг нэмэгдүүлэх, халдварт бус өвчлөл болон халдварт өвчлөлөөс үүдэлтэй нас баралтыг бууруулах чиглэлээр хэд хэдэн бодлого, хөтөлбөр, стратегийг хэрэгжүүлсэн байна. Тухайлбал, Эрүүл мэндийн яамнаас эрчүүдийн эрүүл мэндэд онцгойлон ач холбогдол өгч тусгайлсан “Эрэгтэйчүүдийн эрүүл мэндийн стратеги⁸⁴”-ийг 2014-2018 онд хэрэгжүүлсэн нь томоохон алхам болсон. Гэвч тухайн хөтөлбөрийн хэрэгжилтээс харахад 2014 онд эрэгтэйчүүдийн дундаж наслалт 66,01 байсан бол 2018 онд хөтөлбөр хэрэгжиж дуусахад энэхүү үзүүлэлт 66,10 байгаа нь “бараг өөрчлөлт гараагүй” гэж дүгнэж хэлэхэд болохоор байна. Монгол Улсад дундаж наслалтын зөрүүтэй байдал буюу эрэгтэйчүүдийн дундаж наслалт 9,5 насаар бага байгаа шалтгааныг статистик болон баримтын дүн шинжилгээнд үндэслэн дараах дүгнэлтийг дэвшүүлж байна. Монгол Улсад эрэгтэйчүүдийн дундаж наслалт богино байгаа шалтгаан нь тэдний биологийн онцлог, байгалиасаа эрсдэлт зан үйлд гэмт хэрэг, осол аваарт өртөмтгий байдал, хамгийн гол нь эрэгтэйчүүдийн эрүүл мэндийн боловсрол маш сул, хангалтгүй байгаа, мөн уламжлалт тогтсон хандлагууд болох эр хүн хатуу чанга байх ёстой өвдөж болохгүй, эмчид хандсанаар сул дорой харагдахаас айх гэх мэт буруу хэвшмэл ойлголт, хандлагууд ихээр нөлөөлж байгаа нь тодорхой байна. Нас баралт дээр эрчүүд давамгайлж байгаа нь доорх шалтгаануудтай холбоотой байна. Үүнд:

1. *Нэгдүгээрт өвчлөл.* Эрэгтэйчүүдийн 60 хувь, эмэгтэйчүүдийн 40 хувь нь өвчлөлийн улмаас нас барж байна⁸⁵. Өвчлөлийн хувьд нас баралтын шалтгаанд эрчүүдийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагддаггүй, өвчнийхөө эцсийн шат хүртэл явдаг буруу хэвшмэл ойлголт, амьдралын буруу хэв маяг, ялангуяа буруу хооллолт, архи, тамхины өндөр хэрэглээ их нөлөөлж байна.

⁸⁴ “Эрэгтэйчүүдийн эрүүл мэндийн стратеги”. Эрүүл мэндийн сайдын 2014 оны 84 дүгээр тушаал.

⁸⁵ Эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн дундаж наслалтын зөрүү, түүнд нөлөөлж буй хүчин зүйлс. МУЗГ, ДБ. 2019

2. *Хоёрдугаарт амиа хорлолт.* Эрчүүдийн 85 хувь, эмэгтэйчүүдийн 15 хувь нь нас барсан байна⁸⁶. Эрэгтэйчүүдийн амиа хорлолтын түвшин өндөр байгааг тэдний ажилгүйдлээс үүдсэн архидалт, нийгэм, гэр бүлийн стресстэй холбон тайлбарлаж байгаа боловч, энэ асуудлыг цаашид чанарын судалгаагаар гүнзгийрүүлэн судлах шаардлагатай. Чанарын судалгаанд нэг анхаарал татаж байгаа зүйл нь эрэгтэй, эмэгтэйчүүдийн стрессээ даван туулж байгаа ялгаатай байдал, стрессээ тайлахдаа ямар арга хэрэгсэл ашиглаж байгаа нь анхаарал татаж байна. Эрчүүд стрессээ тайлахдаа ихэвчлэн архи, тамхи хэт их хэрэглэж, эрсдэлт зан үйл хийн, амиа хорлох байдал ихээхэн ажиглагдаж байна.

3. *Гуравдугаарт бусдад хорлогдсон.* Бусдад хорлогдсон нас баралтад эрэгтэйчүүд 81 хувь, эмэгтэйчүүд 19 хувь, бусад осол гэмтлээс үүдэлтэй нас баралтад эрэгтэйчүүд 79 хувь, эмэгтэйчүүд 21 хувь, мөн тодорхой бус нас баралтад эрэгтэйчүүдийн 80 хувь, эмэгтэйчүүдийн 20 хувь тус тус эзэлж байна⁸⁷. Дээрх нас баралтад эрэгтэйчүүдийн байгалиас заяасан эрсдэлт зан үйлд өртөх, эрсдэх байдал нь их нөлөөлж байна. Иймд эрсдэлт зан үйлд өртөх байдал, тэднийг буруу зам руу түлхэн оруулж буй хүчин зүйлсийг судлан, урьдчилан сэргийлэх боломжит аргуудыг судлах шаардлага байна.

4. *Дөрөвдүгээрт, зам тээврийн осол.* Эрэгтэйчүүдийн 74 хувь, эмэгтэйчүүдийн 26 хувь нь нас барсан байна⁸⁸. Энэхүү өндөр нас баралтын хувийг эрэгтэйчүүдийн архины хэрэглээ, мөн жолооч нарын дийлэнх нь эрэгтэйчүүд байгаатай холбон тайлбарлаж байна.

Харин үйлдвэрийн ослын улмаас нас барагсдын тоонд 100 хувь эрэгтэйчүүд байгаа нь тэдний эрсдэлтэй салбаруудад ажилладагтай шууд холбоотой бөгөөд хөдөлмөрийн аюулгүй байдлын ажиллагаа сул байгаа нь үүгээр нотлогдож байна.

Мөн Монгол залуусын эрүүл мэндээрээ цэргийн жинхэнэ албанд тэнцэхгүй байгаа өвчлөлд нийгмийн халдварт өвчин болох сүрьеэ, тэмбүү орж байна. Жилд халдварт өвчний 35-40 хувийг тэмбүү өвчин эзэлж байна. Дэлхийд нас баралтын тэргүүлэх 10 шалтгааны нэг нь сүрьеэ өвчин бөгөөд Монгол Улс нь ДЭМБ-ын Номхон далайн баруун эргийн бүсийн 37 орноос сүрьеэгийн өвчлөл өндөртэй орны тоонд ордог. Сүүлийн 5 жилийн эрүүл мэндийн статистик үзүүлэлтээр сүрьеэ нь улсын

⁸⁶ Мөн тэнд

⁸⁷ Халдварт бус өвчлөл, осол гэмтлийн шалтгаан, эрсдэлт хүчин зүйлсийн тархалтын судалгаа 2013 он, ДЭМБ, НЭМҮТ, МСС, ЭМЯ

⁸⁸ Зам тээврийн ослын өнөөгийн байдал, ҮСХ. 2018

хэмжээнд бүртгэгдэж буй нийт халдварт өвчний дотор дунджаар 10 хувийг эзэлж, жил бүр 4.000 гаруй хүн шинээр сүрьеэ өвчнөөр өвчилж байна⁸⁹.

Боловсрол: 1990-ээд оны нийгмийн өөрчлөлт, шилжилтийн үйл явцад гэр бүл, улс төр, эдийн засаг, нийгэм соёлын хүрээнд гарсан өөрчлөлтөөс улбаалан гэр бүлийн ядуурал, ажилгүйдэл нэмэгдэж, нийгмийн үйлчилгээний хүртээмж тэгш бусаас үүдэн жендэрийн ялгаатай байдал үүссэн билээ. Энэ үеэс сургууль завсардах явдал эрс нэмэгдэж, ялангуяа хөвгүүд сургуулиас завсардах явдал ихэссэн. Бичиг үсэг үл мэдэгч хүн амын 34 орчим хувийг 15-24 насны өсвөр насныхан, залуучууд дангаараа бүрдүүлж байгаа төдийгүй энэ насны бичиг үсэг үл мэдэгчдийн 66,3 хувийг нь эрэгтэйчүүд эзэлж байна. Хөвгүүд бага ангиас сургууль ихээр завсардаж зохих түвшний боловсрол эзэмшээгүйгээс болж бага цалинтай хөдөлмөр эрхэлж, орлого олох бололцоо муутайгаас болж, эрчүүд оюун санааны хүчтэй дарамтад орж архинд донтох, гэмт хэрэгтэн болоход хүргэж байна.

Их, дээд сургуульд суралцагчдын мэргэжлийн чиглэлээс үзэхэд эмэгтэйчүүд боловсрол- 78.3, хүмүүнлэг- 72.6, анагаах ухаан- 80 хувь түлхүү суралцаж байгаа бол эрэгтэйчүүд байгалийн ухаан- 56.8, техник технологи- 63.4, биеийн тамир, тээвэр, батлан хамгаалах, аюулгүй байдлын мэргэжлээр 59.4 хувь нь суралцаж байна. Мөн магистрантур, докторантурт суралцагчдын 64.8 хувь эмэгтэйчүүд, 35.1 хувь нь эрэгтэйчүүд⁹⁰ байна. Энэ нь их дээд сургуулийн хүйсийн харьцаа алдагдсан болохыг харуулж байна.

2.2. Батлан хамгаалах бодлогын хэрэгжилтэд хүн ам зүйн өнөөгийн байдлын үзүүлж буй нөлөөлөлд хийсэн шинжилгээ, уялдаа холбоог сайжруулах арга зам

“Батлан хамгаалах бодлогын үндэс” баримт бичигт “Монгол Улсын хүний хөгжил нь батлан хамгаалах бодлогын нийгмийн чиглэлийн үндэс мөн⁹¹” гэж заасан. Иймд манай улсын хувьд хүн амын эрүүл мэнд, боловсрол, сэтгэл зүй, бие бялдрыг хөгжүүлэх нийт иргэд, ялангуяа залуучуудыг эх оронч үзлээр хүмүүжүүлэх нь улс орноо батлан хамгаалах үндсэн арга хэмжээ болох учиртай.

⁸⁹ Б.Сарангэрэл. “Эрүүл мэндийн салбарт тулгамдаж буй асуудал”. МҮОНТ-д өгсөн ярилцлага. 2019 оны 6 сар

⁹⁰ Салбаруудын жендэрийн бодлогын эмхэтгэл. ХНХЯ, Жендэрийн Үндэсний хороо, Азийн хөгжлийн банк. УБ., 2018 он

⁹¹ Монгол Улсын батлан хамгаалах бодлогын үндсийн 5.1 дэх заалт. УИХ-ын 2015 оны 85 дугаар тогтоол.

Хүний хөгжил нь батлан хамгаалах бодлогын салшгүй хэсэг бөгөөд тухайн орны нийгмийн хөгжлийн цөм байх болно. Тэгэхээр хүнээ бодсон бодлого бүх шатанд байх ёстой болж байна.

Хүн нь чадавх сайтай, эх оронч үзэл, хүмүүжилтэй, ёс зүйтэй байж батлан хамгаалах тогтолцоо зөв бүрдэнэ. Хүний чадавх нь эрүүл мэнд, боловсрол, чадвараар тодорхойлогдоно.

Иргэдийг эх орноо батлан хамгаалахад боловсрол, эрүүл мэнд, хүмүүжил, ёс суртахуун, сэтгэл зүйн хувьд бэлтгэх нь нь ихээхэн чухал юм. Тийм учраас батлан хамгаалах бодлогод хүн ам зүйн асуудал, түүний дотор хүн амын өсөлт, түүний бүтэц, боловсрол, эрүүл мэнд, бие бялдрын болон оюун санааны төлөвшлийг цогцоор авч үзэх шаардлагатай юм.

Батлан хамгаалах бодлого дахь хүн ам зүйн гол үзүүлэлт бол тухайн орны хүн амын өсөлт (түүний дотор эрэгтэй хүүхдийн төрөлтийн тоо), хүйсийн харьцаа, цэргийн насны залуучуудын эрүүл мэнд, боловсролын түвшин, хөдөлмөрийн чадавхтай хүн амын ажил эрхлэлтийн байдал, дайчилгааны бэлтгэл нөөцийн бүрэлдэхүүний сургалт бэлтгэлжилт юм.

Хүн амын төрөлтийн тухайд: судалгаанаас үзэхэд сүүлийн жилүүдийн төрөлтийн тоо эрэгтэй хүүхдийнх эмэгтэйдгээсээ 10000 гаруйгаар илүү байгаа нь *эх орноо батлан хамгаалах цэрэг эрсийг бэлтгэх, батлан хамгаалах ашиг сонирхолд эерэг нөлөө үзүүлж байна.*

2017 онд жилийн дундаж өсөлт 2.0 хувьтай болсон нь хүн амын өсөлтийн талаарх төрийн бодлого (1996 оны)-оор дэвшүүлсэн хүн амын жилийн дундаж өсөлтийг 1,8 хувьд барьж байх зорилтыг хангаж байсан.

Хүн амын төрөлтийн 2018 оны түвшинг өмнөх онтой харьцуулахад бага зэргийн өсөлттэй (0,9 пункт) гарлаа. Энэ нь 2016 онд Засгийн газрын 261 дүгээр тогтоолоор “Төрөөс хүн амын хөгжлийн талаар баримтлах бодлого”-оор хүн амын өсөлтийг 2,1 хувьд буюу түүнээс их байлгах зорилт хэрэгжих шатандаа явж байгааг харуулж буй хэрэг юм.

Статистикийн тоо баримтаас харахад сүүлийн жилүүдэд (2013-2017) дунджаар 41200 эрэгтэй хүүхэд төрсөн байна. Энэхүү үзүүлэлт нь *2030 оноос батлан хамгаалах бодлого дахь хүн ам зүйн зохистой хөгжлийг бүрдүүлэх үндэстэй гэсэн дүгнэлтэд хүргэж байна.*

Хүн амын нягтралын тухайд: 2.1 дүгээр зүйлд хийсэн судалгаанаас харахад хүн амын хөдөөнөөс хот руу чиглэсэн шилжилт хөдөлгөөн саарч, хотоос хөдөө рүү чиглэсэн шилжилт нэмэгдэх хандлага ажиглагдаж байна. Хүн амын нягтрал шилжих

хөдөлгөөнтэй холбоотойгоор Өмнөговь, Дорноговь, Дорнод, Дундговь болон Баруун бүсийн Говь-Алтай аймагт хүн амын нягтрал хамгийн сийрэг, нэг хавтгай дөрвөлжин квадрат километр нутаг дэвсгэрт 0.4-0.6 хүн ногдож байна.

Хилийн бүсийн дагуух дээрх 5 аймгийн хүн амын нягтрал хэтэрхий бага, нутаг дэвсгэр эзэнгүйдэж байгаа нь Монгол Улсын батлан хамгаалах, аюулгүй байдалд ноцтой сөрөг үр дагавар бий болох магадлалыг үүсгэж байна.

Хүн амын нас баралтын тухайд: Монгол Улсын хүн амын нас баралтын байдлын талаарх судалгаанаас харахад 70-аас доошхи бүх насанд эрэгтэйчүүдийн нас баралт эмэгтэйчүүдээсээ 0,1-3,6 дахин их байна. Ялангуяа цэргийн насны залуучуудын нас баралт мөн насны эмэгтэйчүүдээсээ 2,4-2,8 дахин их буюу жилд 294-366 байна. Бэлтгэл нөөцийн бүрэлдэхүүний 30-34 насны эрчүүдийн нас баралт эмэгтэйчүүдийнхээсээ дунджаар 3,3 дахин их байна. Эрэгтэйчүүдийн 45-54 насныхнаас жилд дунджаар мянга гаруй (1002), 50-54 насныхаас мянга хоёр зуу орчим (1169), 55-59 насныхнаас мянга гурван зуу (1306)-аад эрчүүд нас барж байна⁹².

2018 оны байдлаар улсын хэмжээнд дайчилгааны бэлтгэл нөөцийн бүрэлдэхүүний I, II зэргийн бэлтгэл үүрэгтэн 900 гаруй мянга болсон байна. Гэхдээ сүүлийн 5 жилийн судалгаагаар жил бүр дунджаар цэргийн насны залуучууд (202233)-аас 300 гаруй, бэлтгэл насны 5500 гаруй бэлтгэл үүрэгтэн нас барж, мөн 23600 эрэгтэй хүүхэд 18 нас хүрч байна⁹³.

Цаашид холбогдох болон хариуцсан байгууллага, албан тушаалтнууд дайчилгааны бэлтгэл нөөцийн бүрэлдэхүүний I зэргийн бэлтгэл үүрэгтний нас баралтын талаар нарийвчлан судалж, цэргийн цол, мэргэжлээр нь жил бүр гаргаж, дүн шинжилгээ хийж байх хэрэгтэй байна.

Сүүлийн 5 жилд нас барсан эрэгтэй хүн амд амиа хорлогчдын эзлэх хувь 20-29 насанд өндөр байна. Түүнчлэн амиа хорлож эндсэн 10-14 насныхны 75.0 хувь, 15-19 насныхны 65.0 хувь, 20- 24 насныхны 81.5 хувь, 25-29 насныхны 85.2 хувь, 30-34 насныхны 90.7 хувийг эрэгтэйчүүд эзэлж байна⁹⁴. Үүнээс өсвөр насны хүүхэд болон залуу, идэр насны эрэгтэйчүүдийн ёс суртахуун, сэтгэл зүйн төлөвшил хангалтгүй байна гэсэн дүгнэлт хийж болох байна.

⁹² Эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн дундаж наслалтын зөрүү, түүнд нөлөөлж буй хүчин зүйлс. МУЗГ, ДБ. 2019

⁹³ Нас баралтын тоо, хүйс, насны бүлгээр.
http://www.1212.mn/tables.aspx?TBL_ID=DT_NSO_0300_016V1

⁹⁴ СУДАЛГАА: Амиа хорлосон иргэдийн 84 хувь нь эрчүүд, 47 хувь нь ажилгүйчүүд байна. <https://ikon.mn/n/171x>

Энэ нь Монгол Улсын “Бага дунд боловсролын тухай” хууль, Дээд боловсролын тухай хуульд боловсролын байгууллагын ажилтнуудын үүрэг, оюутан сурагчдын эрхийн талаар тодорхой заасан байдаг ч хуулийн заалтыг холбогдох байгууллага, албан тушаалтан зохих түвшинд хэрэгжүүлж ажиллахгүй, багш, эцэг эхчүүд хүүхдэд зөв хүмүүжил, ёс суртахуун, сэтгэл зүйн хатуужил олгох тал дээр төдийлөн анхаардаггүй, анхаарал халамж үзүүлэхдээ дутмаг, сурган хүмүүжүүлэгчийн шударга бус харьцааны улмаас сэтгэл гутралд орох зэрэгтэй холбоотой бөгөөд ийм байдал цаашид үргэлжилбэл, өсвөр насны болон 25 хүртэлх насны хүмүүсийн дундах амиа хорлох тохиолдол өсөх хандлагатай байна гэж үзэж болохоор байна.

Хүн амын эрүүл мэнд: Монгол Улсын мэргэжлийн цэрэгт суурилсан, чадварлаг зэвсэгт хүчнийг бүрдүүлж бэхжүүлэхэд тавигдах үндсэн шаардлагуудын нэг нь эрүүл чийрэг бие бялдартай, оюун санаа, сэтгэл зүйн бэлтгэлтэй, мэдлэг боловсролтой хүчнээр цэргийн албан хаагчдыг бүрдүүлэх явдал юм.

Иймд хугацаат болон гэрээт цэргийн албанд татагдагсдын эрүүл мэндийн байдалд судалгаа хийж, түүнд үндэслэн бие бялдар, оюун санаа, сэтгэхүйн эрүүл хөгжилтэй залуучуудаар Зэвсэгт хүчний эгнээг өргөтгөх нь эх орноо хамгаалах, үүрэг гүйцэтгэх бэлэн байдлыг хангах чухал зорилтуудын нэг болж байна.

Улсын хэмжээнд сүүлийн 5 жилд давхардсан тоогоор 300 000 гаруй иргэн цэргийн албанд татагдан, эрүүл мэндийн үзлэгт орсноос 43,4 хувь нь өвчин эмгэгийн улмаас цэрэг татлагаас чөлөөлөгдсөн. Цэргийн албанд тэнцэхгүй иргэдийн өвчлөлийн бүтцийг авч үзвэл гэмтэл-мэс заслын шалтгаанаар 22,6 хувь, дотор-халдвартын өвчнөөр 12,8 хувь, арьс харшлын өвчнөөр 10,4 хувь, чих, хамар, хоолойгоор 15,5 хувь, нүдээр 12,9 хувь, мэдрэлээр 9,9 хувь, сүрьеэгээр 3,1 хувь, жин өндрийн харьцаагаар 14,95 хувь, сэтгэцээр 2,3 хувь нь чөлөөлөгдөж⁹⁵ байгааг анхаарах ёстой.

Эрүүл мэндээр цэргийн албанаас чөлөөлөгдөж байгаа улсын дундаж хувь 43,4 хувь байхад харин Өвөрхангай-75,07 хувь, Орхон-74,92 аймаг, Хөвсгөл-66,6 хувь, Дорнод-64,42 хувь, Хэнтий-59,69 хувь, Сэлэнгэ-56,07 хувь, Баянхонгор-52,37 хувь, Төв-52,08 хувьтай байна⁹⁶. Эдгээр аймгуудын нийт хүн ам 787785 буюу манай улсын нийт хүн амын 25,02 хувь (1/4)-ийг эзэлж байгаа нь хүн амын, ялангуяа залуучуудын эрүүл мэндийн байдал ямар түвшинд байгааг харуулж байна.

⁹⁵ Жил тутмын цэрэг татлагын мэдээний тойм. БХЯ. 2018

⁹⁶ Мөн тэнд

Түүнчлэн сэтгэцийн болон сүрьеэ өвчин нь батлан хамгаалах эрх ашигт сөрөг үр дагавар ихтэй бөгөөд Хэнтий, Завхан, Дархан-Уул, Ховд, Булган аймгуудын цэргийн албан татагдсан залуучуудын дунд сэтгэцийн өвчлөл улсын дунджаас 2-4 дахин, мөн Ховд, Баян-Өлгий, Булган, Увс, Дархан-Уул аймгуудын цэргийн албан татагдсан залуучуудын дунд сүрьеэгийн өвчлөл улсын дунджаас бараг 2-3 дахин тус тус өндөр байгаа тул тухайн аймгуудаас цэргийн албан татагдан ирж буй залуучуудын эрүүл мэндийн үзлэгт онцгой анхаарах шаардлагатай нь харагдаж байна.

Сүүлийн 5 жилийн судалгааны дүнг 2000-2004 оныхтой харьцуулан үзэхэд цэргийн насны залуучуудын эрүүл мэндийн байдалд нааштай өөрчлөлт гараагүйгээр барахгүй дотор, мэс заслал, мэдрэл, жин өндрийн харьцаагаар эрүүл мэндээр чөлөөлөгдөх нь 1 нэгжээр, сэтгэцийн өвчлөл шинээр нэмэгдсэн, 2018 оны байдлаар сүрьеэ өвчний хамрах хүрээ ихээхэн өсөх хандлагатай байна. Мөн түүнчлэн 2016 онд цэргийн албанд татагдаж эмнэлгийн үзлэгт орсон 18-20 насны залуучуудын өвчлөл 21-25 насныхнаас 4 дахин их байсан бөгөөд энэ үзүүлэлтийг 2018 оныхтой харьцуулахад аль аль насных нь 3 нэгжээр нэмэгдсэн байна.

Цэргийн албанд тэнцэхгүй байгаа залуучуудын өвчлөлийн хамгийн их буюу 22,6 хувийг гэмтэл- мэс заслалын шалтгаант өвчлөл эзэлж байна. Энэ шалтгаант өвчний ихэнх хувийг төмсөгний хураагуур судасны өргөсөл өвчин эзэлж байна⁹⁷. Тэдний дийлэнх хувь нь 18-20 насны хот суурин газрын залуучууд байгаа бөгөөд цэргийн албанд ирснээс хойш 6 сарын дотор мэс заслалын эмчилгээ хийлгэж байна. Энэхүү өвчин нь хүн амын өсөлтөд, улмаар улс орны аюулгүй байдал, батлан хамгаалах эрх ашигт ч нөлөөлж болох тул холбогдох байгууллагын санал санаачилгаар уг өвчний шалтгааныг судлан тогтоож, эрүүлжүүлэх арга хэмжээ авах шаардлагатай хэмээн үзэж байна.

Мөн цэргийн жинхэнэ алба хааж байгаа алба хаагчдаас өвчнөөр халагдсан хүмүүсийн 30-40 хувь нь архаг суурь өвчний сэдрэлээр халагдаж байгаа бөгөөд эдгээр өвчин нь аймаг, сумын эмнэлэгт оношлогдож, эмчлэгдэх бүрэн боломжтой өвчнүүд байна.

Цэргийн албанд татагдан ирж байгаа залуучуудын дунд өвчлөлийн байдал буурахгүй байгаа нь бага, өсвөр насандаа суурь өвчтэй болсон, бие бялдын чийрэгжилт, ерөнхий хөгжил муу, энэ насны залуучууд өөрийн эрүүл мэндэд анхаарч, эрүүлжих талаар санаачилгаагүй, нөгөө талаар цэргийн албанаас зайлсхийх, мөн ядуурал нэмэгдэж байгаатай холбоотой байж болох талтай байна.

⁹⁷ Цэргийн насны залуучуудын эрүүл мэндийн судалгаа. ЗХЖШ-ын ЭМХ., 2018 он

Цэргийн насны залуучуудын эрүүл мэнд, өвчлөлийн үзүүлэлтийг нийт хүн амын эрүүл мэнд, өвчлөлийн үзүүлэлтүүдтэй харьцуулахад нилээд өндөр байна. Үүнд дүгнэлт хийж, цаашид цэргийн насны залуучуудын эрүүл мэндийг сайжруулахад төр засгийн холбогдох бүх шатны байгууллага тодорхой бодлого, алсын хараатай хандаж, авч хэрэгжүүлэх арга хэмжээг бодитойгоор тодорхойлох явдал чухал байна.

Хөдөлмөр эрхлэлт, ажилгүйдэлийн тухайд: Манай улсын эдийн засгийн өсөлт 2000 оноос хойш уул уурхайн салбарын олборлолт, үйлдвэрлэлээс ихээхэн хамааралтай өсч, 2011 онд хамгийн өндөр буюу 17.3 хувиар өссөн. Гэвч энэ өсөлт нь 2012 оноос эхлэн буурч, 2016 онд 1.2 хувь болсон. Энэхүү эдийн засгийн бууралт нь хүн амын амьжиргааны түвшин, эрүүл мэнд, ажил хөдөлмөр эрхлэлтэд сөргөөр нөлөөлж, ялангуяа залуучуудын ирээдүйдээ итгэх итгэлд хүнд цохилт болохын зэрэгцээ, ажилгүйдэл, ядуурал нэмэгдэх гол нөхцөл шалтгаан болсон байна. *Нөгөө талаар энэ бүхэн батлан хамгаалах бодлогыг хэрэгжүүлэхэд нэгд, батлан хамгаалах төсвийн хомсдолын хамаарал, хоёрт, Зэвсэгт хүчний зэвсэглэл техникийн шинэчлэл, цэргийн алба хаагчдын амьжиргааны түвшин, сэтгэл санаа зэрэгт ихээхэн сөрөг нөлөө үзүүлж байна.*

2018 оны байдлаар нийт хүн амын 1358,6 мянга нь хөдөлмөрийн насны иргэд байна. Хөдөлмөрийн насны хүн амын 92,23 хувь буюу 1253,1 мянган хүн ажил хөдөлмөр эрхэлж байна. Хөдөлмөр эрхлээгүй 105,6 мянган хүн байгаагийн 23,1 мянган хүн нь хөдөлмөр эрхлэлтийн албанд бүртгүүлсэн байна. Хөдөлмөр эрхлээгүй иргэдийн 57.7 хувь буюу 60948 эрэгтэйчүүд байна⁹⁸.

Судалгаанаас харахад сүүлийн 5 жилд 18-25 насны ажилгүй иргэдийн тоо жилд дунджаар 300-400 хүнээр нэмэгдэж, тэдгээрийн дотор эрэгтэйчүүдийн эзлэх хувь 50-66 хувь, бүртгэлтэй нь 45-47 хувьтай байгаа нь цэргийн насны залуучуудын хөдөлмөр эрхлэх сонирхол тийм ч сайн биш байгааг харуулж байна.

Боловсролын тухайд: Бүх шатны боловсролын чанар хангалтгүй байгаа нь өнөөгийн тулгамдсан асуудлын нэг болоод байна. Энэ нь боловсролын өгөөжийг бууруулж, залуучууд чадамжаа хөгжүүлэх боломжийг хязгаарлан, тэдний цаашдын хөдөлмөр эрхлэлтийн төлөвт нь сөргөөр нөлөөлж байна.

Боловсролын үзүүлэлт нь батлан хамгаалах хүний нөөц болон өрхийн аж байдлыг нэмэгдүүлэх нэгэн чухал хүчин зүйл болно. Хүн амын эзэмшсэн

⁹⁸ Хөдөлмөр эрхлэлт, ажилгүйдэл. Статистикийн мэдээллийн нэгдсэн сан.
http://www.1212.mn/stat.aspx?LIST_ID=976_L04&type=tables

боловсролын дээд түвшинг болон одоо суралцаж байгаа хүн амыг хүйс, газар зүйн тархалт, амжиргааны түвшинтэй уялдуулан судлахад дараах байдалтай байна.

Нийт хүн амын 25.6 хувь нь (13.2 хувь нь эрэгтэй) боловсролгүй, 11,5 хувь нь (5,9 хувь нь эрэгтэй) бага, 14,7 хувь нь (7,9 хувь нь эрэгтэй) суурь, 25.5 хувь нь (12,4 хувь нь эрэгтэй) бүрэн дунд, 6 хувь нь (2,7 хувь нь эрэгтэй) техник мэргэжлийн, 16.7 хувь нь (6,7 эрэгтэй) дээд боловсролтой, 1.6 хувь нь бичиг үсэгт тайлагдаагүй байна⁹⁹.

Сүүлийн 5 жилийн байдлаар цэргийн албанд татагдсан иргэдийн 1.6 хувийг дээд, тусгай дунд боловсролтой, 35.6 хувийг боловсролгүй болон бага боловсролтой залуучууд эзэлж байна¹⁰⁰.

Эдгээр үзүүлэлт нь цэргийн насны залуучуучуудын төдийгүй нийт хүн амыг эрүүлжүүлэх, тэдний боловсролын түвшинг дээшлүүлэх арга хэмжээг төрийн бүх шатны байгууллага бодлого, үйл ажиллагаандаа анхаарч ажиллах цаг нэгэнт болсныг харуулж байгаа бодит жишээ баримт юм.

Батлан хамгаалах тухай хуулийн 13 дугаар зүйлд “бүх шатны боловсролын байгууллагын сургалтын хөтөлбөрт хүүхэд, залуучуудад цэрэг, эх оронч хүмүүжил болон аюулгүй амьдрах арга ухаан олгох хичээлийн агуулгыг тусгаж, хэрэгжүүлэх¹⁰¹”, “иргэнийг эх орноо батлан хамгаалахад сургаж бэлтгэх, эх оронч үзлээр хүмүүжүүлэхэд төрийн бүх шатны болон төрийн бус байгууллагын үйл ажиллагааг нэгтгэн чиглүүлэх¹⁰²” хэмээн заасан. Хуулийн эдгээр заалтыг хэрэгжүүлэх асуудлыг БХЯ холбогдох төрийн захиргааны төв, нутгийн захиргааны байгууллагуудтай хамтран ажиллаж, шийдвэрлэх учиртай.

Монгол Улсын иргэдэд эх оронч үзэл төлөвшүүлэх тогтолцоог боловсронгуй болгох үндсэн чиглэл, арга замыг тодорхойлж, эх оронч үзэл, хүмүүжил төлөвшүүлэх ажлын шинжлэх ухааны үндэслэл, арга технологийг боловсронгуй болгон, бүх их, дээд, дунд, тусгай мэргэжлийн болон ерөнхий боловсролын сургуулийн сургалт хүмүүжлийн ажлын нэгдсэн тогтолцоонд эх оронч үзэл, үндэсний ухамсар, ёс заншил, уламжлалыг тодорхой байр суурь эзлүүлэх; сургуулийн өмнөх насны хүүхдэд зураг, дуу, хөгжим, шүлэг, домог үлгэрээр дамжуулан эх орон, байгаль орчноо таних, хайрлан хамгаалах хүсэл, тэмүүлэл, эх оронч үзэл, хүмүүжлийг төлөвшүүлэх нь чухал юм.

⁹⁹ НХҮЕГ, Өрхийн амьжиргааны түвшинг тодорхойлох судалгаа. Хүн амын боловсролын түвшингээр. 2017

¹⁰⁰ Цэргийн насны залуучуудын боловсролын байдлын судалгаа. БХЯ-ны СБТГ., 2018

¹⁰¹ Батлан хамгаалах тухай хуулийн 13.1.7 дахь заалт

¹⁰² Батлан хамгаалах тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.6 дахь заалт

Иймд ерөнхий боловсролын сургуулийн сургалтын хөтөлбөрт цэрэг- түүхийн, эрх зүйн, бие бялдар - эрүүл мэндийн, цэрэг – спорт/цэрэгжил/-ын асуудлыг, харин их, дээд сургууль, коллеж, мэргэжлийн боловсролын бусад байгууллагуудын сургалтын хөтөлбөрт эх оронч үзэл, хүмүүжил/батлан хамгаалах/-ийн онолын асуудлыг тус тус нэмж тусган шинэчилснээр залуу үеийнхний бие бялдрын хөгжил болон эх оронч үзэл, улс орноо батлан хамгаалах үйл хэрэгт чанарын өөрчлөлт гарах болно. Түүнчлэн цэргийн анхан шатны болон мэргэжлийн сургалтыг ч сургалтын хөтөлбөрт оруулж болох юм.

Хөдөлмөрийн зах зээлд шаардлагатай мэдлэг ур чадварыг залуучуудад олгох өнөөгийн дээд боловсролын өгөөж сул байгааг дээд болон техник мэргэжлийн боловсролтой залуучуудын ажилгүйдлийн түвшин дунд болон бага боловсролтой залуучуудынхаас өндөр байгаагаас харж болно.

Сургалт, бэлтгэлийн хувьд: Батлан хамгаалах тухай хуульд “дайчилгааны бэлтгэл нөөцийн бүрэлдэхүүний сургалтыг зохион байгуулах¹⁰³,” Зэвсэгт хүчний тухай хуульд “дайчилгааны бэлтгэл нөөцийн бүрэлдэхүүнийг сургах, хүн амыг цэргийн хэрэгт сургах, тэдэнд эх оронч үзлийг төлөвшүүлэхэд дэмжлэг үзүүлэх¹⁰⁴,” Цэргийн албаны тухай хуульд “Цэргийн хоёрдугаар зэргийн бэлтгэл үүрэгтнийг цэргийн анхан шатны бэлтгэл олгох сургалтад заавал хамруулна¹⁰⁵”, “Цэргийн хоёрдугаар зэргийн бэлтгэл үүрэгтний цэргийн анхан шатны бэлтгэл олгох сургалтад хамрагдах нийт хугацаа гурван сар байна¹⁰⁶”, “Цэргийн хоёрдугаар зэргийн бэлтгэл үүрэгтэнд цэргийн анхан шатны бэлтгэл олгох сургалтыг аймаг, нийслэлийн Засаг дарга зохион байгуулна¹⁰⁷” гэж зааснаар дайчилгааны бэлтгэл нөөцийн бүрэлдэхүүний сургалтыг бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалтай уялдуулан орон нутгийн зарчмаар зохион байгуулах эрх зүйн орчин бүрдсэн. Энэ бүхнээс үзэхэд дайчилгааны бэлтгэл нөөцийн бүрэлдэхүүний тайван цагийн сургалт нь орон нутгийн хамгаалалтын тогтолцоог бүрдүүлэхэд чухал ач холбогдолтой байна.

Улс орны батлан хамгаалах чадавхыг дээшлүүлэх, дайчилгааны I зэргийн бэлтгэл үүрэгтний нөөцийг нэмэгдүүлэх, иргэдийн төрийн жинхэнэ алба хаших болзол нөхцлийг хангах зорилго бүхий “Оюутан цэрэг” хөтөлбөрийг 5 жил хэрэгжүүлж байна. Жил бүр 1000 гаруй (сүүлийн 2 жил 200 гаруй) оюутан цэргүүд сургалтад хамрагдаж байна. 2018 онд нийслэлийн хэмжээнд 7000 гаруй оюутан санал

¹⁰³ Батлан хамгаалах тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.6 дахь заалт

¹⁰⁴ Зэвсэгт хүчний тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2.8 дахь заалт

¹⁰⁵ Цэргийн албаны тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.6 дахь заалт

¹⁰⁶ Цэргийн албаны тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.7 дахь заалт

¹⁰⁷ Мөн хуулийн 33 дугаар зүйлийн 33.8 дахь заалт

гаргаснаас 1200 нь шаардлага хангасан, эрүүл мэндийн үзлэгийг Цэргийн төв эмнэлэгт зохион байгуулсан ба үзлэгт тэнцээгүй 100 гаруй оюутныг хасч, 723 оюутныг эрүүл мэндээр тэнцүүлсэн, ҮБХИС-ийн хээрийн сургалтын төвд “Цэргийн мэргэжлийн бэлтгэл сургалтад 640 оюутан хамрагдсан, үүнээс 11 оюутан эрүүл мэндийн шалтгаанаар сургалтаас чөлөөлөгдөн, 629 оюутан хөтөлбөрийг бүрэн хангаж тангараг өргөн цэргийн 1 дүгээр зэргийн бэлтгэл үүрэгтнээр бүртгэгдсэн. 11 төрлөөр цэргийн бага мэргэжил эзэмшүүлэн, I зэргийн бэлтгэл үүрэгтнээр бүртгэн, цэргийн мэргэжлийн дугаар олгосон, хөтөлбөрт тусгай мэргэлжил (Холбоо, Инженер, Хими зэрэг)- ийн бэлтгэлийг 24 цаг хэмээн тайланд тусгасан байна¹⁰⁸. Цэргийн чухал тусгай мэргэжлийг 24 цагийн хичээл сургалтаар эзэмшүүлэн I зэргийн бэлтгэл үүрэгтэн болгож, цэргийн мэргэжил олгож байна.

Цэргийн насны болон дайчилгааны бэлтгэл нөөцийн бүрэлдэхүүнийг эрүүлжүүлэх, чадваржуулах, хууль эрх зүйн баримт бичгүүдэд заасны дагуу тэдний тайван цагийн сургалтын тогтолцоог шинэчлэх, сургалтыг тогтмолжуулан чанаржуулах, жилээс жилд хамрагдах хүний тоог нэмэгдүүлэх, орон нутгийн хамгаалалтын тогтолцоог бүрдүүлж, бэхжүүлэх үйл ажиллагаатай уялдуулан зохион байгуулбал үр дүнтэй байх болно.

Нийгмийн оролцоо ба цэргийн албаны тухайд: Монголд эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн дундаж наслалт эрс зөрүүтэй байгаа нь эрчүүдийн хорт зуршилтай холбоотой хэмээн Монгол эрчүүдийн хорт зуршлын хор хөнөөл судалгаанд үзсэн байна.¹⁰⁹ Сүүлийн жилүүдэд залуучуудын дунд нийгмийн амьдралд хандах хандлага, түүнийг харах өнцөг болон оролцох оролцоо муудсан. Эрэгтэйчүүдийн 40-ээс дээш насныхан ихэнхдээ ажилгүйдэлд өртсөн байдалтай байна. Үүнээс улбаалан сэтгэл гутралд орж архидан согтуурч, гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх нь ихсэх шалтгаан болж байна.

Цаашлаад, ажилгүйдлийн суурь шалтгаан нь тодорхой оршин суух хаяггүй, бичиг баримтгүйгээс болж хэрэг, зөрчилд их өртөж, үр дүнд нь ямар ч байгууллага ажилд авахгүй байна. Иймд залуучуудыг боловсролтой болгох, ажлын байрыг нэмэгдүүлэх, цалин орлогыг өсгөх гэх мэт зэрэг дорвитой ажлуудыг эхлүүлэх шаардлагатай аргуудын эхлэх хэрэгтэй байна.

Монгол Улсын Үндсэн хуулиар 18-25 насны эрэгтэйчүүд нэг жилийн хугацаат цэргийн албыг хаах ёстой. Цэргийн алба хаасан залуус төрийн жинхэнэ албанд орж

¹⁰⁸ “Оюутан цэрэг” хөтөлбөрийн тайлан. 2018.

¹⁰⁹ Наоми Китахара, А. Ариунзаяа. “Монгол эрчүүдийн хорт зуршлын хор хөнөөл” УБ., 2018

ажиллахаар хуульчилснаас хойш цэрэг татлагад хамрагдагчийн тоо харьцангуй өссөн ч сүүлийн хоёр жилд буурсан байна. Хөвсгөл аймагт 2017 оны II ээлжийн цэрэг татлагаар цэргийн насны 2246 иргэнд зарлан дуудах хүргүүлэхэд 1098 нь комисст бүртгүүлж цэргийн үзлэгт оржээ. Үндсэн хуульд заасан иргэний үүргээ гүйцэтгээгүй 1148 иргэн тус цэрэг татлагаас зугтсан байна. Харин үзлэгт орсон 1098 иргэнээс 268 нь эрүүл мэнд, 266 иргэн ар гэрийн гачигдал, 412 нь сурагч оюутан гэсэн шалтгаанаар хасагдаж, 38 залуу албанд тэнцжээ¹¹⁰. Өөрөөр хэлбэл зарлан дуудах авсан залуусын 1,7 хувь нь цэргийн жинхэнэ албанд татагдсан гэсэн үг. Нэг аймгийн төвийн хэмжээнд 38 хүн цэргийн жинхэнэ албанд татагдсан байна. Зарим мэдээллээр нэг сумаас ганцхан хүн цэрэгт татагдсан тохиолдол ч байна.

“Цэргийн албаны тухай” хуульд¹¹¹ Тайван цагт хугацаат цэргийн албанд татахаас чөлөөлөх 3 заалт, түр чөлөөлөх 4 заалттай. Тухайлбал, “эрүүл мэндийн байдлаар цэргийн албанд тэнцэхгүй болох нь нарийн мэргэжлийн эмч нарын үзлэгээр тогтоогдсон; цэргийн дүйцүүлэх алба хааж байгаа болон хаасан; эхнэр нь хөгжлийн бэрхшээлийн 1, 2 дугаар зэрэг тогтоолгосон бол чөлөөлөх заалттай. Харин “хууль ёсоор асран хамгаалах, харгалзан дэмжих өөр хүнгүй 16 хүртэлх насны төрсөн дүүтэй, эсхүл хөгжлийн бэрхшээлийн 1, 2 дугаар зэрэг тогтоолгосон төрсөн ах, эгч, дүүтэй; гэмт хэргийн улмаас хууль сахиулах байгууллагад шалгагдаж байгаа болон ял эдэлж байгаа иргэн; сургуулийн өмнөх насны хоёр буюу түүнээс дээш хүүхэдтэй хүнийг ээлжит цэрэг татлагаас түр чөлөөлөх заалттай юм.

Цэрэгт алба хаах иргэдийн тоог бууруулж байгаа гол хүчин зүйл залуусын бие бялдрын асуудал юм. Хөвсгөлд явагдсан цэрэг татлагын тоо баримтаас ч энэ нь тодорхой харагдаж байна.

Иймд ЕБС-д ордог биеийн тамирын хичээлийн чанар, үр өгөөжийг сайжруулах асуудал нэн түрүүнд яригдана. Мөн түүнчлэн сошиаль ертөнцийн соёлд залуус хэт автсанаас бие бялдраа хөгжүүлэх цагийг өөртөө гаргахаа байсан өнөө үед хүүхэд, залуусын чөлөөт цагаа өнгөрүүлэх соёл, амралтын хүрээлэнгийн үйл ажиллагааг өргөжүүлэх, олон нийтийн биеийн тамир спортыг хөгжүүлэх асуудалд төр ихээхэн анхаарал хандуулах цаг болсон байна.

Төрийн албаны тухай хуульд заасанчлан Төрийн жинхэнэ албан тушаалд тавих нийтлэг шаардлагын нэг нь “хуулийн дагуу цэргийн жинхэнэ алба хаах үүрэг хүлээсэн иргэн үүргээ биелүүлсэн байх”¹¹² явдал юм. Сонгуулийн тухай хуульд УИХ-

¹¹⁰ “2017 оны 2 ээлжийн цэрэг татлага боллоо”. <http://moron.khs.gov.mn/news/134/single/266>

¹¹¹ “Цэргийн албаны тухай хуулийн 16 дугаар зүйл.

¹¹² Төрийн албан тухай хуулийн шинэчилсэн найруулгын 22.1.6 дахь заалт

ын гишүүнд нэр дэвшихийн тулд “хугацаат цэргийн алба хаах насны иргэн Монгол Улсын хуулийн дагуу цэргийн жинхэнэ алба хаах үүргээ биелүүлсэн байх”¹¹³-ыг шаарддаг болсон.

Нийслэлийн 2018 оны ээлжит хугацаат цэрэг татлагад ажилласан нийслэлийн Эрүүл мэндийн газрын дарга Л.Төмөрбаатар “Зарлан дуудах хуудас авсан залуус хөдөлмөрлөж, сурах насандаа хууч, архаг ямар нэг өвчинтэйн улмаас цэргийн албанд тэнцэхгүй байна. Энэ нь маш харамсалтай. Иймд цэргийн насныхан гэлтгүй бүх хүн урьдчилан сэргийлэх шинжилгээнд тогтмол орж, ямар нэг өвчинтэй бол түүнийгээ эрт эмчлүүлэн, эрүүл мэнддээ анхаарах шаардлагатай” гэсэн. Цэргийн үзлэгт орсон залууст чих, хамар, хоолой, дотрын өвчин зонхилж байна. Түүнчлэн сүрьеэтэй, мэс засалд орсон иргэн цөөнгүй байгааг тэрбээр онцоллоо. 2018 оны I ээлжийн цэрэг татлагын үеэр эрүүл мэндийн үзлэгт хамрагдагсдын таван хувь нь жингийн дутагдалтай гэсэн шалтгаанаар цэрэгт тэнцээгүй байна. 2018 онд нийслэлийн хэмжээнд 30000 гаруй иргэнд зарлан дуудах хуудас хүргүүлсний 95.1 хувь нь эзэндээ хүрчээ. Гадаадад ажиллаж, амьдарч буй хүмүүс хэзээ, ямар хугацаагаар эх орноосоо гарснаа оршин сууж буй улсынхаа Хил хамгаалах байгууллагаар батлуулж, бичиг ирүүлбэл цэргийн албанаас түр хугацаагаар чөлөөлж болох гэнэ¹¹⁴.

Мөн цэрэгт тэнцэхгүй байгаа хүмүүсийн хэдэн хувь нь жинхэнэ эрүүл мэндийн шалтгаанаар, хэдэн хувь нь өөрсдийн цэрэгт явах хүсэл, сонирхолгүй байдлаасаа болж буй нь тодорхойгүй юм. Цэргийн албанд явахыг хүсэж байгаа боловч тэнцэхгүй байна уу, явахыг хүсэхгүй байгаа учраас уу гэдгийг судлах шаардлагатай байна.

Хүн ам зүйн болон батлан хамгаалах бодлогын нийгмийн арга хэмжээний уялдаа холбоог сайжруулах арга зам

Хүн амын хөгжлийн бодлого, төлөвлөлт нь олон салбарын бодлого, зохицуулалт шаардсан үндэсний хэмжээний хөгжлийн цөм асуудал юм.

Аливаа бодлогод улс орны буюу тухайн салбарын хөгжлийн ирээдүй, тулгамдсан асуудал, түүнийг хэрэгжүүлэх арга замыг оновчтой тодорхойлж, салбар хоорондын үйл ажиллагааны уялдаа холбоо, харилцан ажиллагааг зөв зохион байгуулж, хэрэгжилтэд тавих хяналтыг тогтмолжуулж, үр дүнг тодорхой хугацаанд гаргаж, цаашдын үйл ажиллагаагаа явуулах нь ач холбогдолтой, үр өгөөжтэй байдаг.

¹¹³ Сонгуулийн тухай хуулийн 26.4.3 дахь заалт

¹¹⁴ <http://unuudur.mn/>. Залуус эрүүл мэндээр тэнцэхгүй байна гэв. 2018.10.18

Хүн ам зүй, батлан хамгаалах бодлогын болон нийгмийн хөгжлийн гол цөм нь хүн юм. Тийм учраас батлан хамгаалах бодлогод хүн амын өсөлт, түүний бүтэц, боловсрол, эрүүл мэнд, бие бялдрын болон оюун санааны төлөвшлийг сайжруулах асуудлыг цогцоор авч үзэх шаардлагатай юм. Өөрөөр хэлбэл, төр, төрийн захиргааны төв, нутгийн захиргааны бүх шатны байгууллагуудын оролцоо, хамтын ажиллагаагаар хүн ам зүйн болон батлан хамгаалах бодлогын нийгмийн арга хэмжээний уялдаа холбоо сайжирч, үр дүнд хүрэх болно.

Хүн ам зүйн болон батлан хамгаалах бодлогын уялдаа холбооны асуудлыг энэхүү судалгааны ажлын 1.3-т тодорхойлон тусгасан.

Хүн амын, ялангуяа цэргийн алба хаах насны залуучуудын эрүүл мэндийн байдал, боловсрол, бие бялдрын хөгжилт нь улс орны аюулгүй байдлыг хангах, батлан хамгаалах хүчин чадлыг бэхжүүлэх, зэвсэгт хүчний байгуулалтын нэн чухал зорилт болох дайчилгааны нөөцийн чадавх, бэлэн байдлыг хангахад онцгой ач холбогдолтой.

Батлан хамгаалах бодлогын нийгмийн нэг чиглэл нь иргэдийн эрүүл мэндийн асуудал юм. Өнөөдрийн байдлаар цэргийн насны залуучуудын эрүүл мэнд нь нийгмийн хөгжлийн хэрэгцээ шаардлагаас хоцорсон хэвээр байна.

Тухайлбал, нийслэлийн ихэнх Цэргийн штабууд 2019 оны I ээлжийн цэрэг татлагад хамрагдсан залуучуудын эрүүл мэндийн байдлаас болж хяналтын тоогоо гүйцээгээгүй байна. Үүний гол шалтгаан нь нэгд, манай хүн амын түүний дотор цэргийн насны залуучуудын эрүүл мэндийн байдал хэр зэрэг байгаа, хоёрт, цэргийн албанд тэнцүүлэн татах заавар бодит байдалд нийцэж байна уу, үгүй юү гурв, төрийн түшээд /заавар боловсруулагч/-ийн мэдлэг чадвар, дадлага туршлага шаардлага хангаж байгаа эсэх зэрэгтэй холбоотой байж болох юм. Нөгөө талаар цэргийн насны залуучуудын эрүүл мэнд, түүнд нөлөөлөгч хүчин зүйлсийн талаар нарийвчилсан судалгаа, мэдээлэл хангалтгүй байна. Иймд цэргийн насны залуучуудын эрүүл мэндийг дэмжих, зохист түвшинд байлгах, тэдэнд үзүүлэх эрүүл мэндийн болон эмнэлгийн тусламж үйлчилгээний хүртээмж, чанарыг дээшлүүлэх замаар сайжруулах, залуучуудад эрүүл мэнд амьдралын ээлтэй нөхцлийг бүрдүүлэхэд анхаарах шаардлагатай байгаа нь судалгаанаас харагдаж байна.

Судалгааны ажлын 2.2 дугаар зүйлд хийсэн шинжилгээнээс харахад жилд 45-60 насны 3500 орчим бэлтгэл үүрэгтэн нас барж байгаа нь орон нутгийн хамгаалалтад суурилсан батлан хамгаалах бодлогыг хэрэгжүүлэхэд сөрөг үр дагаварт хүргэж байна. Иймд Эрүүл мэндийн яам болон Батлан хамгаалах яамдууд

бодлогын хүрээнд хамтран дээрх насны эрчүүдийг эрүүлжүүлэх ажлыг тогтмол хийж, хэвшүүлэх шаардлагатай байна.

Цаг уурын дулааралтай холбоотой ган зуд, хөрсний эвдрэл сүйрэл, цөлжилт, хуурайшилт, хүн малын элдэв халдварт өвчин, эмгэг зэрэг объектив хүчин зүйлээс гадна хүний үйл ажиллагаатай шууд холбоо бүхий хариуцлагагүй уул уурхай, шилжилт хөдөлгөөн, ажилгүйдэл, ядуурал, хөрөнгө санхүүгийн эх үүсвэрийн оновчтой бус хуваарилалт, зарцуулалт, удирдлага, менежмент, сэтгэлгээ, арга барилын хоцрогдол зэрэг нь хүний хөгжил, хүн амын эрүүл мэнд, боловсролын ерөнхий төлөв байдлыг сайжруулах, эрүүл мэнд, боловсролын үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэхэд ноцтой саад бэрхшээл учруулж байна.

Монголын залуучуудын бие бялдын хөгжилд нөлөөлж буй дээр дурьдсан байгаль, нийгмийн хүчин зүйлүүдийн тухай шинжлэх ухааны онол, арга зүйн нарийн үндэслэл бүхий судалгааг тодорхой хугацаанд хийж байх нь хүн ам, залуу үеийнхний эрүүл мэндийг хамгаалах, бие бялдын өв тэгш хөгжил, боловсролын талаарх төр, засгийн зорилго, зорилттой уялдуулан бодлогыг оновчтой тодорхойлоход шинжлэх ухааны нэг үндэслэл нь болно гэж үзэж байна.

2000 оноос 2018 он хүртэл цэргийн албанд татагдан ирж буй залуучуудын 40 гаруй хувь нь эрүүл мэнд, бие бялдын байдлаар цэргийн албанд тэнцэхгүй, 20 гаруй (боловсролгүй-1,52, бага-4,04, суурь-15,29) хувь нь боловсролгүй, бага, суурь боловсролтой байгаа бөгөөд энэ үзүүлэлт буурахгүй, үзлэгээр илэрсэн өвчин эмгэгийг илааршуулах талаар тодорхой арга хэмжээ авахгүй байгаа нь үүний нэг нотолгоо болно.

“Батлан хамгаалах бодлогын үндэс” баримт бичигт “Бүс нутгийг хөгжүүлэх, хүн амыг амьдрах нөхцөл, суурьшлын бүс, дэд бүтэц бий болгох, боловсрол, соёл, иргэдийн эрүүл мэндийг хамгаалах эдийн засаг, нийгмийн цогц бодлогыг хэрэгжүүлнэ ¹¹⁵” хэмээн заасан боловч хэрэгжилт хангалтгүй байна. Үүний шалтгааныг дээр цухас дурьдсан болно.

Судалгаанаас харахад хот, хөдөө, бүс нутагт залуучууд, өсвөр үеийнхний чөлөөт цагийг үр ашигтай өнгөрүүлэх, бие бялдар, эрүүл мэнд, боловсрол мэдлэгээ дээшлүүлэх нөхцөл жигд бүрдээгүй байгаа нь ажиглагдаж байна. Үүнээс гадна үйлдвэр үйлчилгээний газар, байгууллагад ажил хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангах, ажиллагсдынхаа аюулгүй, эрүүл тохилог орчинд ажиллах нөхцөл бүрдүүлээгүйгээс, үйлдвэрийн осол зөрчлөөс болж эрүүл мэндээр хохирон, хөдөлмөрийн чадвараа алдах зөрчил нэмэгдэх хандлагатай байна.

¹¹⁵ Батлан хамгаалах бодлогын үндэс. 5 дугаар зүйлийн 5.2 дахь заалт

Хүн амын дунд, ялангуяа залуучуудад архидан согтуурах, мансуурах, хар тамхинд донтох (бүртгэлтэй насанд хүрсэн хүн-1100, хүүхэд-201¹¹⁶), сэтгэл гутралт автах, амиа егүүтгэх гаж үзэгдэл нэмэгдэх хандлагатай болж буй нь бүх нийтийн анхаарал татсан, аюултай үр дагавартай тул төр, засгийн бүх шатны удирдлага бодлого, үйл ажиллагаа, эрх зүйн зохицуулалтаа даруй өөрчлөн шинэчлэх шаардлагатай болсныг харуулж байна.

Мөн түүнчлэн “Залуучуудын бодлого” судалгааны тайланд залуучуудын эрүүл мэндийн байдал, чөлөөт цагаа өнгөрөөж буй хэв маяг нь тэдний боловсрол, нийгмийн байдал, ажил эрхлэлт, орлогын байдалтай шууд холбоотой бөгөөд уг асуудлыг цогц байдлаар авч үзэх нь илүү чухал болохыг, эрүүл мэндийн чиглэлийн албан болон албан бус тайланд эдгээр асуудлуудыг цогцоор авч үзсэн нь бага байна гэж тэмдэглэсэн нь залуучуудын эрүүл мэндийн байдалд анхаарал хандуулах нь чухал байгааг сануулсан хэрэг юм¹¹⁷.

Батлан хамгаалах бодлогын нийгмийн нэг чиглэл нь залуучуудын бие бялдрын бэлтгэлжилтийн асуудал юм. Аливаа улс орон өөрийгөө хамгаалж чадах чадварлаг Зэвсэгт хүчинтэй байх нь түүнд алба хааж буй бие бүрэлдэхүүний боловсрол, эрүүл мэндийн байдал, бие бялдрын хөгжлөөс ихээхэн хамааралтай байдаг. Зэвсэгт хүчний анги салбарууд нь зөвхөн мэргэжлийн өндөр бэлтгэлтэй төдийгүй эрүүл чийрэг бие бялдартай, сэтгэл зүйн хувьд зориг хатуужилтай бие бүрэлдэхүүнтэй байснаар сая тайван цагийн орон тоо, зохион байгуулалтаараа байлдааны болон тусгай үүрэг гүйцэтгэх чадвартай болох учиртай.

Бид мэргэжлийн, чадварлаг зэвсэгт хүчинтэй байх төрийн бодлогыг хэрэгжүүлэх хүрээнд хугацаат цэргийн албанд бие бялдрын хэвийн хөгжилтэй, суурь өвчингүй, тогтоосон хэмжээний оюуны чадамжтай, бүрэн бус дунд буюу түүнээс дээш боловсролтой цэргийн насны залуучуудыг тэнцүүлэн татдаг.

Цэргийн албанд татагдан ирж байгаа залуучуудын эрүүл мэнд, боловсролын байдал төдийлэн хангалтгүй байгаа нь сүүлийн жилүүдийн судалгаанаас харагдаж байна.

Судалгаанд хамрагдсан цэргийн насны залуучуудын 33,8 нь бие бялдрын хөгжил, бэлтгэлжилтийн зохих түвшинд хүрэхгүй, 53,6 хувь нь дундчууд байна. Залуучуудын бие бялдрын хөгжил, бэлтгэлжилтийн эрчимтэй явагддаг үе нь 18-20 нас хүртэл байх бөгөөд цааш бууралт ажиглагдаж буй нь төр, засаг, нутгийн

¹¹⁶ Д.Энх-Амгалан. “Уламжлалт бус аюулын нийгэмд үзүүлэх нөлөөллийг бууруулах арга зам”. аюулгүй байдлын ухаанаар докторын зэрэг горилсон диссертац. ҮБХИС.2017

¹¹⁷ “Залуучуудын бодлого” судалгааны тойм Нээлттэй нийгэм форум. УБ., 2010 он.

захиргааны байгууллагаас залуучуудын эрүүл мэнд, бие бялдрын хөгжил, бэлтгэлжилтэд анхаарах шаардлагатай болж буйг нотолж байна.

Мөн залуучуудын бие бялдрын өсөлт хөгжилтөд бусад олон хүчин зүйлүүд нөлөөлж байна. Нэгд, хүн амын амьдралын хэв маяг өөрчлөгдөж, 68 хувь нь хот суурин газруудад амьдрах болсон боловч хүн ам нь аюулгүй орчинд амьдарч, бие бялдраа хөгжүүлэх тийм нөхцөл бүрдээгүй байна. Хоёрт, биеийн тамир, спортын хичээлийн хөтөлбөр, орчин нөхцөл, өнөөгийн шаардлага, стандартад нийцэхгүй байгаагаас ЕБС-иудын сургалтын үр дүн 18-25 насны залуусын бие бялдрын хөгжил, чийрэгжилтийн түвшинд хангалттай эерэг нөлөө үзүүлж чадахгүй байна. Гуравт, манай хүн амын, түүний дотор цэргийн насны залуучуудын амьдралын нөхцөл, боломж хангалтгүй, боловсролын түвшин доогуур, ухамсарт үйл хөдлөл, бие бялдраа хөгжүүлэхийн ач холбогдлыг ойлгох чадвар хомс зэрэг шийдвэрлэгдээгүй олон хүчин зүйлүүд байна.

Батлан хамгаалах бодлогын нийгмийн нэг чиглэл нь боловсролын чанар байдал юм. Боловсролын үзүүлэлт батлан хамгаалах хүний нөөцийн үндсэн үзүүлэлт юм. Бүх шатны боловсролын байгууллагад суралцагсдын тооноос харахад бага болон дунд ангид суралцагсдын хувьд эрэгтэй суралцагсад илүү байгаа бол ахлах ангид суралцагсдын хувьд эмэгтэй суралцагсад илүү байна. Харин МСҮТ-д суралцаж буй эрэгтэйчүүдийн тоо эмэгтэйгээс 1.5 дахин их, харин их, дээд сургууль, коллежид суралцаж буй эмэгтэйчүүдийн тоо эрэгтэйгээс 1.5 дахин их байна.

Боловсролын байгууллагад суралцагсдын тоо болон жил бүрийн төгсөгчдийн тоо, хүйсээс харахад 2010 оны тооллогоос хойш эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн боловсролын түвшний ялгаа улам нэмэгдсэн байх магадлалтай байна.

2018-2019 оны хичээлийн жилд 29,152 хүүхэд сургуульд суралцахгүй байгаа ба үүнээс эрэгтэй 56 хувь, эмэгтэй хүүхэд 44 хувь байна. Сургуульд суралцахгүй байгаа эрэгтэй хүүхдийн тоо эмэгтэйгээс 1.3 дахин их байна.

Эрэгтэйчүүдийн хувьд дээд боловсрол эзэмшсэн хүн амын тоо эмэгтэйчүүдийнхээс 78.0 мянган хүнээр цөөн байгаа бөгөөд нийт эрэгтэй хүн амын 27,1 хувь нь боловсролгүй, 12.1 хувь нь бага, 16.2 хувь нь суурь, 25.4 хувь нь бүрэн дунд, 5.5 хувь нь тусгай дунд, 13.8 хувь нь дээд боловсрол эзэмшжээ¹¹⁸.

Энэхүү судалгаанаас харахад манай эрэгтэйчүүдийн бараг 55.4 хувь нь боловсролгүй, бага болон суурь боловсролтой байгаа нь цэргийн хэрэгт нэвтэрч

¹¹⁸ Боловсролын салбарын өнөөгийн байдал, ҮСХ. 2018

буй орчин үеийн техник, хэрэгслийг судалж, эзэмшин, хүчин чадлыг бүрэн ашиглаж үүрэг гүйцэтгэхэд сөрөг нөлөөтэй байна. Иймд өсвөр үеийнхэн болон 25 хүртлэх насны залуучуудыг бүрэн дунд, тусгай дунд, дээд боловсрол эзэмшүүлэхэд боловсролын байгууллагатай хамтран ажиллах шаардлагатай байна. Их, дээд сургуулийн оюутнуудаас цэргийн албанд татагдаж, алба хаагаад эргэн сургуульдаа ороход алба хаасан хугацааны төлбөрийг эргүүлэн өгдөггүй, эргээд сургуульдаа ороход нь өмнө төлсөн мөнгийг нөхөн тооцдоггүй, цэргийн алба хааснаар тухайн оюутан хохирох явдал байгаад Батлан хамгаалах яам болон Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам анхаарч, эрх зүйн хүрээнд зохицуулах шаардлагатай байна.

Улс орны батлан хамгаалах тогтолцооны нэг чухал бүрэлдэхүүн болох дайчилгааны бэлтгэл нөөцийн бэлэн байдлыг хангах, бүрдүүлэх нэг гол нөхцөл болсон хүн амын, түүний дотор цэргийн насны залуучуудын эрүүл мэнд, бие бялдрын болон боловсролын байдал, тэдгээрт нөлөөлж буй эерэг, сөрөг хүчин зүйлүүдийн өөрчлөлт хөгжилтийн талаар нарийвчилсан судалгааг Батлан хамгаалах яам санаачлан, төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны бүх шатны болон хувийн хэвшлийн холбогдох байгууллагуудтай хамтран зохион байгуулж, судалгааны үр дүнд дүгнэлт хийж, цаашдын бодлого, ажил, арга хэмжээгээ тодорхойлж, хэтийн хараа, шинжлэх ухааны үндэслэлтэй, залгамж чанартай нэгдсэн төлөвлөгөөтэйгээр авч хэрэгжүүлбэл ач холбогдолтой юм.

Батлан хамгаалах бодлогын нийгмийн нэг чиглэл нь хүн амын байршлын асуудал юм. Өөрөөр хэлбэл, батлан хамгаалах тогтолцоо орон нутгийн хамгаалалтад суурилна гэдэг нь эх орон, газар нутгаа орон нутгийн засаг захиргаа, ард иргэд өөрсдөө хамгаалах тухай асуудал юм. Иймээс хүн амын суурьшил, шилжилт хөдөлгөөнийг зохистой түвшинд байлгах нь тулгамдсан асуудлуудын нэг болоод байна.

Манай улсын нийт суурин хүн амын 68 хувь нь нийслэл, аймгийн төв, тосгонд оршин сууж байгаа бол 32 хувь нь сумын төв, хөдөөд оршин сууж байна. Хүн амын суурьшлыг бүсээр ангилж үзэхэд нийт хүн амын 46 хувь нь Улаанбаатарт, 18.7 хувь нь Хангайн бүсэд, 15.9 хувь нь Төвийн бүсэд, 12.6 хувь нь Баруун бүсэд, 6.8 хувь нь Зүүн бүсэд оршин сууж байна¹¹⁹.

Хилийн бүсийн дагуух аймгуудын хүн амын нягтрал багасаж, нутаг дэвсгэр эзэнгүйдэж байгаа талаар 2.1 болон 2.2 дугаар зүйлд бичсэн судалгааны ажлын

¹¹⁹ http://www.1212.mn/tables.aspx?TBL_ID=DT_NSO_0300_040V1. Хүн амын шилжих хөдөлгөөн, аймаг, нийслэлээр

шинжилгээний дүнг төр засаг анхааралдаа авч хүн ам зүйн байршил, нутагшилтын талаар алсын хараатай бодлого боловсруулан баталгаажуулж хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Батлан хамгаалах бодлогын нийгмийн нэг чиглэл нь цэргийн насны залуучуудын хөдөлмөр эрхлэлтийн асуудал юм. 18-25 насны 13000 орчим залуучууд ажилгүй байна. Тэд амар хялбар аргаар мөнгө олох сонирхол их байдаг тул биед амар, цалин өндөртэй ажил хийх хүсэлтэй. Иймээс залуучуудыг хугацаат цэргийн алба хаах хугацаанд нь цэргийн мэргэжил эзэмшүүлэхээс гадна ажил хийх сонирхлыг нь өдөөж, мужаан, барилга зэрэг мэргэжил давхар эзэмшүүлэх боломжийг судлан хэрэгжүүлэх шаардлагатай байна. Мөн иргэдийг ажилд авахдаа хугацаат цэргийн алба хаасан бол эхний ээлжид хөдөлмөр эрхлүүлдэг зохицуулалтыг хуулийн хүрээнд шийдвэрлэх нь зүйтэй.

Хүн ам зүйн болон батлан хамгаалах бодлогын нийгмийн арга хэмжээний уялдаа холбоог сайжруулахын тулд төрийн захиргааны төв байгууллагууд, ялангуяа Батлан хамгаалах яам, Сангийн яам, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам, Эрүүл мэндийн яам, нутгийн захиргааны болон аж ахуйн нэгж байгууллагуудтай залуучууд болон дайчилгааны бэлтгэл нөөцийн бүрэлдэхүүний эрүүл мэнд, бие бялдрын чийрэгжилт, боловсролыг дээшлүүлэх, хүн амын зохистой байршлын талаар судалгааны ажлын зөвлөмжид тусгасан.

Дүгнэлт

“Монгол Улсын хүн ам зүйн өнөөгийн байдал, түүний батлан хамгаалах бодлогын хэрэгжилтэд үзүүлж буй нөлөөллийн шинжилгээ, уялдаа холбоог сайжруулах арга зам” хэмээх хоёрдугаар бүлэгт Монгол Улсын хүн ам зүйн бодлого, үйл ажиллагааны өнөөгийн байдал болон Батлан хамгаалах бодлогын хэрэгжилтэд хүн ам зүйн өнөөгийн байдлын үзүүлж буй нөлөөлөлд шинжилгээ хийж, хүн ам зүйн болон батлан хамгаалах бодлогын нийгмийн арга хэмжээний уялдаа холбоог сайжруулах арга замын талаарх зөвлөмжийг тодорхойллоо.

Судалгааны үр дүнд дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

1. Монгол Улсын хүн амын нас, хүйсийн хүснэгтээс харахад 0-4 нас болон 15-29 насны хүн амын тоо 2016 оноос буурч байгаа бол бусад насны хүн амын тоо жил тутам өсөлттэй байна. Харин хүн амын нас хүйсийн суваргаас харахад дунд хэсгээрээ (25-34 нас) аажмаар өргөсөж байгаа нь 1980-1990 оны үед төрөлт өндөр байсантай; 10-19 насны бүлгийн хүн амын хэсгээр нарийсаж байгаа нь 1990-2000 оны үед төрөлт багассантай; 0-4 нас болон 5-9 насанд суваргын суурь өргөн болсон нь 2010 оноос төрөлтийн түвшин нэмэгдсэнийг илэрхийлж байна.

Манай улсын нийт хүн амд 0-14 насны хүүхэд болон 65 ба түүнээс дээш насныханы харьцааг харахад “залуу” бүтэцтэй байгаа хэдий ч сүүлийн жилүүдэд залуучуудын хүмүүсийн эзлэх хувь буурч, ахмад настануудын эзлэх хувь нэмэгдэж байгаа нь анхаарал татаж байна.

2. Судалгаанаас харахад сүүлийн жилүүдийн төрөлтийн тоо эрэгтэй хүүхдийнх эмэгтэйгээсээ 10000 гаруйгаар илүү байгаа нь эх орноо батлан хамгаалах цэрэг эрсийг бэлтгэх, батлан хамгаалах ашиг сонирхолд эерэг нөлөө үзүүлж, 2030 оноос батлан хамгаалах бодлого дахь хүн ам зүйн зохистой хөгжлийг бүрдүүлэх үндэстэй гэсэн дүгнэлтэд хүргэж байна.

3. Монгол Улсын хүн амын хүйсийн харьцааны хувьд эрэгтэйчүүд 49.2 хувь, эмэгтэйчүүд 50.8 хувь байдаг бол нас баралтын хувьд эрэгтэйчүүд 60.4 хувь, эмэгтэйчүүд 39.6 хувийг тус тус эзэлж, эрэгтэйчүүдийн 52.2 хувь нь, эмэгтэйчүүдийн 24 хувь нь хөдөлмөрийн насандаа нас барсан нь судалгаанаас харагдаж байна. Энэ нь эрчүүдийн амьдралын буруу хэв маяг, архи тамхины өндөр хэрэглээ болон эрсдэлт зан үйлд өртөх байдал зэрэгтэй холбоотой байна.

4. Нийгмийн хөгжлөө дагаад хот руу чиглэж байсан иргэдийн шилжилт хөдөлгөөн сүүлийн жилүүдэд бага зэрэг саарч, уул уурхай дагаад дэд бүтэц хөгжиж буй аймгууд руу чиглэсэн иргэдийн шилжилт нэмэгдээд байгаа нь судалгаанаас харагдаж байна. Хүн амын шилжилт хөдөлгөөнтэй холбоотойгоор хилийн бүсийн дагуух 5 аймгийн хүн амын нягтрал хэтэрхий бага, нутаг дэвсгэр эзэнгүйдэж байгаа нь Монгол Улсын батлан хамгаалах, аюулгүй байдалд ноцтой сөрөг үр дагавар бий болох магадлалыг үүсгэж байна.

5. Цэргийн албанд татагдан ирж байгаа залуучуудын дунд өвчлөл буурахгүй байгаа нь бага насандаа суурь өвчтэй болсон, бие бялдрын чийрэгжилт, ерөнхий хөгжил муу, энэ насны залуучууд өөрийн эрүүл мэндэд анхаарч, эрүүлжих талаар санаачилгагүй, нөгөө талаар цэргийн албанаас зайлсхийх, мөн ядуурал нэмэгдэж байгаатай холбоотой байна.

Батлан хамгаалах бодлогын нийгмийн нэг чиглэл нь иргэдийн эрүүл мэндийн асуудал учраас цэргийн насны залуучуудын эрүүл мэнд, өвчлөлийн үзүүлэлтийг нийт хүн амын эрүүл мэнд, өвчлөлийн үзүүлэлтүүдтэй харьцуулахад нилээд өндөр байна. Иймд цэргийн насны залуучуудын эрүүл мэндийг дэмжих, зохист түвшинд байлгах, тэдэнд үзүүлэх эрүүл мэндийн болон эмнэлгийн тусламж үйлчилгээний хүртээмж, чанарыг дээшлүүлэх шаардлагатай байгаа нь судалгаанаас харагдаж байна.

6. Судалгаанд хамрагдсан цэргийн насны залуучуудын 34 хувь нь бие бялдрын хөгжил, бэлтгэлжилтийн зохих түвшинд хүрээгүй, 54 хувь нь дунд, 12 хувь нь дөнгөж

хангаж байгаа нь залуучуудын эрүүл мэнд, бие бялдрын хөгжил, бэлтгэлжилтэд анхаарах шаардлагатай болж буйг нотолж байна. Иймээс ерөнхий боловсролын дунд сургуулийн биеийн тамир, спортын хичээлийн хөтөлбөрийг өнөөгийн шаардлага, стандартад нийцүүлэн шинэчилж мөрдөх цаг нь ирсэнийг судалгааны дүн харуулж байна. Батлан хамгаалах бодлогын нийгмийн нэг чиглэл нь иргэдийн тэр дундаа цэргийн насны залуучуудын бие бялдрын бэлтгэлжилтийн асуудал юм.

7. Судалгаанаас харахад эрэгтэйчүүдийн 55.4 хувь нь боловсролгүй, бага болон суурь боловсролтой байгаа нь цэргийн хэрэгт нэвтэрч буй орчин үеийн техник, хэрэгслийг судалж, эзэмшин, хүчин чадлыг бүрэн ашиглаж үүрэг гүйцэтгэхэд сөрөг нөлөөтэй байна. Иймд залуучуудыг боловсролтой, мэргэжилтэй болгоход төр засгаас анхаарах шаардлагатай байна. Их, дээд сургуулийн оюутан байх хугацаандаа цэргийн албанд татагдаад буцаад сургуульдаа үргэлжлүүлэн сурах тохиолдолд хичээл сургалт, төлбөрийн асуудлыг хэрхэн тооцох асуудлыг тусгайлан журам гаргаж зохицуулах шаардлагатай нь практикаас харагдаж байна.

8. Залуучуудыг хугацаат цэргийн алба хаах хугацаанд нь цэргийн мэргэжил эзэмшүүлэхээс гадна ажил хийх сонирхлыг нь өдөөж, мужаан, барилга зэрэг мэргэжил давхар эзэмшүүлэх боломжийг судлан хэрэгжүүлэхээс гадна хугацаат цэргийн алба хаасан иргэдийг эхний ээлжинд ажил авдаг зохицуулалтыг холбогдох хууль, дүрэм журмаар зохицуулж өгвөл иргэдийн цэрэг алба хаах хүсэл сонирхол эрс нэмэгдэх сайн талтай.

ЗӨВЛӨМЖ

Монгол Улсын хүн амын нас, хүйсний харьцаа, боловсрол, эрүүл мэнд, сургалт, бэлтгэлжилтийн асуудлыг судлан, батлан хамгаалах бодлогын хэрэгжилтэд үзүүлэх нөлөөллийг тодорхойлж, хүн ам зүйн болон батлан хамгаалах бодлогын нийгмийн арга хэмжээний уялдаа холбоог сайжруулах арга замын талаарх зөвлөмж боловсруулах зорилгоор уг судалгааны ажлыг гүйцэтгэлээ.

Судалгааны ажлын үр дүнгээр дараах зөвлөмжийг дэвшүүлж байна. Үүнд:

Нэгд. Улсын Их Хурал, Засгийн газарт хандсан зөвлөмж

1. Эрх зүйн баримт бичгүүдийг хүн ам, нийгмийн хөгжил дэвшил, батлан хамгаалах эрх ашигт нийцсэн тодорхой, харилцан хамааралтайгаар боловсруулах. Энэ нь хүн ам зүйн болон батлан хамгаалах бодлого харилцан уялдаатайгаар хэрэгжих боломжийг бүрдүүлж өгнө.

2. Хүн амын суурьшил, шилжилт хөдөлгөөнийг зохистой түвшинд барьж, хилийн бүсийн дагуух аймгуудын дэд бүтцийг хөгжүүлэх, тэнд хүн ажиллаж, амьдрах таатай орчинг бий болгох талаар төрийн бодлогод тусгайлан тусгах. Энэ нь орон нутгийн хөгжлийг дэмжих, орон нутгийн хамгаалалтыг бүрдүүлж бэхжүүлэх, хилийн дагуух аймгуудын хүн амын нягтралыг нэмэгдүүлэх ихээхэн ач холбогдолтой.

3. Цэргийн алба хаасан, цаашид сурч боловсрох сонирхолтой бүрэн дунд боловсролтой болон сурч байгаад цэрэгт татагдаж, цэргийн албыг нэр төртэй хаасан иргэдэд тодорхой хэмжээний хөнгөлөлт, урамшуулал үзүүлэх, цэргийн алба хаасан иргэнийг эхний ээлжинд ажилд авах асуудлыг хуулиар зохицуулах. Энэ нь залуучуудыг эх оронч үзэл хүмүүжилтэй, цэргийн албанд дур сонирхолтой болгоход тустай.

4. Ажиллах хүчний шингээлт сайтай ажлын байр бий болгохыг төрөөс бодлогоор дэмжиж хэрэгжүүлэх. Энэ нь нийт хүн амд хөдөлмөрийн насны хүн амын эзлэх хувь өндөр түвшинд байгаа өнөө үед эдийн засгийн үр өгөөжийг хөдөлмөрийн нөөцдөө зориулан ашиглах боломжтой юм.

5. Залуучууд, өсвөр үеийнхний эрүүл мэнд, боловсролын байдал, бие бялдрын хөгжлийн судалгааг олон улсын жишигт нийцсэн аргачлалаар 4 жил тутамд цогц байдлаар хийж, гарсан үр дүнд тулгуурлан авах арга хэмжээг Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлэх. Энэ нь судалгааны үр дүн амьдралд хэрэгжих боломжийг нэмэгдүүлнэ.

Хоёр. Төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллагуудад
хандсан зөвлөмж (БХЯ, БСШУСЯ, ЭМЯ)

1. Залуучуудын эрүүл мэндийн мэдлэгийг дээшлүүлж, өвчнөөс сэргийлэх, эрүүлжүүлэх арга хэмжээг сайжруулах, тэдний чөлөөт цагаа зүй зохистой өнгөрүүлэх, бие бялдраа хөгжүүлэх, чийрэгжүүлэх зорилгоор эмнэлэг, сэргээн засах төв, бялдаржуулах төв, усан бассейн, спортын ордон болон нийтийн биеийн тамирын зам, талбайг олноор байгуулах;

2. Хүүхэд залуучуудын (ирээдүйн эх орноо хамгаалагч цэрэг эрс) эрүүл мэнд, бие бялдрын хөгжил, бэлтгэлжилтэд онцгойлон анхаарч, боловсролын бүх шатны сургалтад заах биеийн тамирын хичээлийн хөтөлбөрт өөрчлөлт оруулж, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах;

3. Цэргийн насны залуучуудын эрүүл мэндийн байдлыг (эрүүл эмгэгийн заагийг) үнэлэх хурдавчилсан оношлогооны аргыг эрүүл мэндийн төвүүдэд нэвтрүүлэх арга хэмжээг үе шаттайгаар авч хэрэгжүүлэх;

4. Хүн амыг (Дайчилгааны бэлтгэл нөөцийн бүрэлдэхүүн)-ыг эрүүлжүүлэх ажлыг бодлогын баримт бичигт тусгаж, үе шаттайгаар хэрэгжүүлж, энэ ажилд төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагаа, уялдаа холбоог хангах, хариуцлагын тогтолцоог бүрдүүлэх, иргэний нийгмийн оролцоог нэмэгдүүлэх;

5. Цэрэг татлагын үеийн эмнэлэгийн үзлэгээр тодорхой эмгэг илэрсэн залуучуудыг эмчилж, эрүүлжүүлэх арга хэмжээг тухай бүр авах;

6. Залуучуудын эрүүл мэнд, ялангуяа 18-25 насны залуучуудын эрүүл мэнд, бие бялдрын өсөлт, хөгжлийн тухай мэдээллийн сан бүрдүүлж, шинэчилж байх;

7. Залуучуудын эрүүл мэндийн байдал, бие бялдрын өсөлт, хөгжилт, боловсролын түвшинд нөлөөлж буй хүчин зүйлийн нарийвчилсан судалгаа хийж, тэдний (18-25 нас) эрүүл мэндийн асуудалд 4 жил тутамд үнэлгээ хийж, цаашид авах арга хэмжээг төр, засгийн бодлогод тусгаж байх;

8. Хүний эрүүл мэндийг хамгаалах, бэхжүүлэхэд чиглэсэн эмнэлэг-урьдчилан сэргийлэх болон спорт-эрүүлжүүлэлтийн ажлын чанарыг үнэлэх стандарт боловсруулах;

9. Эрүүл аж төрөх ёсны (идэвхтэй хөдөлгөөн, зөв хооллолт, архи, тамхины хор гэх мэт) чиглэлээр залууст зориулж сургалтыг тодорхой үечлэлтэйгээр зохион байгуулж байх;

10. Залуучуудын эрүүл мэнд сэдвээр 4 жил тутамд улсын хэмжээний чуулган зохион байгуулж, төрийн болоод төрийн бус байгууллагын анхаарлыг хандуулах, бодлого зөвлөмж боловсруулах;

11. Дайчилгааны бэлтгэл үүрэгтнүүдийн нас баралтын байдалд шинжилгээ хийж, 45-60 насны эрчүүдийг эрүүлжүүлэх ажлыг тогтмол хийж, хэвшүүлэх;

12. Бүх шатны боловсролын байгууллагууд, ялангуяа ЕБС-иудад эх оронч үзэл, уламжлалт зан заншил, ёс зүйг төлөвшүүлэх, спорт, биеийн тамирыг хөгжүүлэх, бие хүн болж төлөвших таатай орчин бүрдүүлэх;

13. Хүн ам, залуучуудын дунд нийтийн биеийн тамир, спортыг хөгжүүлэх, ялангуяа хөдөөгийн залуучуудын амралт чөлөөт цагийг үр ашигтай өнгөрүүлж, өөрийгөө хөгжүүлэх нөхцөл бүрдүүлэхэд чиглэсэн тусгай бодлого боловсруулж, хэрэгжүүлэх;

15. Залуучуудын бие бялдрын хөгжил, бэлтгэлжилтийг сайжруулах талаарх сургалтыг тогтмол явуулах, энэ чиглэлийн сургагч багш- мэргэжилтэнг бэлтгэх;

16. ЭМЯ, БХЯ, БСШУСЯ, ЗХЖШ-ын удирдлага, холбогдох албан тушаалтнууд судалгааны үр дүнгээр санал болгож буй зөвлөмжийг хэрэглээнд оруулах арга хэмжээг үе шаттайгаар тодорхой хугацаанд хэрэгжүүлэх.

ТӨГСГӨЛ

Бидний гүйцэтгэсэн “Хүн ам зүйн байдал, түүний батлан хамгаалах бодлогыг хэрэгжүүлэхэд үзүүлэх нөлөөлөл” сэдэвт төслийн ажил нь Монголын хүн ам зүйн бодлогын хэрэгжилтийн байдлыг судалж, хүн амын өсөлт, нас баралт, нягтрал, эрүүл мэнд, боловсрол, хөдөлмөр эрхлэлт, шилжилт хөдөлгөөн зэрэг нь батлан хамгаалах бодлогыг хэрэгжүүлэхэд хэрхэн нөлөөлөх, хүн ам зүйн болон батлан хамгаалах бодлогын уялдаа холбоог сайжруулах арга замыг тодорхойлох, цаашид харилцан ажиллах чиглэлийг гаргахад чиглэгдсэн болно.

Энэхүү төслийн ажлыг хийснээр дараах гол үр дүнд хүрлээ. Үүнд:

- Монголын хүн ам зүйн болон хүн амын, ялангуяа залуучуудын эрүүл мэнд, боловсрол, үзэл бодлын төлөвшил, сурч боловсрох, хөдөлмөрлөх, дур сонирхол болон тэдгээрт нөлөөлж буй хүчин зүйлүүдэд дүгнэлт хийв.
- Хүн ам зүйн байршилд шилжилт хөдөлгөөн хэрхэн эерэг, сөрөг үр дагавар үзүүлж байгаа, тэр нь улс орны аюулгүй байдал, батлан хамгаалах асуудалд үзүүлэх нөлөөлөл ямар байгааг судлан, дүгнэлт өгөв.
- Залуучууд, ялангуяа цэргийн насны залуучуудын эрүүл мэнд (өвчлөл), боловсрол, бие бялдрын бэлтгэлжилт, хөдөлмөр эрхлэлтэд тулгамдаж буй асуудлыг судалж, цаашид анхаарах, хийж хэрэгжүүлэх ажлын талаарх саналыг тодорхойлов.
- Хүн ам зүйн болон батлан хамгаалах бодлогын уялдаа холбоог сайжруулах арга замын талаарх санал, зөвлөмжийг тодорхойлов.

Судалгааны үр дүнд дараах дүгнэлтүүдийг хийж байна.

1. Батлагдан гарч буй эрх зүйн баримт бичгүүд (батлан хамгаалахын, нийгмийн, хүн ам зүйн, эрүүл мэндийн, боловсролын гэх мэтчилэн) нь бодит байдлаас хөндий, тунхаглалын шинжтэй, уялдаа холбоо, залгамж чанар дутмаг, улс орны болон хүний хөгжлийн нэгдмэл ашиг сонирхлыг бүрэн илэрхийлж чадахгүй, зарим талаараа хүний эрхийг хязгаарласан, заалтууд нь хоёрдмол утгатай байгаагаас хэрэгжилт хангалтгүй байна.

Төрийн бодлого *нэгдүгээрт*, улс орон, хүн амынхаа хөгжил дэвшилд чиглэсэн, залгамж чанартай, *хоёрдугаарт*, түүний зорилго, зорилт нь алс ирээдүйг харсан тодорхой, *гуравдугаарт*, авч хэрэгжүүлэх ажил арга хэмжээ, хүрэх үр дүн нь тодорхой байх аваас хэрэгжилт сайн байна.

2. Монгол Улсын тухайд нүүдлийн болон суурьшмал соёл иргэншил зэрэгцэн оршиж, хотжилт эрчимтэй явагдаж, хүн амын төвлөрөл бий болсноор монгол хүний аж төрөх арга, биеийн болон оюуны хүчний харьцаа өөрчлөгдөж буй зэрэг нь монгол

хүн, монголын залуучуудын эрүүл мэнд, боловсрол, бие бялдрын хөгжилд ихээхэн нөлөөлж байгаа нь судалгаанаас харагдаж байна. Үүн дээр хүн амын шилжилт хөдөлгөөнийг онцлон дурьдах ёстой.

3. Монгол хүн, монголын залуучуудын эрүүл мэнд, боловсрол, бие бялдрын хөгжилд нөлөөлж буй нийгмийн хүчин зүйлүүдийн талаар шинжлэх ухааны онол, арга зүйн нарийн үндэслэлтэй судалгааг тодорхой хугацаанд хийж байх нь хүн ам, залуу үеийнхний эрүүл мэндийг хамгаалах, бие бялдрын өв тэгш хөгжил, боловсролын талаар төрөөс баримтлах бодлогыг оновчтой болгоход шинжлэх ухааны нэг үндэслэл нь болно гэж үзэж байна.

4. Цэргийн насны залуучууд болон дайчилгааны бэлтгэл нөөцийн бүрэлдэхүүний тухайд насны бүтцээр нь авч үзвэл, ойрын 20-30 жилд хүний нөөцийн хомсдолгүй байх төлөвтэй хэдий ч Зэвсэгт хүчнийг дайчилгаагаар өргөтгөн зохион байгуулахад офицерийн бие бүрэлдэхүүний, түүний дотор тусгай мэргэжлийн офицерийн нөөцийн хомсдол бий болох хандлага ажиглагдаж байна.

Иймд бэлтгэл офицерийн нөөцийг нэмэгдүүлэхийн тулд их, дээд сургуулиудад сурч буй оюутнуудад үндсэн мэргэжлийг нь харгалзан, сургалтад хамруулан цэргийн мэргэжил эзэмшүүлэх асуудлыг холбогдох төрийн захиргааны төв байгууллагуудад тавьж их, дээд, тусгай мэргэжлийн сургуулиудад батлан хамгаалах-цэргийн тэнхим байгуулж, сургалтын хөтөлбөрт нэмэгдэл хичээл оруулах замаар шийдвэрлэж болох юм.

5. Залуучуудыг эрүүлжүүлэх, бие бялдрыг хөгжүүлэх, боловсролыг дээшлүүлэх үйл ажиллагааны үндсэн чиглэлийг 2020-2024 онд боловсруулж, хэрэгжүүлэх нь зүйтэй. Хэрэгжилтийг үндэсний түвшинд удирдан зохион байгуулах үйл ажиллагааг холбогдох төрийн захиргааны төв байгууллага, хэрэгжилтийг хангах ажлыг харьяа газруудад хариуцуулж, орон нутгийн түвшинд аймаг, нийслэлийн Засаг даргатай хамтран, үндсэн чиглэлийн хэрэгжилтийг хангаж ажиллавал илүү үр дүнд хүрнэ гэж үзэж байна.

6. Улс орны батлан хамгаалах тогтолцооны нэг чухал бүрэлдэхүүн болох дайчилгааны бэлтгэл нөөцийг бүрдүүлэх, бэлэн байдлыг хангах нэг гол нөхцөл нь залуучуудын (ялангуяа цэргийн насны) нас хүйсийн харьцаа, эрүүл мэнд, боловсрол, сургалт бэлтгэлжилтийн судалгаа юм. Иймд бидний гүйцэтгэсэн энэхүү судалгааны үр дүнгээр хийсэн дүгнэлтүүд, санал зөвлөмжийг цаашдын бодлого, төлөвлөлтийг оновчтой боловсруулахад чухал ач холбогдолтой гэж үзэж байна.

ЭШЛЭЛ АВСАН, АШИГЛАСАН БҮТЭЭЛИЙН ЖАГСААЛТ

1. Этиен Ванде Валле. Хүн ам зүйн олон хэлийн толь бичиг. Бельги., 1982
2. Хүн ам зүйн байдал, батлан хамгаалах асуудал. Судалгааны ажлын тайлан. БХЭШХ. 2010
3. Б.Наранчимэг. Хүн ам зүй ба хүн ам судлал. МУИС., 2011
4. Засгийн газрын 2016 оны 261 дүгээр тогтоол “Төрөөс хүн амын хөгжлийн талаар баримтлах бодлого”
5. Я.Бямбасүрэн, П.Доржсүрэн. “Төрийн бодлого”. УБ., 2006
6. Н. Батжаргал, “Эдийн засгийн хөгжил ба хүн амын өсөлт шилжилт хөдөлгөөн”, УБ. 2017
7. Өвөрхангай аймгийн хүн ам зүйн үзүүлэлтүүдийн өнөөгийн байдал. 2012
8. Ш.Насанбат. “Монголын түүхэнд тодорсон 33 цуут жанжин”. УБ., 2018
9. Иргэний бүртгэлийн түүхэн тойм.
<http://burtgel.gov.mn/index.php/about/history/80-civil>.
10. Хүн ам зүйн бодлогогүй Монгол Улс “Өвөг дээдсийн бодлогоос” Хөх толбо. 2013
11. ХХ зуунд Монгол улсын хүн ам өсөлт
<https://mongoltoli.mn/history/h/712>
12. “Хүн ам зүйн бодлого” төгсгөл, 6/6-р хэсэг 2017
13. “БНМАУ-ын хүн ам зүйн талаар баримтлах чиглэл”. БНМАУ-ын Ерөнхийлөгчийн 115 дугаар зарлиг
14. О.Үржин. “Аюулгүй байдлын онол, арга зүйн асуудалд”. Аюулгүй байдлын онол, практикийн тулгамдсан асуудал” сэдэвт эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл. 2016
15. Монгол Улсын батлан хамгаалах бодлогын үндэс. УИХ-ын 2015 оны 85 дугаар тогтоол.
16. Б.Равжаа. “Батлан хамгаалах бодлого, үйл ажиллагааг боловсронгуй болгох зарим асуудал” Батлан хамгаалах бодлого эмхэтгэл. УБ., 2015
17. Батлан хамгаалах тухай хууль
18. “Батлан хамгаалах стратеги” онол, арга зүй, шинжилгээний бүтээл. БХЭШХ. УБ., 2017
19. Орон нутгийн хамгаалалтын тухай хууль
20. Ц.Дашзэвэг. Батлан хамгаалах бодлого, зэвсэгт хүчний байгуулалт, удирдлагын шинэчлэл. УБ., 2019

21. Зэвсэгт хүчний тухай хууль.
22. Дайчилгааны тухай хууль
23. Б.Эрдэнэчимэг. “Монгол Улсын тусгаар тогтнолыг бэхжүүлэх талаарх батлан хамгаалах бодлогын чиг хандлага”. Монгол Улсын тусгаар тогтнол ба батлан хамгаалах бодлого сэдэвт эрдэм шинжилгээний хурал. МУЕТГ. 2016.
24. “Монголын залуучуудын бие бялдрын хөгжлийн судалгаа”. БХЭШХ. 2016
25. Монгол Улсын төрөөс хүн амын хөгжлийн талаар баримтлах бодлого. ЗГ-ын 2016 оны 261 тогтоол
26. “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”. УИХ-ын 2016 оны 19 дүгээр тогтоол.
27. Наоми Китахара, А. Ариунзаяа. “Монгол эрчүүдийн хорт зуршлын хор хөнөөл” УБ., 2018
28. “Жендэрийн эрх тэгш байдлыг хангах үндэсний шинэ хөтөлбөр”. Засгийн газрын 2017 оны 129 дүгээр тогтоол
29. Салбаруудын жендэрийн бодлогын эмхэтгэл. ХНХЯ, Жендэрийн Үндэсний хороо, Азийн хөгжлийн банк. УБ., 2018
30. Эрүүл мэндийн үзүүлэлт-2018. ДЭМБ, Эрүүл мэндийн төв. УБ., 2019
31. Монгол Улсын хүн амын тоо, насны бүлэг хүйсээр. Статистикийн мэдээллийн нэгдсэн сан. http://www.1212.mn/tables.aspx?TBL_ID=DT_NSO_0300_003V1
32. Эрүүл мэндийн үзүүлэлт-2018. ДЭМБ, Эрүүл мэндийн төв. УБ., 2019
33. Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хууль. УБ., 1993
34. Монгол Улсын хүн амын тоо, хүйсээр. 1212.мн
35. Монгол Улсын жендэрийн нөхцөл байдлын дүн шинжилгээ: 2005 оноос өнөөг хүртэлх ололт ба сургамж, 2019
36. Эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн дундаж наслалтын зөрүү, түүнд нөлөөлж буй хүчин зүйлс. МУЗГ, ДБ. 2019
37. “Хүн амын статистикийн үзүүлэлт тооцоолох аргачлал”. ҮСХ-ны даргын 2013 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 1/149 дугаар тушаалын хавсралт.
38. Төрөлтийн тоо, хүйсээр.
http://www.1212.mn/tables.aspx?TBL_ID=DT_NSO_0300_013V1
39. Монгол Улс. “Нийгмийн үзүүлэлтийн түүвэр судалгаа-2018”. Нэгдсэн тайлан. ҮСХ, НҮБ-ын Хүн амын Сан., 2019.
40. Монгол Улсын Үндсэн хууль. УБ., 1992 он.
41. “Эрэгтэйчүүдийн эрүүл мэндийн стратеги”. Эрүүл мэндийн сайдын 2014 оны 84 дүгээр тушаал.

- 42.Халдварт бус өвчлөл, осол гэмтлийн шалтгаан, эрсдэлт хүчин зүйлсийн тархалтын судалгаа 2013 он, ДЭМБ, НЭМҮТ, МСС, ЭМЯ
- 43.Зам тээврийн ослын өнөөгийн байдал, ҮСХ. 2018
- 44.Б.Сарангэрэл. “Эрүүл мэндийн салбарт тулгамдаж буй асуудал”. МҮОНТ-д өгсөн ярилцлага. 2019 оны 6 сар
- 45.Хөдөлмөр эрхлэлт, ажилгүйдэл. Статистикийн мэдээллийн нэгдсэн сан.
http://www.1212.mn/stat.aspx?LIST_ID=976_L04&type=tables
- 46.Цэргийн албаны тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.6 дахь заалт
- 47.“Оюутан цэрэг” хөтөлбөрийн тайлан. 2018.
- 48.“2017 оны 2 ээлжийн цэрэг татлага боллоо”.
<http://moron.khs.gov.mn/news/134/single/266>
- 49.Төрийн албан тухай хуулийн шинэчилсэн найруулга
- 50.Сонгуулийн тухай хуулийн 26.4.3 дахь заалт
- 51.Залуус эрүүл мэндээр тэнцэхгүй байна. <http://unuudur.mn/>. 2018.10.18
- 52.Д.Энх-Амгалан. “Уламжлалт бус аюулын нийгэмд үзүүлэх нөлөөллийг бууруулах арга зам”. аюулгүй байдлын ухаанаар докторын зэрэг горилсон диссертац. ҮБХИС.2017
- 53.“Залуучуудын бодлого” судалгааны тойм Нээлттэй нийгэм форум. УБ., 2010 он.
- 54.Боловсролын салбарын өнөөгийн байдал, ҮСХ. 2018
- 55.Хүн амын шилжих хөдөлгөөн, аймаг, нийслэлээр
http://www.1212.mn/tables.aspx?TBL_ID=DT_NSO_0300_040V1.